

# Лицлэл

A black and white portrait of Joseph Fielding Smith, a man with short, dark hair, wearing a dark suit jacket, a white shirt, and a light-colored tie. He is looking slightly to the right of the camera with a neutral expression.

**Жозеф Фийлдинг  
Смит: Итгэлээ  
хамгаалагч,  
32-р хуудас**

**Мексик дэх сүм—Арвин  
баялаг түүх, Гайхалтай  
ирээдүй, 24-р хуудас**

**Мючелийн 2014 оны уриа,  
50, 52, 53-р хуудсууд**

**Хуучин Гэрээний будах үйл  
ажиллагаа ба унших хүснэгт,  
74, 76-р хуудсууд**



*“Та нарын зарим нь амьдралын нөхцөл байдал дэндүү хэцүү, сорилт бэрхшээлүүд хэтэрхий хүнд, уруу таталтууд даанч их учраас өсч хөгжиж чадахгүй байна хэмээн бодож магадгүй. . . . Сараана цэцгийн иш тохьгүй орчинд ургадаг бөгөөд энэ иш нь цэцгээ өргөдгийн адил таны итгэл таныг өргөж дэмжих болно гэдгийг санаарай.”*

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх асан Мэри Н.Күк, “Гэрчлэлийн зангуу,” Лиакона, 2008 оны 5-р сар, 122-р хуудас.



## ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Мод тарих хамгийн тохиромжтой цаг  
Ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Үлгэр жишээ үзүүлэгч

## ОНЦЛОХ ӨГҮҮЛЛҮҮД

- 18** Ирээдүйд тохиолдох зүйлүүдэд итгэл найдвартайгаар бэлтгэх нь  
Ахлагч М.Рассэл Баллард  
*Бид итгэл үнэмшлээрээ амьдарч, ажиллан, Аврагчийн үйл хэрэгт амьдралаа зориулах ёстой.*
- 24** Газар бүрийн анхдагчид: Мексик—Тэмцлээс хүч чадалд хүрсэн нь  
Салли Жонсон Өүдкөрк  
*Мексикийн хожмын үеийн гэгээнтнүүд эх орондоо сүмийг байгуулахын төлөө агуу золиослол хийсэн юм.*
- 32** Үнэнч бөгөөд итгэлтэй: Жозеф Фийлдинг Смитийн амьдрал ба сургаалуудын сүнслэг нөлөө  
Бага Хоит В.Брэстэр  
*Бэйсбол тоглохдоо гаргууд бөгөөд элдэг сайхан зантай мөн Их Эзэнд итгэлтэйгээр үйлчилж байсан өнөө үеийн нэгэн бошиглогчтой танилчана уу.*

## АЛБАД

- 8** 2013 оны 10-р сарын чуулганы тэмдэглэл
- 10** Бид Христийн тухай ярьж байна: Харанхуйгаас гэрэл рүү  
Нэрийг нууцлав
- 12** Хуучин Гэрээний бошиглогчид: Адам
- 14** Сайн мэдээний сонгомол бүтээл: Тэнгэрлэг Бурхан Тэргүүтэн  
Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли
- 17** Залуучуудын бат бөх байдлын төлөө товхимлоос заах нь: Хүндэтгэлийн өдрийг сахих нь
- 38** Хожмын үеийн гэгээнтнүүдийн дуу хоолой
- 80** Биднийг дахин уулзтал: Тэр намайг харах болов уу?  
Тэрэса Старп

### ХАВТСАН ДЭЭР

Нүүрэн талд: Жозеф Фийлдинг Смит 1910 оны дөрөвдүгээр сарын 26-нд 33 настайдаа. Төлөөлөгчөөр томилогдсоных нь дараахан авсан гэрэл зураг, гэрэл зургийг Ларэнэ Портэр Гаунт



42

- 42 Тэвчээртэй даван туулах нь**  
Ахлагч Ж.Кристофер Лансинг  
*Бидний итгэл найдвар мөн хүсэл мөрөөдөл биелэгдэх боломжгүй болсон үед Их Эзэн биднийг юу хийгээсэй хэмээн хүсэн хүлээдэг вэ?*



**Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санамж: Судруудыг шалга!**

46



- 46 Ирээдүйн гэр бүлдээ бэлэг бэлтгэх нь**  
Ерөнхийлөгч Хэнри Б.Айринг  
*Та ирээдүйн гэр бүлээ адислахын тулд ямар бэлгүүдийг одоо хөгжүүлж болох вэ?*

- 50 Мючелийн 2014 оны уриа**  
*"Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржисгтүн, мөн бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун"*

- 52 Шат шатаар: Моронай 10:32**  
*Мючелийн энэ жилийн уриа төгөлдөржилтөд хүрэх замын талаар та нарт заах болно.*

- 53 Зурагт хуудас: Христэд ирэгтүн**

- 54 Бурхан Тэргүүтэнийг мэдэх нь намайг хэрхэн өөрчлөх вэ?**  
Лори Фүллэр  
*Бурхан Тэргүүтэний тухай эдгээр таван зарчим нь том, жижиг аль нэг арга замаар таны амьдралын хэв маягийг өөрчилж чадна.*

- 56 Залуучуудын бат бөх байдлын төлөө: Би үргэлж түүнийг санадаг**  
Лари М.Гибсон  
*Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих нь гэрээнүүддээ чин үнэнч байгаа байдлыг тань харуулдаг.*

- 58 Амжилтаа ахиулах нь**  
Даниэл Кавай  
*Математикийн олимпиадад оролцогч нэгэн залуу эрэгтэй хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих уу эсвэл үүнд зохисгүй байх уу гэдгийн аль нэгийг сонгох хэрэгтэй болжээ.*

- 59 Нүдээ олсон хариулт**

- 60 Давхар адислал**  
Британи Бэтти  
*Бид гэр бүлийнхээ гишүүдийн нэрсийг судалж, тэдгээрийг ариун сүмд авч очсоноор нэмэлт адисламуд авч чадна.*

- 64 Бидний орон зай**



72

- 66 Дэлхий даяарх найзууд: Мексикийн Махонри, Хиламан хоёр**

- 68 Онцгой гэрч: Христийн шашинтан байна гэдэг нь юу гэсэн үг вэ?**  
Ахлагч Роберт Д.Хэйлс

- 69 Дэлхий даяарх найзууд: Паспорт**

- 71 Бидний хуудас**

- 72 Яг л судрууд шиг!**  
Рэнэ Вэйт Майкли  
*Судрууд үнэхээр миний амьдрал шиг байж чадна!*

- 74 Хуучин Гэрээний судрын уриалга**

- 77 Ялалтын хаалга**  
Рөүзмэри М.Виксом  
*Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очих замыг хэн танд үзүүлж чадах вэ?*

- 78 Хүүхдийн хэсгийг гэртээ авчрах нь: Түүнд эргэж очих замыг Тэнгэрлэг Эцэг минь надад бэлтгэсэн юм**

- 81 Бошиглогчийн хөрөг: Харолд Б.Лий**

## 2014 ОНЫ НЭГДҮГЭЭР САРЫН ДУГААР 15 NO. 1 ЛИАХОНА 10981 363

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн  
Сүмийн олон улсын сэтгүүл

**Тэргүүн Зөвлөл:** Томас С.Монсон, Хэнри Б.Айринг,  
Дийтр Ф.Угдорф

**Арванхоёр Төлөөлөгчийн чуулга:** Боид К.Пакэр,  
Л.Том Пэрри, Рассэл М.Нэлсон, Даллин Х.Өүкс,  
М.Рассэл Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хэйлс,  
Жэффри Р.Холланд, Дэвид А.Бэднар, Квинтин Л.Кук,  
Д.Тодд Кристоффэрсон, Нийл Л.Андэрсэн

**Эрхлэгч:** Крэйг А.Кардон

**Зөвлөхүүд:** Хосе Л.Алонсо, Мэрвин М.Арнольд, Шэйн  
М.Бөүэн, Стэнли Г.Эллис. Бага Кристоффэл Голдэн

**Удирдах захирал:** Дэвид Т.Варнэр

**Гэр бүл болон гишүүдийн тусламжийн захирал:**  
Винсэнт А.Ваун

**Сүмийн сэтгүүлийн захирал:** Алан Р.Лоиборг

**Бизнесийн менежер:** Гарфф Каннон

**Гүйцэтгэх редактор:** Р.Вал Жонсон

**Гүйцэтгэх захирлын туслах:** Раян Карп

**Редакцийн баг:** Сюзан Баррэт, Бригитани Бийти, Дэвид  
Диксон, Дэвид А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Минди Рая  
Фрийдман, Лори Фүллэр, Гаррэт Х.Гарфф, Ларин Портер  
Гаунт, Жэнифэр Грэйс Жөүнс, Майкл Р.Моррис, Салли  
Жонсон Одажэрк, Жошуа Ж.Пэркий, Жан Пинбороу,  
Ричард М.Ромни, Пол Вандэнбэрг, Марисса Виддисон

**Зураглал чимэглэлийн удирдагч менежер:**

Ж.Скотт Кнудсэн

**Зураглал чимэглэлийн удирдагч:** Тадд Р.Петрсон

**Уран бүтээлийн ажилтнууд:** Жанэтт Эндрьюс, Фэй  
П.Андрус, С.Кимбалл Ботт, Том Чайлд, Нэйт Гайнс, Коллийн  
Хинкли, Эрик П.Жонсэн, Сюзан Лодфрэн, Скотт М.Моой,  
Марк В.Робисон, Брад Тизери, П.Никол Вокэюрст

**Оюуны өмчийн зохицуулагч:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэлийн захирал:** Жэйн Анн Пэтэрс

**Хэвлэх баг:** Кэвин К.Банкс, Конни Бөүгторп Бриж, Жүүли  
Бурдэтт, Браян У.Гиги, Дэнис Көрби, Жинни Ж.Нилсон,  
Гэйл Тэйт Раффэрти

**Хэвлэлийн захирал:** Крэйг К.Сэдвик

**Хуваарилалт хариуцсан захирал:** Эван Ларсэн, Нэгдсэн  
Улс, Канадаас бусад орнууд дахь захиалагч болон үнийн  
талаар орон нутгийн сүмийн хангамжийн төв болон тойрог,  
салбарынхаа удирдагчтай холбоо барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернэт вэбсайт**

liahona.lds.org руу; шуудангаар *Liahona*, Rm. 2420,  
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024, USA  
хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch.org хаягаар  
ирүүлнэ үү.

*Лиэхона* нь (Мормоны Номон дахь уггаараа бол "луужин"  
буюу "залагч") албани, англи, армен, бислам, болгар,  
вьетнам, гаити, герман, грек, дани, индонез, ирланд, испани,  
итали, камбож, кирибати, латви, литва, малагаш, маршалл,  
монгол, нидерланд, норвеги, орос, польш, португали, румын,  
свахили, самоа, себуано, солонгос, тагалог, тай, тахити,  
тонга, украин, унгар, урду, фижи, фин, франц, хорват,  
хятад, хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр  
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд өөр  
байна.)

© 2014 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх хамгаалагдсан.  
Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.

*Лиэхона* дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой  
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон гэрт  
ашиглахын тулд хувилж болно. Урлагийн бүтээлийг  
хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг хувиан олшруулж  
болохгүй. Зохиогчийн эрхийн талаарх асуултаа Intellectual  
Property Office, 50 E. North Temple St., Salt Lake City,  
UT 84150, USA хаягаар; эсвэл электрон шуудангийн:  
cor-intellectualproperty@ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

**For Readers in the United States and Canada:**  
January 2014 Vol. 15 No. 1. LIAHONA (USPS 311-480)  
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a year  
(January, April, June, July, October, and December) by  
The Church of Jesus Christ of Latter-day Saints, 50 E. North  
Temple St., Salt Lake City, UT 84150. USA subscription price is  
\$5.00 per year; Canada, \$6.00 plus applicable taxes. Periodicals  
Postage Paid at Salt Lake City, Utah. Sixty days' notice required  
for change of address. Include address label from a recent issue;  
old and new address *must* be included. Send USA and Canadian  
subscriptions to Salt Lake Distribution Center at address below.  
Subscription help line: 1-800-537-5971. Credit card orders  
(Visa, MasterCard, American Express) may be taken by phone.  
(Canada Poste Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send all UAA to CFS (see DMM 707.4.12.5).  
NONPOSTAL AND MILITARY FACILITIES: Send address changes to  
Distribution Services, Church Magazines, P.O. Box 26368,  
Salt Lake City, UT 84126-0368, USA.

# Гэр бүлийн үдшийн санаанууд

Энэ дугаарт гэр бүлийн үдшээр ашиглаж болох өгүүлүүд болон үйл ажиллагаанууд  
багтсан. Дор хоёр жишээ өгөв.



ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ КОДИ БЭЛЭГ

## "Ирээдүйн гэр бүлдээ бэлэг бэлт- гэх нь," 46-р хуудас: Ерөнхийлөгч

Айрингийн өгүүлийг уншсаны дараа  
эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ авьяасаа  
хуваалцах гэр бүлийн авьяасын үзүүлбэр  
зохион байгуулах талаар бодно уу. Хүн  
бүрийг авьяасаа үзүүлсний дараа тэдний  
авьяас гэр бүлийг нь хэрхэн адисалж  
болох арга замуудын талаар эцэг эх  
нь тайлбарлаж өгч болно. Дараа нь  
хүүхдүүдийн авьяас гэр бүлийг нь хэрхэн  
адисалж байгаа болон хэзээ нэг өдөр энэ  
нь тэдний ирээдүйн гэр бүлийг хэрхэн  
адислах талаар хуваалцахад хүүхдүүдээ  
урьж болно. Авьяасаа цаашид хөгжүүлэх

зорилго тавихад нь эцэг эхчүүд хүүхдүү-  
дээ урамшуулан дэмжиж болно.

## "Хуучин Гэрээний судрын уриалга,"

74-р хуудас: Хуучин Гэрээг гэр бүлээ-  
рээ унших зорилго тавьж, ажиллах  
талаар бодож үзнэ үү. Та өсөлт хөгж-  
лөө тэмдэглэхийн тулд тус сэтгүүлээс  
өнгөтэй хүснэгтийг салган авах юм уу  
liahona.lds.org-оос хэвлэн авч болно.  
Санал болгосон судруудыг гэр бүлээрээ  
уншиж, ярилцан; энэ жилдээ долоо хоног  
бүр уншиж, дуусгах зорилготой төлөвлөгөө  
гарган, ажиллахад анхаарна уу.

## ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

*Лиэхона* болон сүмийн бусад материалуудыг [languages.lds.org](http://languages.lds.org) дээрээс олон хэлээр  
үзэх боломжтой.

## ЭНЭ ДУГААРЫН СЭДВҮҮД

*Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг заана.*

**Авралын төлөвлөгөө, 78**

**Адамын уналт, 12**

**Амар амгалан, 41**

**Анхдагчид, 24**

**Ариун Сүнс, 14, 40, 54,  
64, 81**

**Ариун сүмүүд, 24, 39, 60  
Бардамнал, 10**

**Бурхан Тэргүүтэн, 14, 54**

**Гэр бүл, 46, 60, 64**

**Гэр бүлийн түүх, 60, 64**

**Гэрчлэл, 64**

**Гэрээнүүд, 56, 58**

**Даруу байдал, 10**

**Есүс Христ, 7, 14, 50, 52,  
54, 56, 68**

**Залбирал, 64**

**Зорилгууд, 4, 18, 46**

**Итгэл, 18**

**Лий, Харолд Б., 81**

**Мексик, 24, 39, 66  
Мормоны Ном, 38**

**Мючелийн уриа, 50,  
52, 53**

**Мөнх бус байдал, 12,  
42, 78**

**Найдвар, 18**

**Наманчлал, 4, 10, 46**

**Номлолын ажил, 38, 59**

**Смит, Жозеф Фийлдинг,  
32**

**Сорилтууд, 42**

**Тэнгэрлэг Эцэг, 14, 54,  
77, 78, 80**

**Тэсвэр хатуужилтай,  
42, 72**

**Төгөлдөржилт, 50, 52  
Хоёр дахь ирэлт, 18**

**Христийн шашинтан,  
40, 68**

**Хуучин Гэрээ, 12, 74  
Хүндэтгэлийн өдөр,  
17, 56, 58**

**Хүүхдүүдэд зориулав, 41  
Хөгжил цэцэглэлт, 18**

**Цагаатгал, 4, 10, 14, 54**

**Үйлчлэл, 40**

**Үлгэр жишээ, 7  
Өв, 24, 32**



**Ерөнхийлөгч  
Дийтр Ф.Угдорф**

Тэргүүн Зөвлөлийн  
хоёрдугаар зөвлөх

# Мод тарих

## ХАМГИЙН ТОХИРОМЖТОЙ ЦАГ

Эртний Ромд Жанус хэмээх эхлэлийн бурхан байлаа. Түүнийг ихэвчлэн нэг нүүрээрээ өнгөрсөн рүү, нөгөө нүүрээрээ ирээдүй рүү харж буй— хоёр нүүртэйгээр дүрсэлдэг байжээ. Зарим хэлэнд Жанварь буюу нэгдүгээр сарыг түүний нэрээр нэрлэдэг. Учир нь жилийн эхлэл нь сайтар төлөвлөн, тунгаан бодох цаг юм.

Олон мянган жилийн дараа ч дэлхий дээрх олон улс орон шинэ оныхоо хувийн хөгжлийн зорилгоо тавих энэхүү уламжлалаа үргэлжлүүлсээр байна. Мэдээж хэрэг, зорилго тавих нь амархан ч тэдгээрийг биелүүлэх нь харин өөр зүйл билээ.

Шинэ оны хувийн хөгжлийн зорилгын урт жагсаалтыг хийсэн нэг хүн өсөлт хөгжлийнхөө талаар сэтгэл ихэд хангалуун байсан ажээ. Тэрээр дотроо “Одоогоор би хоолны дэглэмээ чанд сахиж, уурлаж уцаарлаагүй мөн төсвөө баримтлан, хөршийнхөө нохойны талаар нэг ч удаа гомдоллоогүй байгаа. Гэхдээ өнөөдөр чинь нэгдүгээр сарын 2. Сэрүүдэг дуугарч байна, босох цаг ч болж. Гайхамшиг тохиовол л би бүх зорилгуудаа үргэлжлүүлэн дагах байх даа” гэж боджээ.

### Дахин эхлэх нь

Сайн эхлэлийн талаар гайхалтай найдвар төрүүлсэн зүйл байдаг. Бид бүгдээрээ алдаа мадаггүйгээр цоо шинээр дахин эхлэхийг нэг бус удаа хүсч байсан гэж би боддог.

Би хатуу диск нь хоосон, шинэ компьютер авах тун дуртай. Ийм компьютер хэсэг хугацаанд үнэхээр

сайн ажилладаг. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам шинэ програмууд нэмж суулгасаар байгаад (заримыг нь зориудаар, заримыг нь тохиолдлоор) эцэстээ компьютер гацаж эхлэн, үйлдлүүд нь эхэндээ маш хурдан байснаа удааширдаг. Заримдаа бүр ажиллахаа болино. Шаардлагатай бус мэдээ баримтууд болон ашиггүй үйлдлүүдээр хатуу дискийн ачаалал нь хэтэрсэн учир компьютерийг асаах гэж бөөн юм болдог байлаа. Компьютерийг форматлаад үйлдлийн систем дахин суулгаж, шинээр эхлүүлэх нь цорын ганц зөв арга болох үе байдаг байв.

Үүнтэй адил хүмүүс айдас, эргэлзээ болон гэм буруугийн ачаа дарамтаар дүүрч болно. Бидний гаргасан алдаа (санаатай, санамсаргүй аль аль нь) бидэнд ачаа дарамт болж, санаагаар унан, гутрахад хүргэж, хийх ёстой зүйлээ хийхэд ч хэцүү санагдаж байж болно.

Нүгэл үйлдсэнээс болж, хүний зүрх сэтгэлд хуримтлагддаг ачаа дарамтаасаа дотоод хатуу дискээ цэвэрлэх боломжийг олгодог, наманчлал хэмээн нэрлэгддэг, форматлах гайхамшигтай үйл явц байдаг. Сайн мэдээ нь Есүс Христийн гайхамшигтай мөн нигүүлсэнгүй Цагаатгалаар дамжуулан нүглийн гэм буруугаас бие сэтгэлээ ариусган, дахин шинэчилж, улмаар хүүхэд мэт цагаан цайлган, цэвэр ариун болох арга замыг бидэнд үзүүлдэг билээ.

Гэвч зарим нэг зүйлс нь шинээр эхлүүлэхэд бэрхшээлтэй болгож, хэрэггүй бодлууд хийгээд үйлдлүүдийг бий болгон, биднийг удаашруулан, хойш татаж байдаг.



### **Өөрийн чадах хамгийн сайнаараа байх нь**

Зорилго тавих нь туйлын чухал. Тэнгэрлэг Эцэгт маань зорилго байдгийг бид мэднэ, учир нь Тэр бидэнд Түүний ажил болоод алдар суу нь “Үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Мосе 1:39) явдал гэж хэлсэн билээ.

Бидний хувийн зорилго бол өөрсдийн чадах хамгийн сайнаараа байх нь юм. Гэвч хувийн хөгжлийн зорилгоо тавьж, хэрэгжүүлэх бидний хичээл зүтгэлийг тасалдуулдаг зүйлсийн нэг бол хойшлуулах явдал байдаг. Бид заримдаа шинэ оны эхний

өдөр эсвэл зуны эхэнд, бишоп юм уу Халамжийн Нийгэмлэгийн ерөнхийлөгчөөр дуудагдсан үедээ эсвэл хүүхдүүдээ сургуульд орсны дараа болон тэтгэвэрт гарсныхаа дараа гэх зэргээр зөв цагийг хүлээн, шинээр эхлэхээ хойшлуулдаг.

Зөв зорилгодоо ахиц дэвшил гаргахад танд урилга хэрэггүй. Та байвал зохих тийм хүн болохдоо зөвшөөрөл авахаар хүлээх хэрэггүй. Та сүмд үйлчлэхээр уригдахыг хүлээх хэрэггүй.

Бид заримдаа сонгогдохыг хүлээсээр байгаад амьдралынхаа олон жилийг алдаж болно (С ба Г

### **ЭНЭХҮҮ ЗАХИАСААС ЗААХ НЬ**

**З**орилгодоо хүрэх гээд бүтэлгүйтэх үед “бид хүч чадлаар дүүрдэг. . . . Бид барианы шугам дээрээ бүтэлгүйтсэн ч аянаа цааш үргэлжлүүлэх нь биднийг урьд нь байснаасаа илүү хүч чадалтай болгодог” гэж ерөнхийлөгч Угдорф тайлбарласан билээ. Сургууль төгсөх, шагнал хүлээн авах зэрэг үр дүнгээс илүү, үйл явцаас нь юу сурч мэдсэнээ хуваалцахыг гэр бүлийн гишүүдээс хүс.

121:34–36-г үзнэ үү). Гэвч энэ нь хуурамч таамаглал юм. Та аль хэдийн сонгогдсон!

Миний амьдралд хувийн болон санаа зовоосон бусад асуудлууд эсвэл уйтгар гунигийнхаа улмаас олон шөнийг нойргүй өнгөрүүлсэн тийм үеүд бий. Гэхдээ шөнө ямар ч харанхуй байсан, өглөө нь нар манддаг гэсэн бодол надад ямагт урам хайрладаг байлаа.

Шинэ өдөр бүрийг угтаж, шинээр үүр гийдэг нь зөвхөн дэлхийн төлөө төдийгүй бас бидний төлөө юм. Тийнхүү шинэ өдөр ирэхэд шинэ эхлэл—дахин эхлэх боломж ирдэг.

## Харин бид бүтэлгүйтвэл яах вэ?

Зарим үед биднийг хойш чангаадаг зүйл байдаг нь айдас юм. Бид амжилтад хүрэхгүй, биднийг шоолох болно, амжилт нь биднийг өөрчилнө эсвэл энэ нь бидний хайртай хүмүүсийг өөрчилнө хэмээн бид айдаг байж магадгүй.

Иймээс бид хүлээзнэдэг. Нэг бол бууж өгдөг.

Богино хугацаагаар ч болов бүтэлгүйтэж, амжилт олохгүй байх нь—байх л зүйл гэдгийг бид зорилго тавихдаа санаж байх хэрэгтэй юм. Харин бид үүнийг ойлгосноор яг одоо төгс байна гэсэн дарамтаас ангижрах учраас хүч чадалтай болж чадна. Эхлэлээсээ бид хэзээ нэгэн

өдөр бүтэлгүйтэж болно. Үүнийг урьдаас мэдэж байх нь бүтэлгүйтсэнээс болж цочирдох мөн урам хугарахаас маш сайн сэргийлдэг.

Биднийг энэ замаар зорилгодоо хүрэх үед бүтэлгүйтэл бидэнд саад учруулж чадахгүй. Бид туйлын зорилгоо биелүүлж, хүссэн түвшиндээ хүрэх гээд бүтэлгүйтсэн ч уг зорилго руу хөтлөх замд ахиц дэвшил гаргасан байх болно гэдгийг санагтун.

Энэ бол маш чухал зүйл юм.

Бид барианы шугам дээрээ бүтэлгүйтэж мэдэх ч аянаа цааш үргэлжлүүлэх нь биднийг урьд нь байснаасаа илүү хүч чадалтай болгодог.


## Эхлэх хамгийн сайн цаг бол яг одоо

Хуучны нэгэн зүйр үгэнд: “Мод тарих хамгийн тохиромжтой цаг нь 20 жилийн өмнө байсан. Хоёр дахь хамгийн тохиромжтой цаг нь яг одоо юм” гэсэн байдаг.

Одоо гэдэг үгийн тухайд гайхамшигтай бөгөөд найдвар төрүүлэх нэг зүйл бий. Хэрэв бид яг одоо шийдэхээр сонгоход энэ мөчид л урагш ахиж чаддаг гэвэл хүч чадал өгөгч ямар нэг зүйл байж таарна.


Бид энэ үеэс хойш 20 жилийн дараа төдийгүй мөн үүрд мөнхөд ямар хүн болохыг хүсдэг шигээ тийм хүн болохоор эхлэх хамгийн сайн цаг нь одоо юм. ■

## ӨСВӨР ҮЕИЙНХЭНД ЗОРИУЛАВ



## Хамгийн сайн хүн болохын тулд чадах бүхнээ одоо хийж эхэл

Ерөнхийлөгч Угдорф “Хувь хүний зорилго нь бидэнд байгаа хамгийн сайн зүйлсийг илрүүлэн, хөгжүүлдэг” хэмээн заажээ. Биеийн болон сүнсний эрүүл мэнд, нөхөрлөл зэрэг амьдралынхаа хоёр, гурван зүйлд зорилго тавьж ажилла. Та энэ жил эдгээр зүйлс дээр ямар амжилтад хүрэхийг хүсч байна вэ? Та зорилгынхоо тухай залбирч бодохдоо тэдгээр нь биелэгдэх боломжтой байхаас гадна танаас өсч хөгжихийг шаарддаг байхад анхаар. Жил өнгөрөхөд та өсөлт хөгжлөө харах боломжтой байхын тулд зорилгуудаа өдрийн тэмдэглэлдээ дэлгэрэнгүй дүрслэн бичиж бай.





Энэ материалыг залбирч судлан, хуваалцах зүйлээ мэдэхээр эрэлхийл. Аврагчийн амьдрал ба зорилгыг ойлгох нь Түүнд итгэх итгэлийг тань хэрхэн өсгөж, айлчлагч багшлалтаар дамжуулан харж ханддаг хүмүүсийн тань амьдралыг мөн хэрхэн адислах вэ? Дэлгэрэнгүй мэдээллийг [reliefsociety.lds.org](http://reliefsociety.lds.org)-ээс үзнэ үү.

## Есүс Христийн тэнгэрлэг зорилго: Үлгэр жишээ үзүүлэгч

Энэ бол Аврагчийн зорилгын онцлог талуудын тухай айлчлагч багшийн цуврал захиасуудын нэг хэсэг юм.

Есүс Христ бол бүх зүйлд бидний үлгэр жишээ мөн гэдгийг ойлгосноор бид Түүнийг дагах илүү их хүсэлтэй болж чадна. Христийн зам мөрийг дагахад судрууд бидэнд агуу зориг өгдөг билээ. Аврагч нифайчуудад хандан: “Учир нь миний хийхийг та нарын харсан тэр ажлуудыг та нар түүнчлэн хийх болно” (3 Нифай 27:21) гэж хэлжээ. Есүс Томаст хандан: “Би бол зам, үнэн, амь мөн. Хэн ч надаар дамжилгүйгээр Эцэгт хүрэхгүй” (Иохан 14:6) гэж хэлсэн юм.

Өнөөдөр удирдагчид маань Аврагчийг өөрсдийн үлгэр жишээгээ болгохыг бидэнд сануулдаг. Халамжийн Нийгэмлэгийн ерөнхий ерөнхийлөгч Линда К.Бертон “Бидний хүн нэг бүр Цагаатгалын сургаалыг зүрх сэтгэлдээ гүнзгий ойлгосон үед Их Эзэн биднийг ямархуу маягийн хүмүүс болохыг хүсдэг билээ, бид тийм хүмүүс болж төлөвших болно” гэж хэлжээ.<sup>1</sup>



Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бидний Их Эзэн бөгөөд Аврагч Есүс Христ бол бидэнд үлгэр жишээ үзүүлэгч бас бидний хүч чадал мөн” гэж хэлсэн билээ.<sup>2</sup>

Есүс Христэд улам ойртож, Түүний зарлигуудыг даган, Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очихын төлөө хичээцгээе.

### Судруудаас

2 Нифай 31:16; Алма 17:11;

3 Нифай 27:27; Моронай 7:48

### ЭШЛЭЛҮҮД

1. Линда К.Бертон, “Is Faith in the Atonement of Jesus Christ Written in Our Hearts?” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 114-р хуудас.
2. Томас С.Монсон, “Meeting Life’s Challenges,” *Ensign*, 1993 оны 11-р сар, 71-р хуудас.
3. “How Great the Wisdom and the Love,” *Нутны*, дугаар 195.
4. Дийтр Ф.Угдорф, “Аз жаргал, та нарын өв,” *Лиакхона*, 2008 оны 11-р сар, 120-р хуудас.



Итгэл, гэр бүл, халамж

### Бидний түүхээс

Халамжийн Нийгэмлэгийн хоёр дахь ерөнхий ерөнхийлөгч Элиза Р.Снөү Есүс Христийн мөнх бус амьдрал дахь үйлчлэлийн тухай “Тэрбээр замыг зааж, тэр замаар удирдсан юм” хэмээн бичжээ.<sup>3</sup> Тэр хүмүүст нэг бүрчлэн үйлчилдэг байлаа. Бид ерэн есөн хонио орхиод алдагдсан нэг хонийг аврахаар явах ёстой гэж Тэр заасан билээ (Лук 15:3–7-г үзнэ үү). Тэрээр цугласан 2500 хүний хүн нэг бүрд цаг гаргаж, тэднийг эдгээж, тэдэнд заасан юм (3 Нифай 11:13–15; 17:25-ыг үзнэ үү).

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф хожмын үеийн гэгээнтэн эмэгтэйчүүдийн тухай хэлэхдээ “Гайхамшигтай эгч нар та бүхэн бусдад үйлчлэхийг хувийн эрх ашгаасаа дээгүүрт тавин, өрөвч нинжин сэтгэлийн үйлчлэлийг тэдэнд үзүүлдэг билээ. Та нар үүгээрээ Аврагчийн үлгэр жишээг даган дуурайдаг. . . . Тэрбээр бусдад хэрхэн үйлчилж болох талаар үргэлж боддог байсан” гэжээ.<sup>4</sup>

### Би юу хийж чадах вэ?

1. Есүс Христ яагаад мөн хэрхэн надад үлгэр жишээ үзүүлэгч байдаг вэ?

2. Айлчилж очдог эгч нартаа үйлчлэх нь Аврагчийг дагахад надад хэрхэн туслах вэ?

# 2013 ОНЫ 10-Р САРЫН ЧУУЛГАНЫ ТЭМДЭГЛЭЛ

*“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).*

Амьд бошиглогч, төлөөлөгчдийн болон сүмийн бусад удирдагчдын саяхан заасан зүйлсээс суралцаж, тэдгээрийг амьдралдаа хэрэгжүүлэхэд тань туслах 2013 оны 10-р сарын Ерөнхий чуулганы хэлсэн үгсийг судлахдаа эдгээр хуудсуудыг (мөн дараагийн дугаарууд дахь чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.



## Бошиглогчийн амлалт: Бэрхшээлүүдтэй нүүр тулах нь

Биднийг баярлаж баясгах маш олон зүйлсээр адисалсан Тэнгэрлэг Эцэг маань биднийг ирэх зовлон бэрхшээлүүдтэйгээ нүүр тулж, тэдгээрийг даван гарснаар илүү ихийг сурч улмаар өсч хөгжин, улам хүчирхэг болдог гэдгийг маань мэддэг. Биднийг гансруулж зовоон, тэсвэр тэвчээрийг маань барж түүнчлэн зүрхийг минь мохоон, уй гашууг мэдрүүлэх тийм цаг үе ирнэ гэдгийг бид мэддэг. Гэхдээ ийм бэрхшээлүүд нь Тэнгэрлэг Эцэгийн зааснаар амьдралаа өөрчлөх боломжийг бидэнд олгож, биднийг илүү чадварлаг болгон өөрчилдөг

билээ. Бид өмнө байснаасаа илүү сайжирч—бидний ойлголт тэлэн, бусдыг хайрлах илүү их чадвартай мөн өмнөхөөсөө ч илүү хүчтэй гэрчлэлтэй болцгоодог юм.

“Бидний зорилго бол цөхрөлтгүйгээр урагшилж, даван туулах явдал юм. Тийм ээ, түүнчлэн бид нар, салхийг сөрөн гарахдаа сүнсээ хүчирхэгжүүлэх ёстой билээ. Хэрэв бидэнд шийдэх ёстой асуудлууд, давж гарах ёстой бэрхшээлүүд гэж байдаггүй байсансан бол бид хэзээ ч өөрчлөгдөхгүйгээр хэвээр үлдэж, мөнх амийг авах зорилгодоо ер ойртолгүй эсвэл үл ялиг л ойртсон байх байсан юм.”

Ерөнхийлөгч Томас С. Монсон, “Би чамайг хаяхгүй мөн орхихгүй” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 87.

Ерөнхий чуулганы үгсийг [conference.lds.org](http://conference.lds.org)-оос уншиж, үзэж харах эсвэл сонсох боломжтой.

Танай гэр бүл Ерөнхий чуулганаас сурч байгаа зүйлсээ хэрхэн хэрэгжүүлж байгаа вэ? [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org) хаягаар имэйл илгээнэ үү.

## Танд зориулсан хариултууд

Чуулган бүрээр бошиглогч, төлөөлөгчид сүмийн гишүүдэд байж болох асуултуудад сүнслэгээр удирдагдсан хариултуудыг өгдөг юм. 2013 оны 11-р сарын дугаараас эсвэл [conference.lds.org](http://conference.lds.org)-оос эдгээр асуултуудын хариултыг олно уу.

- Бид Итгэлийн тунхагаас сайн мэдээний ямар сургаалуудыг сурдаг вэ? Л. Том Пэрри, “Итгэлийн тунхаг дахь сургаал, зарчмууд”-ыг үзнэ үү.
- Бид айдастай байсан үедээ номлолын ажилд хэрхэн оролцох вэ? М. Рассэл Баллард, “Их Эзэнд итгэл найдвараа тавь”-ыг үзнэ үү.
- Аравны нэгийг юунд ашигладаг вэ? Дэвид А. Бэднар, “Тэнгэрийн цонхнууд”-ыг үзнэ үү.
- Нүгэл үйлдэх мөн эсэргүүцэл үзүүлэх нь хэрхэн бидний сонгох эрх чөлөөнд нөлөөлж, боолчлолд хүргэж болох вэ? Квинтин Л. Күк, “Иеремиагийн гашуудал: Боолчлолоос сэрэмжил”-ийг үзнэ үү.



### ЯВЖ МӨН ХИЙ

Хэрэв бид дараах зүйлсийг хийвэл чуулганы агуу адислалууд ирдэг болохыг Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Робэрт Д. Хэйлс заасан юм:



1. “Их Эзэний үгсийг сонсохоор цуглар.”



2. “Тэдгээрийн дагуу амьдрахын тулд гэртээ харь.”

“Ерөнхий чуулган: Итгэл ба гэрчлэлийг хүчирхэгжүүлэх нь,” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 7-р хуудсаас.

### ЭМЭГТЭЙЧҮҮДЭД БОЛОН САНВААРТНУУДАД ЗОРИУЛСАН БОШИГЛОЛЫН ҮГС

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л. Андэрсэн “Яагаад санваарын ёслолуудыг эрэгтэй хүн гүйцэтгэдэг вэ? гэж асуусан . . .

“Өөрийн охид, хөвгүүдийг Бурхан адилхан хайрладаг гэдгийг бид баттай мэддэг шиг Тэрээр эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг яг адилхан бүтээгээгүй гэдгийг ч бас мэддэг. Түүнчлэн хүйс нь мөнх бус болон мөнх амьдрал бидний хэн байх зорилгуудын маань салшгүй чухал хэсэг гэдгийг ч бид мөн мэддэг билээ. Аль алинд нь ариун нандин үүрэг хариуцлагууд өгөгддөг.

“Түүний санваарыг хэрхэн ашиглах ёстой талаар Их Эзэн эхлэлээс тогтоосон гэдгийг бид мэднэ.”

Энэхүү хэлсэн үгийн 12 дахь эшлэлд ахлагч Андэрсэн бусад бошиглогчдын үгсээс эш татаж, уг асуултад хариулсан юм. Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли (1910–2008) “Түүний сүмд эрэгтэй хүн санваар атгах ёстой гэдгийг Их Эзэн Өөрөө тогтоосон юм” гэж хэлсэн. Харин Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч М. Рассэл Баллард “Их Эзэн яагаад энэ маягаар Өөрийн сүмийг зохион байгуулснаа илчлээгүй юм” гэж хэлсэн байна.

“Санваарын хүч,” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 92-р хуудсаас.

### ХООСОН ЗАЙГ БӨГЛӨӨРӨЙ

1. “Гэрээгээ сахигчид нь \_\_\_\_\_-ыг сахигчид байдаг билээ!” (Линда К. Бертон, “Гэрээгээ сахиснаар ирэх хүч чадал, баяр баясал мөн хайр,” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 113).
2. “Өөрсдөө ч мэдэлгүйгээр олон хүн \_\_\_\_\_-г сонсож, Их Эзэний \_\_\_\_\_-т нэгдэх газрууд руу Түүгээр удирдуулагдаж байдаг.” (Жэралд Коссэй, “Та нар цаашид гадны хүмүүс биш,” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 50).
3. “Зөвт байдал нь \_\_\_\_\_-аас илүү хүчтэй.” (Боид К. Пакэр, “Сүнсний хамгаалалтын түлхүүр,” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 27).
4. “Эр, эм хүйсийн ялгааг бүдгэрүүлснээр бид \_\_\_\_\_, \_\_\_\_\_ хүмүүсийн ялгаатай бөгөөд бие биенээ нөхдөг мөн нийлж, илүү сайн сайхан зүйлийг бүтээдэг тэрхүү бэлгүүдээ алдаж эхэлдэг юм.” (Д. Тодд Кристоффэрсон, “Эмэгтэйчүүдийн ёс суртахууны хүч,” *Лиахона*, 2013 оны 11-р сар, 31).

Хариултаа: 1. тушаал; 2. сайн мэдээ, сурвалж; 3. ёс бус байдал; 4. эрэгтэй, эмэгтэй

# ХАРАНХУЙГААС ГЭРЭЛ РҮҮ

*Бидний амьдрал харанхуй болсон үед бид чин сэтгэлээсээ залбирвал Есүс Христ тэрхүү харанхуйг гэрэл болгон хувиргаж чадна гэдгийг баттай мэдэж болно.*

## Нэрийг нууцлав

Аз жаргалтай амьдарч, Тэнгэр дэх Эцэгтээ эргэж очих найдвар үгүй болсон юм шиг санагдаж байсан үе миний амьдралд нэг бус удаа тохиолдож байсан. Хэдэн жилийн өмнө намайг сүмийн гишүүнчлэлээс түдгэлзүүлсэн юм. Би бардамнал болон нүгэлт амьдралаар амьдарч, үйлдлүүдээсээ болж их зовдог байлаа. Хайртай бүсгүйтэйтэй гээ сүй тавьсан ч бүтсэнгүй. Бусад хүмүүстэй харилцах нь надад хэцүү юм шиг санагддаг байснаас би аз жаргалгүй байв.

Би бүр дээр үед даруу байх сонголт хийхийг хүссэн ч албаар даруусгагдаж, Их Эзэний хүслийг биелүүлэхээр эрэлхийлсэн билээ. Ингээд би судруудыг байнга уншиж, үргэлж залбиран, бусдад үйлчлэхийг хичээдэг боллоо. Удаан хугацаанд үл тоомсорлодог байсан харилцаагаа, түүний дотор Тэнгэрлэг Эцэгтэй харилцах харилцаагаа сэргээхийг хичээдэг болов. Би зүрх сэтгэлийн өөрчлөлтийг үнэхээр хүсч байлаа.

Нэг өдөр намайг өглөө эрт сургууль руугаа явах үед нар мандаагүй байв. Тэнгэрийн зүүн хаяа гэгээрч,

харанхуй байсан тэнгэрийн баруун хаяанд тэргэл саран жаргаж байлаа. Би машин барьж явахдаа ч Тэнгэрлэг Эцэгтэйгээ ярилцах хэвшлийг өөртөө хөгжүүлж байсан юм. Энэ удаад машинаар явж байхдаа залбирч байтал оюун ухаан минь гэгээрч, зүрх сэтгэлд минь шинэ найдвар төрсөн.

Миний амьдрал гэрэл гэгээтэй болж, тэнгэрийн зүүн хаяан дахь гэгээ шиг улам тодорч байгааг би ухаарсан юм. Жаргаж буй бүтэн сар шиг үлэмж их байсан миний нүглүүд мөн харанхуй сарнин, алга болж байлаа. Нүглүүд маань бүрэн арилаагүй ч хэрэв чин сэтгэлийн



## НАМАНЧЛАЛААР ДАМЖИН ИРДЭГ АЗ ЖАРГАЛ

“Түүнд эргэж очих бидний хичээл зүтгэл бүрийг Тэнгэрлэг Эцэг тэсч ядан хүлээдгийг бид ойлгодог бил үү? Түүнд очих бидний зам асар хол ч гэсэн Тэрбээр биднийг эргэж очиход баяртай байх болно. Бид цэвэр ариун байж чадах юм бол хэзээ нэгэн цагт тэнгэрлэг гэртээ эргэж очих болно гэдгийг Аврагчийн хайр бидэнд баталдаг учраас бид баяртай байдаг билээ. Энэхүү аз жаргал зөвхөн наманчлалаар дамжин ирдэг.

“Бид буруу зүйл хийхээ ардаа орхиж, Есүс Христэд итгэх итгэлээ ашигласнаар нүглүүдийнхээ өршөөлийг хүлээн авах болно. Бидний өөрсдөө хийж чадахгүй зүйлийг Аврагч бидний төлөө хийдгийг бид мэддэг.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андерсен, “The Joy of Becoming Clean,” *Ensign*, 1995 оны 4-р сар, 51-р хуудас.



наманчлалаа үргэлжлүүлбэл удахгүй арилж, үгүй болно гэдгийг би мэдэж байлаа. Хэзээ нэгэн цагт миний амьдрал үд дундын нар мэт гэрэлтэй болно гэсэн найдвар надад байв.

Цаг хугацаа өнгөрөх тусам Тэнгэрлэг Эцэгийг болон бусдыг хайрлах хайрын төлөө залбирах үедээ би улам даруу болж байсан юм. Ийнхүү улам даруу болсон нь намайг Бурханд болон бусдад амин хувиа үл хайхран, үйлчлэхэд хөтөлсөн бөгөөд мөнх амьдрал болон илүү сайхан ирээдүйн төлөөх итгэл найдвар минь шинэчлэгдсэн билээ. Тэрхүү найдвар өсөхийн хэрээр миний Аврагч, Есүс Христ намайг аварч, Тэрээр бүхий л шударга бус зүйлээс ариусгах хүчтэй гэсэн итгэл минь бас өссөн юм. “Та нар Христийн Цагаатгал, мөн түүний амиалтын хүчээр, мөнх амьдралд босгогдохын тулд найдах [болно]” (Моронай 7:41) гэсэн Мормоны үгс үнэнийг би мэднэ. ■

### НАМАНЧЛАЛЫН НӨХЦӨЛҮҮД НЬ ЮУ ВЭ?

Наманчлал нь дараах нөхцөлүүдтэй болохыг бошиглогч Хиламан заажээ.

“Их Эзэн өөрийн хүмүүсийг гэтэлгэхээр гарцаагүй ирэх болно, . . . гэвч тэрээр тэднийг нүгэлд нь гэтэлгэхээр ирэх бус харин тэднийг нүглүүдээс нь гэтэлгэхээр ирнэ.

“Мөн наманчлалын учир нүглүүдээс нь тэднийг гэтэлгэхээр Эцэгээс түүнд хүч өгөгдсөн буй; тиймийн тул Гэтэлгэгчийн хүчинд бодгалиудынх нь авралд хүргэх наманчлалын нөхцөлүүдийн мэдээг тунхаглуулахаар тэрээр тэнгэр элчүүдээ илгээсэн билээ” (Хиламан 5:10–11; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Эдгээр нөхцөлүүдийн заримыг илүү сайн ойлгохын тулд дараах судруудыг судал: Ром 3:23; 1 Нифай 10:21; 2 Нифай 2:8; Мозая 4:9–10; Сургаал ба Гэрээ 58:42–43.

---

**Аврагчийн үйлчлэл болон зорилготой холбоотой таны сайн мэдээний туршлагын тухай түүхүүдийг бид тун баяртай хүлээн авах болно. Цагаатгал, ач ивээл, эдгээлт, найдвар, наманчлал зэрэг сэдвүүдээр байж болох юм. Өгүүллээ 600 үгэнд багтааж, “We Talk of Christ (Бид Христийн талаар ярьдаг)” гэж хаяглан, [liahona.lds.org](http://liahona.lds.org) руу илгээх буюу [liahona@ldschurch.org](mailto:liahona@ldschurch.org)-аар имэйлээр ирүүлнэ үү.**

# АДАМ

“Үүрд мөнхөд хэдхэн хүн авралын төлөвлөгөөнд . . . Адамаас илүү оролцоотой байсан.”<sup>1</sup>

Ихэнх хүмүүс намайг дэлхий дээр амьдрахаар ирсэн анхны хүн гэдгээр минь мэддэг ч дэлхий дээр ирэхээс өмнө надад онцгой үүрэг хариуцлага байсныг тэд мэддэггүй. Мөнх бус байдлын өмнөх оршихуйд тэнгэрт болсон дайнд би Сатаны их цэргийн эсрэг тулалдсан Бурханы их цэргийг удирдсан<sup>2</sup> бөгөөд дэлхийг бүтээхэд нь Есүс Христэд тусалсан билээ.<sup>3</sup> Тэр үед намайг Михаил гэдэг байсан нь “Бурхантай адил хүн” гэсэн утгатай юм.<sup>4</sup>

Бурхан намайг дэлхийд ирэх анхны хүн байхаар сонгож, олон зүйлийн ургамал, амьтантай диваажин болох Эдэний цэцэрлэгт байрлуулсан билээ. Тэр надад “амин амьсгалыг”<sup>5</sup> оруулж, Адам хэмээх шинэ нэрийг өгсөн юм.<sup>6</sup>

Бурхан миний эхнэр Ева бид хоёрт сайн ба муугийн мэдлэгийн модны жимснээс идэж болохгүй гэсэн юм.<sup>7</sup> Бид тэр жимсийг идээгүй бол цэцэрлэгт үлдэж, тэндээ үүрд амьдрах байсан ч “мөнх бус байдлын эсрэг тэсрэг талыг мэдсэнээр өсч хөгжих”<sup>8</sup> болон үр хүүхдүүдтэй байх боломжгүй байх байсан.<sup>9</sup> Сонголт бидэнд өгөгдсөн байлаа.

Бид уг жимсийг идэхээр сонгосон учраас цэцэрлэг болон Бурханы оршихуйг орхих шаардлагатай болсон билээ. Үүнийг уналт гэдэг. Бид мөнх бус болж; амьдралын сайн, муу талыг аль алиныг нь мэддэг болж; дэлхийд хүүхдүүдийг авчирсан юм.<sup>10</sup>

Уналт болно гэдгийг Бурхан мэдэж байсан учраас бид бүгд үр хүүхдүүдийнхээ хамт Түүнд эргэн очих боломжтой байхын төлөө нүглүүдийг минь цагаатгаж, үхлийг ялахын тулд Есүс Христийг илгээсэн билээ.<sup>11</sup>

Ева бид хоёр Есүс



Христийн сайн мэдээний тухай, түүний дотор Есүс Христэд итгэх итгэл, наманчлал, баптисм, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах болон эцсээ хүртэл тэвчих тухай заалгасан бөгөөд үүнийгээ хүүхдүүдээ заасан юм.<sup>12</sup>

Эдгээр туршлагауд байсан учраас нүд минь нээгдэж,

энэ амьдралд би баяр баясгалантай байсан билээ.<sup>13</sup> Та нар ч бас Есүс Христийг дагавал миний сурч мэдсэний нэгэн адил<sup>14</sup> Бурханы хайрыг мэдэрч, Түүнд эргэн очиж чадна гэдгийг санагтун. ■

#### ЭШЛЭЛҮҮД

1. Роберт А.Миллэт, "The Man Adam," *Ensign*, 1994 оны 1-р сар, 8-р хуудас.
2. Илчлэлт 12:7–8-ыг үзнэ үү.
3. Роберт А.Миллэт, "The Man Adam," 10-р хуудсыг үзнэ үү.
4. Судруудын удирдамж, "Михаил," scriptures.lds.org.
5. Эхлэл 2:7.
6. Мосе 1:34-ийг үзнэ үү.
7. Эхлэл 2:16–17; Мосе 3:16–17-г үзнэ үү.
8. *Миний сайн мэдээг номло: Ноллогчийн үйлчлэлийн удирдамж* (2004), 49-р хуудас.
9. 2 Нифай 2:22–23-ыг үзнэ үү.
10. Мосе 4:22–31; 5:10–11; Алма 12:21–27-г үзнэ үү.
11. Иохан 3:16–17; 1 Коринт 15:22; 2 Нифай 9:21; Алма 42:2–15-ыг үзнэ үү.
12. Мосе 5:1–12, 58–59; 6:51–67-г үзнэ үү.
13. Мосе 5:10-ыг үзнэ үү.
14. Мозая 27:25–26-г үзнэ үү.
15. Сургаал ба Гэрээ 27:11-ийг үзнэ үү.
16. Эхлэл 5:5-ыг үзнэ үү.
17. Сургаал ба Гэрээ 116:1; Даниел 7:9–14-ийг үзнэ үү.
18. Сургаал ба Гэрээ 29:26-г үзнэ үү.
19. Сургаал ба Гэрээ 88:114–116-г үзнэ үү.

ЗҮҮН ТАЛААС: ДАН БАКСТЭРЫН УРАН ЗУРАГ; АДАМ, ЕВА ХОЁР ЦЭЦЭРЛЭГТ, ЛАУВЭЛЛ БРУС БЭННЭТ, ЭДЭНИЙ ЦЭЦЭРЛЭГИЙГ ОРХИН ЯВСАН НЬ, ИОСЕФ БРИКИ; АДАМ, АДИЛ ТӨСТЭЙ БАЙДЛААР, ИОСЕФ БРИКИ; АДАМ, ЕВА ХОЁР ХҮҮХДҮҮДЭЭ ЗААЖ БАЙГАА НЬ, ДЭЛ ПАРСОН; АДАМ СЭТИЙГ ТОМИЛЖ БАЙГАА НЬ, ДЭЛ ПАРСОН; АДАМ-ОНДАЙ-АМАН, ДЭЛ ПАРСОН; ТЭРГҮҮН ТЭНГЭР ЭЛЧ МИХАИЛ САТАНЫГ БУТ ЦОХИСОН НЬ, ГУЙДО РЭНИ /BRIDGEMAN ART LIBRARY/GETTY IMAGES; ISTOCKPHOTO/THINKSTOCK-ИЙН СУУРЬ ЗУРАГ

#### МЭДЭЭ БАРИМТЫН ХАЙРЦАГ: АДАМ

**Нэрс:** Адам, эцэг Адам, Эртний өдрүүд, Михаил<sup>15</sup>

**Нас барах үедээ хэдэн настай байсан:** 930<sup>16</sup>

**Мөнх бус амьдралын өмнөх үүрэг:** Сатаны эсрэг тулалдаанд Бурханы их цэргийг удирдав; Есүс Христэд дэлхийг бүтээхэд нь туслав

**Мөнх бус амьдрал дахь үүргүүд:** патриарх, нөхөр болон эцэг; уналтыг тохиолгоход тусалжээ; Есүс Христийн сайн мэдээгээр амьдарч байв

**Мөнх бус амьдралын дараах үүргүүд:** Адам-ондай-Аманд өөрийн хүмүүстэй уулзана<sup>17</sup>; Амилуулалтад тусална<sup>18</sup>; Сатаны эсрэг сүүлчийн тулалдааныг удирдана<sup>19</sup>



**Ерөнхийлөгч  
Гордон Б.Хинкли  
(1910–2008)**

Сүмийн арвантав дахь  
ерөнхийлөгч

## ТЭНГЭРЛЭГ БУРХАН ТЭРГҮҮТЭН

*Бурхан Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсэнд итгэх бидний итгэл бол манай шашны хамгийн чухал итгэл юм.*

*Сүмийн 15 дахь ерөнхийлөгч Гордон Б.Хинкли 1910 оны 6-р сарын 23-нд төржээ. Тэрээр 51 насандаа 1961 оны 10-р сарын 5-нд төлөөлөгчөөр томилогдсон бол 1995 оны 3-р сарын 12-нд сүмийн ерөнхийлөгчөөр дэмжигдэн, батлагджээ.*

**Б**ошиглогч Иосеф манай сургаалын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг бий болгохдоо дараах сургаалыг эн тэргүүнд тавьсан юм: “Бид Бурхан, Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсэнд итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:1).

[Бошиглогч түүнчлэн]: “Бурханы мөн чанарыг баттай мэдэх нь сайн мэдээний анхдагч зарчим мөн” (*History of the Church*, 6:305) хэмээн заажээ.

Энэхүү агуу ач холбогдолтой, бүх талыг хамарсан тунхаглал нь “Цорын ганц үнэн Бурхан Таныг болон Таны илгээсэн Есүс Христийг мэдэх нь мөнхийн амь мөн” гэсэн Их Эзэний үгстэй нийцдэг билээ (Иохан 17:3). . . .

### Мөнхийн Эцэг Бурхан

Би Мөнхийн Эцэг Бурханд өчүүхэн ч эргэлзээгүйгээр, бүрэн итгэдэг. Тэр бол миний мөн сүнсний минь Эцэг бөгөөд бүх хүмүүний сүнсний Эцэг билээ. Тэр бол агуу Бүтээгч, ертөнцийн Захирагч. . . . Хүмүүн Түүний дүр төрхөөр бүтээгдсэн юм. Тэр бол бие хүн. Тэрээр бодитойгоор оршдог билээ. Тэр бол хувь хүн. Тэрбээр “хүмүүнийхтэй адил мэдрэгдэх мах хийгээд ясан биетэй болой” (С ба Г 130:22).

Дэлхийн бүтээлтийн тухай бичигдсэн цэдэгт “Бурхан -Бид Өөрсдийнхөө дүр төрхийн дагуу Өөрсөдтэйгөө адилхан хүнийг бүтээцгээе” (Эхлэл 1:26) гэсэн байдаг.

Хүмүүний хэлээр үүнээс илүү тодорхой дүрсэлж болно гэж үү? Бурхан хүмүүнийг Өөрийн онцгой дүр төрхөөр бүтээснээрээ Өөрийгөө доош нь оруулсан юм биш үү? хэмээн зарим хүмүүс бидэнд итгүүлэхийг хичээж мэднэ. Харин ч энэ нь эрэгтэй, эмэгтэй хүн бүрийн зүрх сэтгэлд өөрийгөө Бурханы хүү буюу охин гэж үзэх агуу бахархлыг бий болгодог. . . .

. . . Номлогчийн хувиар намайг зааж байтал [Английн Лондонд нэгэн танхай хүн] “Иоханы хэлснээр (Иохан 4:24) ‘Бурхан бол Сүнс’ гэсэн Библийн сургаалыг та яагаад дагадаггүй юм бэ?” гэж хашгиран, миний үгийг тасалж байж билээ.

Би Библээ нээж, түүний эш татсан шүлгэн дээр нэмэн, “Бурхан бол сүнс. Түүнд мөргөгчид сүнсээрээ, үнэнээр мөргөх ёстой” хэмээн түүнд бүрнээр нь уншиж өглөө.

Тэгээд би “Мэдээж хэрэг Бурхан бол сүнс, та ч гэсэн адил. Сүнс, бие хоёр нэгдсэнээр та амьд хүн байгаа юм. Би ч гэсэн мөн адил” хэмээн хэлж билээ.

Бидний хүн нэг бүр сүнсний матери, биеийн матери хоёрын нэгдлээс бүтсэн хүмүүн юм. Үхэл гэгч үнэн бодитойг бүгд мэднэ. . . . мөн сүнс нь бие даасан матери болон оршдог бөгөөд Бурханы Хүүгийн золиослолоор боломжтой болсон тэнгэрлэг төлөвлөгөөний дагуу хэзээ нэгэн цагт сүнс, бие хоёр дахин нэгдэх болно гэдгийг бид мэддэг. Бурхан бол сүнс мөн гэсэн Есүсийн тунхаглал нь Бурханы биетэйг үгүйсгэж чадахгүй. Учир нь, би бол сүнс гэдэг үзэл бодол миний биеийг үгүйсгэхгүй шүү дээ.

Би өөрийн биеийг Түүний төгс биетэй, тэрхүү биеийнх нь хүч чадал, үзэсгэлэн төгөлдөр хийгээд гэрэл цацруулан туяардагтай адилтгахгүй. Түүний бие мөнхийнх бол минийх зуурдын бие юм. Гэхдээ энэ нь гагцхүү Түүнийг хүндлэн дээдлэх миний хүндэтгэлийг нэмэгдүүлдэг билээ. . . . Би Түүнийг бүхий л зүрх сэтгэл, хүчин чадал, оюун ухаан хийгээд бүх чадлаараа хайрлахыг хичээдэг. Түүний мэргэн ухаан бүх хүмүүний мэргэн ухаанаас илүү агуу юм. . . . Түүний хайрыг бүх хүүхдүүд нь мэдэрдэг бөгөөд Өөрийн хөвгүүд болон охидод үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг тохиолгон авчрах нь Түүний ажил мөн алдар суу билээ. . . . (Моце 1:39-ийг үзнэ үү). . . .





### Их Эзэн Есүс Христ

Би мөнхийн амьд Бурханы Хүү, Их Эзэн, Есүс Христэд итгэдэг. Би Түүнийг Эцэгийн Ууган Хүү бөгөөд махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц Хүүгийн хувьд Түүнд итгэдэг. Би Түүнийг Эцэгээсээ тусдаа бөгөөд ялгаатай хувь хүн гэдэгт итгэдэг. . . .

Тэрбээр мөнх бус байдалд дэлхий дээр амьдарч байсан цорын ганц төгс хүн гэдэгт би итгэдэг. Би Түүний үгсээс гэрэл ба үнэнийг олж чадна гэдэгт, хэрэв бид энэхүү гэрэл ба үнэнийг дагавал дэлхийг аварч, хүн төрөлхтөнд өргөмжлөлийг авчрах болно гэдэгт итгэдэг. Түүний санваар бол бурханлаг эрх мэдэл—адислах болон эдгээх хүч, дэлхий дээрх Бурханы ажил хэргүүдийг удирдах мөн газар дээр холбосон зүйлийг тэнгэрт холбох хүч мөн гэдэгт би итгэдэг.

Тэрбээр Калварийн толгой дээр амиа өргөн, Өөрийн цагаатгагч золиослоор дамжуулан хүн

төрөлхтний нүглүүдийг цагаатгасан бөгөөд хэрэв бид нүгэл хилэнцээ орхиж, Түүнийг дагавал Тэрбээр биднийг нүглийн дарамтаас чөлөөлөх болно гэдэгт би итгэдэг. Би Түүний амилалтын хүч хийгээд үнэн бодит байдалд итгэдэг. . . . Бидний хүн нэг бүрд үхлээс амилуулагдах бэлэг . . . нь Түүний Цагаатгалаар өгөгдсөн гэдэгт би мөн итгэдэг. Бид Түүний зарлигуудыг дуулгавартай дагасан тохиолдолд эрэгтэй, эмэгтэйчүүд мөн Бурханы хөвгүүд, охид хүн нэг бүрд Тэнгэрлэг Эцэгийн хаант улсад үүрд мөнх амьдарч, өргөмжлөгдөх боломж энэхүү золиослоор өгөгдсөн гэдэгт би итгэдэг.

Ийм агуу ганц ч хүн дэлхий дээр амьдарч байгаагүй. Өөр хэн ч Түүнтэй харьцуулахуйц золиослол хийгээгүй эсвээс Түүнтэй эн зэрэгцэх адислалыг авчраагүй юм. Тэр бол дэлхийн Аврагч бөгөөд Гэтэлгэгч мөн. Би Түүнд итгэдэг. Би Түүний

бурханлаг мөн чанарыг тунхаглаж байна. . . . Би Түүнд хайртай. Би Түүний нэрийг хүндэтгэлтэй бөгөөд гүн бишрэлтэйгээр хэлж байна. . . .

. . . Түүний Өөрийгөө үзүүлсэн болон Бурханы амилсан Хүүгийн хувиар ярилцсан хүмүүсийн тухай сударт өгүүлдэг. Энэ эрин үед ийнхүү Тэрээр хүрч ирсэн бөгөөд Түүнийг харсан хүмүүс тунхаглахдаа:

“Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх хамгийн сүүлчийн гэрчлэл юм: Тэр амьд бөлгөө!

“Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон билээ—

Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс дэлхийнүүд бүтээгдсэн, бас бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь

Бурханы төрсөн хөвгүүд, охид бөлгөө” (С ба Г 76:22–24) гэжээ.

Энэ бол миний итгэдэг бас миний гэрчилдэг Христ.

### Ариун Сүнс

Энэ мэдлэг судрын үгсээс ирдэг бол энэхүү гэрчлэл Ариун Сүнсний хүчээр ирдэг билээ. Энэ бол Бурхан Тэргүүтэний гурав дахь гишүүнээс илчлэлтээр ирдэг ариун нандин бөгөөд гайхамшигтай бэлэг. Ариун Сүнс бол Эцэг, Хүү хоёртой хамт оршдог сүнсэн хүн бөгөөд энэ гурав нийлж, тэнгэрлэг Бурхан Тэргүүтэнийг бүрдүүлдэгт би итгэдэг. . . .

Эрт үед Ариун Сүнсийг Бурхан Тэргүүтэний нэг гишүүн хэмээн хүлээн зөвшөөрдөг байсныг Ананиа худалдсан газрынхаа үнэнээс заримыг нь нуун авч үлдсэн үед Петр, тэр хоёрын хооронд болсон яриа нотолдог.

“Тэгэхэд Петр -Ананиа, чи . . . Ариун Сүнсэнд худал хэллээ. Чиний зүрх яагаад Сатанд автах болов?

“ . . . Чи хүнд биш харин Бурханд худал хэллээ” (Үйлс 5:3–4) гэжээ.

Ариун Сүнс бол Түүний дагалдагчдад бүх зүйлийг зааж, хэлсэн бүгдийг тэдэнд сануулж байхын тулд Аврагчийн амласан Тайтгаруулагч юм . . . (Иохан 14:26-г үзнэ үү).

Ариун Сүнс бол хүмүүсийн бие биедээ зааж чадахгүй зүйлсийг тэдэнд зааж чаддаг, үнэний гэрчлэгч мөн. . . . Мормоны Номын үнэний мэдлэг “Ариун Сүнсний хүчээр” амлагдсан юм. “Мөн Ариун Сүнсний хүчээр та нар бүх зүйлийн үнэнийг



мэдэж болно” (Моронай 10:4–5) хэмээн Моронай тунхаглажээ.

Би энэхүү хүч болоод бэлэг өнөөдөр бидэнд боломжтой гэдэгт итгэдэг.

### Үнэн бөгөөд бодитой хувь хүн

“ . . . Би Бурхан, Мөнхийн Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон Ариун Сүнсэнд итгэдэг” (Итгэлийн тунхаг 1:1).

Би энэ гурвын нэрээр баптисм хүртэж, энэ гурвын нэрээр гэрлэсэн. Тэдний үнэн бодит байдал болоод тус тусдаа хувь хүмүүс гэдэгт би эргэлздэггүй. Ийнхүү тусдаа хувь хүн болох нь Иохан Есүст Иордан голд баптисм хүртээхэд мэдэгдсэн билээ. Бурханы Хүү усан дотор зогсож байсан шүү дээ. Эцэгийн дуу хоолой Хүүгийнхээ бурханлаг мөн чанарыг тунхаглаж, Ариун Сүнс тагтааны дүрээр харагдсан билээ (Матай 3:16–17-г үзнэ үү).

Түүнийг харсан хүмүүс Эцэгийг бас харсан хэмээн Есүс хэлснийг би мэднэ [Иохан 14:9-ийг үзнэ үү]. Эцэг, эхээ дуурайсан олон хөвгүүн мөн ингэж хэлэхгүй гэж үү?

Есүс Эцэгт хандан залбирахдаа мэдээж, Өөртөө хандан залбираагүй билээ!

### Төгс нэгдмэл

Тэд тус тусдаа хүмүүс ч гэсэн зорилго, хүч чармайлтаараа нэг юм. Тэд Бурханы хүүхдүүдийн аврал болон өргөмжлөлийн төлөөх агуу тэнгэрлэг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд нэг хүн мэт нэгдмэл байдаг.

. . . Христ хайртай төлөөлөгчдийнхөө талаар Эцэгээс гуйж,

“Би зөвхөн тэдний төлөө бус, тэдний үгээр дамжуулан Надад итгэх хүмүүсийн төлөө мөн гуйж байна.

“Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгдээрээ нэг байхын тулд юм” гэжээ (Иохан 17:20–21-ийг үзнэ үү).

Эцэг, Хүү, Ариун Сүнсний төгс эв нэгдэл нь энэ гурвыг нэгдмэл нэг тэнгэрлэг Бурхан Тэргүүтэн болгон нягт холбодог билээ. ■

*“The Father, Son, and Holy Ghost (Эцэг, Хүү мөн Ариун Сүнс)” өгүүллээс авав, Ensign, 1986 оны 11-р сар, 49–51-р хуудсууд; том үсгээр бичих дүрэм болон цэг тэмдгийг стандартын дагуу болгосон.*

# ХҮНДЭТГЭЛИЙН ӨДРИЙГ САХИХ НЬ

Олон хүний хувьд ням гараг нь зүгээр нэг долоо хоногийн амралт, зугаа цэнгэлийн өдөр байдаг. Гэвч эртний болон өнөө үеийн илчлэлт хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих нь хэчнээн чухал болохыг заасаар ирсэн. Энэ дугаарын 56–57-р хуудсан дээр Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Ларри М.Гибсон хүндэтгэлийн өдрийг сахих бидний чухал үүргийн талаар ярьдаг. Гибсон ах “Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих бидний арга зам нь Есүс Христийг үргэлж санах бидний гэрээний гадаад илрэл мөн” хэмээн хэлжээ.

Хүүхдүүд тань хүндэтгэлийн өдрийг ариунаар сахиж сурвал олон адислал хүлээн авахад бэлтгэгдэх болно. “Хэрэв бид хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих тэнгэрлэг зарлигийг биелүүлж, үүгээр амьдрах юм бол Их Эзэн хариуд нь биднийг адислан, удирдан чиглүүлж, тулгарсан асуудлуудыг шийдвэрлэхэд бидэнд сүнслэгээр нөлөөлөх болно” гэж Гибсон ах ярилаа.

## Өсвөр үеийнхэнд заах зөвлөмжүүд

- 56–57-р хуудсан дээрх Гибсон ахын өгүүллийг хамтдаа уншиж, танай гэр бүл хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихад бэлтгэхийн тулд долоо хоног бүр юу хийж болох талаар ярилц. Гэр бүлийн үдшээр “Gently Raise the Sacred Strain” (*Hymns*, дугаар 146) дууллыг эсвэл хүндэтгэлийн өдрийн тухай өөр дууллыг дуулж, танай гэр бүл хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихын тулд ням гарагт юу хийж болох талаар ярилцаж болно.
- *Залуучуудын бат бөх байдлын төлөө* товхимлын хүндэтгэлийн өдрийг сахих тухай хэсэг

болон товхимлын төгсгөлд жагсаасан судруудыг өсвөр насны хүүхдүүдтэйгээ хамт унш. Та нар хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих тухай бусад судруудыг хамтдаа хайж, хүндэтгэлийн өдрийг сахих олон зарчмын талаар ярилцаж болно.

- Мөн өсвөр насны хүүхдүүдтэйгээ хамт хүндэтгэлийн өдрийг сахихтай холбоотой видео бичлэгүүд үзэж, энэ тухай өгүүллүүдийг уншиж болох ба [youth.lds.org](http://youth.lds.org) рүү орж, цэсэн дэх “For the Strength of Youth” буюу “Залуучуудын бат бөх байдлын төлөө” гэсэн хэсэг дээр дарна уу. Дараа нь та Sabbath day observance буюу хүндэтгэлийн өдрийг сахих гэсэн хэсэг дээр дарвал холбогдох видео бичлэгүүд болон өгүүллүүдийг хуудасны баруун болон доод талаас олох болно. Хэрэв өсвөр үеийнхэнд зориулсан сургалтын хөтөлбөр төрөлх хэлээр тань байгаа бол Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих талаарх өгүүллүүд эсвэл видео бичлэгүүдийг олж, хичээлүүдийг нь ашиглаж болно. Суралцахын тулд [lds.org/youth/](http://lds.org/youth/)-д орж үзнэ үү. Есдүгээр сард судлах зарлигуудын талаарх хичээлүүд нь энэ сэдвийг заахад ашиг тустай байж болно.

## Хүүхдүүдэд заах зөвлөмж

- 2013 оны 10-р сарын *Лиахона*-аас “Шинэхэн дикон” өгүүллийг уншин, хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихад ариун ёслол ямар ач холбогдолтой байдаг талаар ярилцана уу.
- 2010 оны 3-р сарын *Лиахона*-аас “A Lesson in Reverence (Хүндэтгэлийн сургамж)”



## УГ СЭДЭВТЭЙ ХОЛБООТОЙ СУДРУУД

Египетээс гарсан нь  
20:8–11

Исаиа 58:13–14

1 Коринт 11:23–26

3 Нифай 18:31–32

Моронай 6:4–6

Сургаал ба Гэрээ

59:9–13

өгүүллийг уншихыг бод; түүнчлэн уг өгүүлэл дэх үйл ажиллагааг хийж болно. Сүм дээр хүндэтгэл бишрэлтэй байх нь хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихад хэрхэн тусалдаг тухай хүүхдүүдтэйгээ ярилц.

- Танай гэр бүл Их Эзэнийг дээдлэн, хүндлэхийн тулд ням гарагт юу хийж болох талаар ярилц. 2012 оны 3-р сарын *Лиахона*-аас “Decide Right Now (Яг одоо шийд)” өгүүллийг хүнд нөхцөл байдалд хүндэтгэлийн өдрийг ариунаар сахидаг хүний жишээ болгон, уншиж болно.
- Та хүндэтгэлийн өдрийн тухай зарим дуут тухайлбал, “Saturday (Бямба гараг)” (*Children’s Songbook*, дугаар 196) дуут хүүхдүүдтэйгээ дуулж болно. Танай гэр бүл бямба гараг болон долоо хоногийн бусад өдрүүдийг ням гарагт бэлтгэхэд хэрхэн ашиглаж болох арга замуудын тухай ярилцана уу. ■

*Ертөнцийн  
Бүтээгч, бид-  
ний авралын  
уран барилгач  
бөгөөд энэ сү-  
мийн тэргүүн  
Есүс Христ  
бүхнийг удирд-  
даг гэдгийг  
үргэлж  
санагтун.*



Ахлагч  
М.Рассэлл Баллард  
Арванхоёр  
Төлөөлөгчийн чуулга



# ИРЭЭДҮЙД ТОХИОЛДОХ ЗҮЙЛҮҮДЭД „ ИТГЭЛ, „ Найдвартайгаар БЭЛТГЭХ НЬ

Дэлхийн нөхцөл байдал тодорхой биш, аюултай байгаа; эдийн засаг нь тогтворгүй, урьдчилан тааварлах аргагүй байна. Аливааг хийх шинэ бөгөөд сэтгэл догдлом аргуудыг бий болгохын төлөө ур чадвар, авьяас билгээ ашиглахад бидэнд урам, дэм өгөхийн оронд биднийг албадан, бусдаас хамааралтай болгож, бидний сонгох эрхийг хязгаарлахыг хүсдэг хүмүүс амьдралын эрхэмлэх үнэт зүйлс, эрх чөлөө, аз жаргалын төлөөх эрлийг маань дайрч, давшилж байна.

Ёс суртахууны жишгүүд үгүй болж байна. Гэр бүл дайралтад өртөн, задарч байна. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн зүрх сэтгэл дэх хайр хөрч, байгалиас заяагдсан биш болж байна (Матай 24:12; Ром 1:31-р шүлгүүдийг үзнэ үү). Улс төр, бизнесийн болон бусад удирдагчдын зарчимч, зөв шударга байдал доройтсоор байна. Улс үндэстнүүдийн дунд дайн ба түүний тухай сураг чимээ тасрахаа болилоо. Сайн ба муугийн хоорондох эсвээс Бурханы хүүхдүүдийн бодгалийн төлөөх Аврагч болон Түүний гэрлийн арми, Сатан болон харанхуйг эрхэмлэгч түүний хилэнцэт дагалдагчдын хоорондох дайн нь аливаа зэвсэгт мөргөлдөөнөөс илүү сүйрүүлэгч үр дагавартай юм.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) өнөө үеийн залуучуудын амьдарч буй дэлхийг дүрслэхдээ “Хүний мөс чанараа алдсан хүмүүс аймшигтай, жигшүүрт зүйлсийг хийж байгаа энэ үед бид аж төрж байна. Бид дайн дажны үед амьдарч байна. Бид мөн харанхуй бүдүүлэг үед аж төрж байна. Бид бусармаг явдал, порнограф болон ёс суртахуунгүй үед амьдарч байна. Содом болон Гоморрагийн бүх нүглүүд манай нийгэмд бугшин, оршиж байна. Манай залуучууд ийм ноцтой сорилттой хэзээ ч тулгарч байгаагүй билээ. Бид чөтгөрийн шалиг завхай нүүрийг ийм тодорхойгоор харж байгаагүй юм” гэжээ.<sup>1</sup>

Хэрэв хүмүүс Бурханаас нүүр буруулбал өнөө үед дэлхийд юу тохиолдохыг судрууд болон бошигло-лууд гэрчилсэн учраас бид өөрсдийнхөө цаг үеийн ийм нөхцөл байдалд гайхах хэрэггүй юм. Бидэнд үүнээс ч илүү таагүй явдал тохиолдох болно, учир нь чөтгөр хилэнцэт төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхийн төлөө улайран тэмүүлсээр байна. Үүний сацуу, өнөө үе болон өнөөдрийн залуу үеийнхнийг харсан эртний бошиглогчид энэ цаг үе бол дэлхийд өмнө нь хэзээ ч тохиогоогүй, гэрэл хийгээд гайхамшгийн эрин үе байх болно гэдгийг мэдэж байжээ.

Би энэхүү захиасыг бэлтгэж байх үедээ Тэнгэрлэг Эцэг маань намайг юу хуваалцаасай хэмээн хүсэх бол гэдгийг мэдэхийн тулд Түүнээс удирдамж хүссэн билээ. Бошиглогч Иосеф Смитэд хандан Их Эзэний хэлсэн дараах найдвар төрүүлэм, тайтгаруулагч үгс санаанд минь орж ирлээ: “Зоригтой бай, учир нь би та нарыг удирдах болно. Хаант улс та нарынх болой . . . , мөн үүрд мөнхийн баялагууд та нарынх бөлгөө” (С ба Г 78:18).

### **Айдсыг итгэлээр орлуул**

Их Эзэн надаар хэлүүлэхийг хүссэн зүйл бол бид айдсыг итгэлээр—Бурхан болон Их Эзэн Есүс Христийн Цагаатгалын хүчинд итгэх итгэлээр орлуулах ёстой гэсэн захиас юм гэдэгт би итгэдэг.

Би 13 настай байхдаа 1941 оны 12-р сарын 7-ны ням гарагт болсон санваарын хурлаас гэртээ эргэж ирэн, дөнгөж өмнөхөн нь Япон улс Сувдан эрэг боомтыг бөмбөгдсөнийг эцэг эхээсээ мэдсэнээ санаж байна. Энэ нь Европт дэгдээд хоёр жил болж байсан дэлхийн дайнд Нэгдсэн Улсыг татан оруулсан юм. Бидний мэддэг амьдрал ингээд төгсөх нь энэ үү гэсэн бодол төрж билээ. Залуу эрэгтэйчүүдийг үй олноор нь цэргийн албанд дайчлан татсан тэр үе үнэхээр тодорхой бус цаг үе байлаа. Тэр үед дэлхий дээр одоогийнх шиг бүх төрлийн сөргөлдөөн, зөрчил тэмцэл, хилэнцэт нөлөө байсан ч гэсэн тэнд сайн зүйл байсаар байсан юм.

Бид ирээдүйн тухай бодохдоо итгэл, найдвараар дүүрэн байх ёстой. Ертөнцийн Бүтээгч, бидний авралын уран барилгач бөгөөд энэ сүмийн тэргүүн Есүс Христ бүхнийг удирддаг гэдгийг үргэлж санагтун. Тэрбээр Өөрийнх нь ажил бүтэлгүйтэхийг зөвшөөрөхгүй. Тэрбээр бүхий л харанхуй болон нүгэл хилэнцийг ялах болно. Тэрбээр Өөрийн сүмийн гишүүд болон зүрх сэтгэлдээ шударга бусад бүх хүмүүс, бид бүгдийг Бурханы

хүүхдүүдийн бодгалийн төлөөх тулалдаанд нэгдэхэд урьдаг билээ. Бид амьдралдаа хийдэг бүх зүйлийнхээ хажуугаар зүрх сэтгэл, чадвар, оюун ухаан хийгээд бүх хүч чадлаа Түүний үйлсэд зориулж; итгэл, үнэмшлээрээ амьдарч, ажиллах ёстой.

Ирээдүйг өөдрөгөөр угтагтун. Бид өсөлт дэвшил, цэцэглэн хөгжилт, элбэг хангалуун байдлын үед аж төрж байгаа гэдэгт би итгэдэг. Хэрэв байгалийн аюулт гамшиг болон олон улсын чанартай гэнэтийн хямрал болохгүй л бол ойрын хэдэн жилд мэдээлэл холбоо, анагаах ухаан, эрчим хүч, тээвэр, физикийн шинжлэх ухаан, компьютерийн технологи болон бусад салбаруудад шинэ нээлтүүд хийгдэн, дэлхийн эдийн засагт сэргэлт гарна гэж би боддог.

Өнгөрсөн үед болсонтой адил, эдгээр нээлтүүдийн ихэнх нь үнэнийг эрж хайдаг хүмүүсийн оюун ухааныг Сүнс гэгээрүүлж, шинэ мэдлэгийг тэдэнд шивнэсний үр дүн байх болно. Эдгээр нээлтүүд хийгээд улам боловсронгуй болсон шинэ технологийн ачаар шаргуу ажилладаг бөгөөд ялангуяа Бурханы зарлигуудыг сахихыг хичээдэг хүмүүст ажил эрхлэлтийн шинэ шинэ боломжууд нээгдэх болно. Энэ бол үндэсний болон олон улсын эдийн засгийн өсөлт хөгжилтийн түүхэн дэх гайхамшигтай үе юм.

Түүнээс гадна эдгээр нээлтүүдийн ихэнх нь Бурханы зорилгуудыг гүйцэлдүүлж, Түүний ажлыг яаравчуулах, ялангуяа номлолын ажлаар дамжуулан өнөө үед дэлхий дээр Түүний хаант улсыг байгуулахад туслахын төлөө хийгдэх болно.

### **Өөрт оногдсоноо хий**

Аврагчийн Хоёр дахь ирэлтээс өмнө Түүний бурханлаг цаг хугацаан дээр үндэслэн, сайн мэдээ бүх дэлхийг дүүргэх хүртэл бүх үндэстэн, ястан, хэлтэн болон хүмүүст хүрэх ёстой. Бошиглогч Иосеф Смит “Ямар ч бохир гар энэ ажлыг зогсоож чадахгүй; хавчлага дарамт гарч ирэн, дээрэмчид нэгдэж, арми цугларч, гүтгэлэг доромжлол ил гарсан ч Бурханы үнэн бүх нутагт айлчлан, бүх оронд нэвтэрч, бүх чихэнд сонсогдож, Бурханы зорилго гүйцэлдэн улмаар Аугаа Иехова ажил дууслаа гэж хэлэх хүртэл зоригтойгоор, еэлдэг зөөлнөөр, бие даан урагшлах болно” хэмээн тунхагласан билээ.<sup>2</sup>

Сүнсээр өлсөж, цангасан хэдэн тэрбум хүнд сайн мэдээг хүргэсэн үед Их Эзэний мутраар гайхамшгууд үйлдэгдэх болно. Олон үндэстний номлогчид дэлхий даяар Их Эзэнд үйлчлэх болно. Мянган жилийн өмнөх



***Бурханы зорилгуудыг гүйцэлдүүлж, Түүний ажлыг яаравчлуулах, түүний дотор номлолын ажлаар дамжуулан өнөө үед дэлхий дээр Түүний хаант улсыг байгуулахад туслахын тулд олон шинэ нээлтүүд хийгдэх болно.***

сүмийн өсөлт хөгжилтийн талаар бошиглогдсоны дагуу гэгээнтнүүдийг адислахын тулд шинэ шинэ цуглааны байр, улам олон ариун сүм баригдана.

“Ийм их өсөлтийг санхүүгийн ямар эх үүсвэрээр хангах юм бэ?” хэмээн та асууж магад. Санхүүгийн энэхүү эх үүсвэр нь итгэлтэй гишүүдийн аравны нэг болон өргөлдүүдээс ирэх болно. Бид өөрт оногдсоноо хийх үед Их Эзэн хөгжил цэцэглэлтээр, амьдралын хамгийн чухал асуудлууд дээр оюун ухаанаа төвлөрүүлэх мэргэн ухаанаар адислах болно. “Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” (Матай 6:33).

Тодорхой хугацаанд, магадгүй богинохон хугацаанд ч гэсэн “ивээлийг хальтал асгахын” (Малахи 3:10) тулд тэнгэрийн цонхнууд үнэхээр нээгдсэн юм шиг байх болно.

Хэрэв өнөөгийн залуучуудаас олон нь Их Эзэний зарлигуудыг сахих юм бол тэд материалаг адислалуудыг идэвхтэйгээр хүртэгчид байх болно гэдэгт би итгэдэг. Хөгжил цэцэглэлттэй хамт хувь хүний сүнслэг байдлыг турших сорилт бэрхшээлүүд ч гарч ирнэ. Та нар хөгжил дэвшлийн энэхүү шинэ ертөнцөд хөл тавин; боловсрол, авьяас чадвараа санхүүгийн талаар амжилт олоход ашиглахдаа хэргэцээ болон хүслийн хоорондох ялгааг харах хэрэгтэй.

### **Эхлээд Бурханы хаант улсыг эрэлхийл**

Та нар хоёр сонголттой тулгарах болно. Хувийнхаа эрх ашгийн төлөө; хүмүүсийн дундах өөрийн нэр төр, эрх мэдэл болон нөлөөг нэмэгдүүлэхийн төлөө Их Эзэний адислалуудыг эрэлхийлэн, олж авах явдал өөрийн тань эрмэлзэл байх уу? Эсвэл Бурханыг алдаршуулж, Түүний сүмийн өсөлт хөгжилт, өргөжилтэд туслахын төлөө ажиллах явдал өөрийн тань эрмэлзэл байх уу?

Өөрийгөө өргөмжлөхийн тулд баялгийг эрэлхийлэгчдийн үнэт зүйлс хэврэг бөгөөд үүнийг ухаалаг бус аргаар зарцуулбал амархан үрэгдэж, үгүй болно (Хиламан 13:31-ийг үзнэ үү). Тэдний сүнсний сайн сайхан байдал агуу эрсдэлд байх болно. Нифайн дуулгавартай дүү Иаков бидэнд анхааруулан,

“Мөн хангагч ариун мутар та нарын дээр ихэд тааламжтайгаар инээмсэглэж байсны учир та нар олон баялгийг эзэмшсэн билээ; мөн та нарын зарим нь ах дүүсээсээ илүү баялгийг эзэмшсэний учир та нар зүрх сэтгэлийн бардамналд өргөгдөж, мөн зөрүүдлэн дээгүүр хардаг учир нь та нарын өмсгөл чимэг үнэтэйн учир болой, мөн та нар өөрсдийгөө тэднээс илүү хэмээн бодох учир ах дүүсээ хавчих бөлгөө.

“... Бурхан та нарыг энэ зүйлд чинь зөвтгөнө хэмээн бодно уу? Болгоогтун, би та нарт хэлнэ, Үгүй. Харин тэр та нарыг буруушаана, мөн хэрэв та нар эдгээр

зүйлүүдэд энэ хэвээрээ үлдэх аваас түүний шүүлтүүд та нар дээр гэнэт ирэх ёстой.

“... Та нарын зүрхний энэ бардамнал бодгалийг тань устгахыг бүү зөвшөөрөөсэй!” гэжээ (Иаков 2:13, 14, 16).

Иаков дараа нь баялаг олж авах бидний учир шалтгааныг амлалттай зохих харьцаанд тавьж,

“Харин та нар баялгуудыг эрэлхийлэхийн өмнө, Бурханы хаант улсыг эрэлхийлэгтүн та нар.

“Мөн та нар Христэд найдах найдварыг олсныхоо дараа хэрэв та нар тэдгээрийг эрэлхийлэх аваас та нар баялгуудыг олох болно, мөн та нар тэдгээрийг сайныг үйлдэх зорилгын төлөө эрэлхийлэх болно—нүцгэнийг хувцаслахад мөн өлссөнийг хооллоход бас боолчлогдсоныг чөлөөлөхөд мөн өвдсөн бас зовсныг халамжлахад буюу” (Иаков 2:18–19) хэмээн хэлсэн.

Биднийг хөгжин дэвжих ёсгүй эсвээс хөгжил цэцэглэлт бол нүгэл хэмээн Их Эзэн бидэнд хэлээгүй. Харин эсрэгээр Их Эзэн дуулгавартай хүүхдүүдээ үргэлж адисалсаар ирсэн юм. Харин Тэрбээр бид Түүнийг эрж хайн, олж, Түүнд үйлчлэхийн төлөө хөгжил цэцэглэлтийг эрэлхийлэх ёстой гэж хэлдэг. Тэгвэл бидний зүрх сэтгэл зөв бөгөөд бид Түүнийг хамгийн түрүүнд бүхнээс илүү хайрладаг учраас бид олсон эд баялгаа Түүний хаант улсыг байгуулахад зориулахаар сонгох болно.

Хэрэв та зөвхөн эд баялаг олж авахын төлөө баялгийг эрэлхийлэх аваас үүнийгээ олж авч чадахгүй. Та хэзээ



### **ЗОРИГТОЙ БАЙ**

“Хүнд хэцүү нөхцөл байдал биднийг сүрдүүлж, сорилтууд амьдралд маань тохиолдлоо ч гэсэн бид цэх шулуун алхалж, зарлигуудыг сахих юм бол сайн мэдээний тухай мэдлэг мөн Тэнгэрлэг Эцэг

болон Аврагчаа хайрлах хайр маань биднийг тайтгаруулж, дэмжин туслах болно. Энэ дэлхийд биднийг ялж чадах юу ч байхгүй.

“Хайрт ах, эгч нар минь, бүү ай. Зоригтой бай. Ирээдүй та бүхний итгэл шиг гэрэлтэй байна.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Зоригтой бай,” *Лиакхона*, 2009 оны 5-р сар, 92-р хуудас.

ч сэтгэл хангалуун байхгүй. Та хоосон, донгио болж, аз жаргал болон өнө удаан үргэлжлэх баяр баясгаланг хэзээ ч олохгүй.

Дараагийн хэдэн жилд таны итгэлийн сорилт дэлхийн эд зүйлсээр дутагдах явдал биш байх болов уу. Харин хүлээн авсан материаллаг адислалуудаа юунд зориулахаар сонгоход итгэл тань соригдоно.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бэнсон (1899–1994) өнөөдөрийн залуу үеийнхний талаар

“Бурхан та нарыг Их Эзэний Хоёр дахь ирэлтийн өмнөх эцсийн өдрүүдэд дэлхийд ирүүлэхээр бараг зургаан мянган жилийн турш нөөцөнд байлгасан юм. . . .

“... Бурхан хаант улсаа ялгууснаар удирдахад туслах Өөрийн хамгийн хүчирхэг зарим хүүхдүүдийг . . . эцсийн өдрүүдэд зориулан хадгалжээ” гэж хэлсэн билээ.<sup>3</sup>

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Та нар бол Тэнгэрлэг Эцэгийн хамгийн хүчирхэг хүүхдүүд бөгөөд Тэрбээр та нарыг ‘үүн шиг ийм цагийн төлөө’ [Естер 4:14] дэлхийд ирүүлэхээр хадгалан үлдээсэн юм” гэжээ.<sup>4</sup>

Та нар энэхүү эцсийн өдрүүдийн “ер бусын ажил мөн гайхамшгийн” (2 Нифай 25:17) хамгийн чухал хэсэг нь байхын тулд өөрийн хүслийг Бурханд захируулан, үүнийг Түүний хүсэлд багтаах боломжийг ологтун. Та нар “найджарын төгс гэрэлтэйгээр мөн Бурханыг болон бүх хүмүүсийг хайрлах хайрыг агуулан . . . Христийн үгэн дээр найрлан,” (2 Нифай 31:20) хичээнгүйлэн судалж, үргэлж залбиран, итгэлтэй байвал Их Эзэн амласны дагуу “та нарын сайн сайхны тулд бүх зүйл хамтдаа ажиллах болно” (С ба Г 90:24).

### **Бүхнээ зориулж, өргөл болго**

Би та бүхнээс Аврагчийн Хоёр дахь ирэлтэд бэлтгэхийн төлөө, Есүс Христийн сүмийг байгуулахад амьдралаа зориулж, цаг зав болон авьяас чадвараа өргөл болгон өгөх амлалтыг өөртөө болон Тэнгэрлэг Эцэгтээ өгөхийг хичээнгүйлэн хүсч байна. Бодол санаа, үйлдлүүдийн тань учир шалтгаан нь Бурханыг алдаршуулж, хөршөө адислахын төлөө байг. Энэхүү хүсэл тань шинэ өглөө бүрийг урам зоригтойгоор утгахад танд сүнслэгээр нөлөөлж, өдөр бүрийн бодол санаа болоод үйлдлүүдэд тань хөдөлгөх хүч болж байг.

Хэрэв та үүнийг хийвэл замаа түргэн алдаж байгаа энэ дэлхийд адислагдан, хайртай хүмүүсийнхээ хамт амар амгалан, аз жаргалтай байх болно. Энэ нь та нарт сорилт, бэрхшээлүүд тохиолдохгүй гэсэн хэрэг биш харин Их Эзэнд итгэх итгэлээр сорилт, бэрхшээлүүдийг



## СУРГААЛЫН ЗААЛТУУД

Хэрэв бид дараах зүйлсийг хийвэл ирээдүйн тухайд өөдрөг бодолтой байж чадна:

- Есүс Христийн Цагаатгалын хүчинд итгэх итгэлээ тордох.
- Өөрсдийн амьдралд Тэнгэрлэг Эцэгийг нэгдүгээрт тавих.
- Бурханы хаант улсыг байгуулахад амьдрал болон цаг заваа зориулах.



шийдвэрлэх сүнсний хүч чадал та нарт байх болно гэсэн үг юм.

Миний захиасын зорилго бол ирээдүйгээ угтан харахад тань та нарт туслах явдал юм. Гэрэлт ирээдүйгээ угтах итгэл, найдвартай байгун. Залуу эрэгтэйчүүд та нар ирээдүйн эцэг, залуу эмэгтэйчүүд та нар ирээдүйн эх, халамжлан хүмүүжүүлэгчид билээ. Та нар хамтдаа “сонгогдсон угсаа, хаант тахилч нар, ариун үндэстэн, Бурханы эзэмшлийн ард түмэн” (1 Петр 2:9) юм.

Хэрвээ та гэрлээгүй бол эрэгтэй, эмэгтэйчүүд та нарын аль алиных нь хувьд хамгийн түрүүнд эрхэмлэх зүйлсийн нэг нь мөнхийн ханиа олж авах явдал мөн. Та ариун сүмд гэрлэснээр Тэнгэрлэг Эцэг, Их Эзэн Есүс

Христ хоёрын дэргэд буцаж очих зөв зам дээр байхад тань туслах ханьтай болно. Бид Хоёр дахь ирэлтэд цааш бэлтгэхдээ өөрөөсөө хамаарах бүхнийг хийх ёстой. ■

*2012 оны 4-р сарын 6-нд Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль дээр хэлсэн үгээс. Англи хэл дээрх бүрэн эхийг [web.byui.edu/devotionalsandspeeches/speeches.aspx](http://web.byui.edu/devotionalsandspeeches/speeches.aspx)-аас үзнэ үү.*

### ЭШЛЭЛҮҮД

1. Гордон Б.Хинкли, “Living in the Fulness of Times,” *Лиахона*, 2002 оны 1-р сар, 6-р хуудас.
2. Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: *Иосеф Смит* (2007), 142-р хуудас.
3. Эзра Тафт Бэнсон, “Ганцаар зогсох зоригтой бай,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 62-р хуудас.
4. Томас С.Монсон, “Танд урам зориг байг (May You Have Courage),” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 127-р хуудас.



# Мексик

ТЭМЦЛЭЭС ХҮЧ ЧАДАЛД ХҮРСЭН НЬ

*Мексик дэх хожмын үеийн гэгээнтнүүд эх орондоо гэрэлт сайхан ирээдүйг авчрахаар итгэлийнхээ өвийг цогцлон байгуулж байна.*

## Сэлли Жонсон Өүдкөрк

Сүмийн сэтгүүлүүд

1945 оны 11-р сарын 6-нд Мексикийн хожмын үеийн гэгээнтнүүдийн анхны бүлэг төрөлх хэлээрээ ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахаар Аризонагийн Меса ариун сүмд хүрч ирэхэд тэдний залбирал хариулагджээ. Тэр үед Монтэрри салбарын ерөнхийлөгч байсан Хосэ Грациа “Бид өөрсдийнхөө болон өвөг дээдсийнхээ төлөө агуу ажлыг хийхээр ирээд байна. . . . Магадгүй бидний зарим нь золиослол хийсэн байх, гэхдээ энэ золиослол дэмий хоосон зүйл биш юм. Бид тийнхүү золиослол хийсэндээ баяртай байна” гэж ярилаа.<sup>1</sup>

Ерөнхийлөгч Грациа болон ариун сүмд орохоор ирсэн хүмүүс сэргээгдсэн сайн мэдээний төлөө мөн ийнхүү золиослол хийсэн Мексикийн эхэн үеийн анхдагчдын зам мөрийг дагасан ажээ.

## Суурийг тавьсан нь

Өндөр уулс, элсэн цөл, халуун орны ширэнгэн ой, ер бусын үзэсгэлэнт далайн эргээр хүрээлэгдсэн эртний Мексик бол гоёмсог ариун сүм болон сайхан хотууд барьж байгуулсан хүмүүсийн эх орон юм. Хэдэн зууны туршид мексикчүүд итгэл болон залбирлын хүчирхэг суурийг бий болгосон нь хүнд нөхцөл байдлаа даван туулахад нь тэдэнд тусалсан ажээ.

Гэгээнтнүүд Ютад сүм байгуулж байсан үед мексикчүүд нийгмийнхээ бүтцийг, түүний дотор сүмийг төрөөс тусгаарласан шинэ үндсэн хуулиа боловсруулахаар ажиллаж байв. Мексикт сайн мэдээний захиасыг 1876 онд анхны номлогчид авчирсан ажээ. Тэд Мормоны Номоос түүвэрлэж авсан хэсгүүдийг авч явдаг байсан



Ерөнхийлөгч Жорж Альбэрт Смит Мексикт айлчлан, Гуравдугаар конвенцэд хандаж, гишүүдийг нэгтгэхэд тусалжээ.

1810 он: Испанийн захиргаанд 300 жил болсны эцэст 1821 онд Мексик орон тусгаар тогтнолоо тунхаглаж, тусгаар улс болов.

1830 он: АНУ-ын Нью-Йорк мужийн Палмирад сүм зохион байгуулагдаж, Мормоны Ном хэвлэгдэв.



1846–1848 он: Мексик-Америкийн дайн болж, анхдагч мормончууд Нэгдсэн Улсын өрнөд нутагт суурьшив.



1857–1861 он: Ерөнхийлөгч Бенито Хуарез Мексикийн засгийн газрыг шинэчилж, шашны эрх чөлөөг тунхаглав.

ба Мексикийн нөлөө бүхий удирдагчдад шуудангаар явуулдаг байжээ. Удалгүй хүмүүс баптисм хүртэж эхлэв.

1881 оны 4-р сарын 6-нд болсон сүмийн тусгай чуулганы үеэр салбарын ерөнхийлөгч Силвиано Артэга мөн орон нутгийн нэлээд хэдэн удирдагч болон төлөөлөгч Мозес Тэтчэр (1842–1909) нар Попокэтэпэтл галт уулын бэл дээр гарчээ. Тэгэхэд ахлагч Тэтчэр сайн мэдээг номлохоор тус орныг онцгойлон адисалсан ажээ.

Чуулган дээр ерөнхийлөгч Артэга залбирав. Ахлагч Тэтчэр энэ тухай “Улс үндэстэн болон ард түмэн нь чөлөөлөгдсөний төлөө түүний үрчлээт хацрыг даган, нулимс урсаж байлаа. . . . Хүн ийнхүү сэтгэл зүрхнийхээ угаас залбирч байхыг би хэзээ ч сонсоогүй. Хэдийгээр энэ нь миний ойлгохгүй хэл байсан ч түүний гуйсан бүхнийг би Сүнсээр ойлгосон мэт санагдсан”<sup>2</sup> гэжээ.

Энэ үеэр тус бүсэд Мексикийн нэлээд хэдэн салбар зохион байгуулагдав. Хидалго мужийн настай бэлэвсэн эмэгтэй Дэсидэриа Янэз Парли П.Праттын *A Voice of Warning (Сэрэмжлүүлгийн дуу хоолой) товхимлын тухай зүүдэлсэн ажээ*. Тэрээр испани хэлээр дөнгөж орчуулагдаад байсан тэрхүү товхимлыг олж авахаар хүүгээ Мехико хот

руу явуулжээ. Янэз эгч 1880 онд сүмд нэгдэж, Мексик дэх сүмд элссэн анхны эмэгтэй болсон юм.<sup>3</sup>

Тэр үеэс хойш одоог хүртэл Мексик дэх сүмийн олон гишүүд хувьсгал, хавчлага, ядуу зүдүү байдал болон тусгаарлалтын олон арван жилийн туршид итгэлтэй хэвээр байна.<sup>4</sup>

## Итгэлтэй анхдагчдын үлгэр жишээ

1907 онд зохион байгуулагдсан Сан Пэдро Мартир салбараас энэхүү итгэлтэй байдлын нэг жишээг харж болно. Шинээр баптисм хүртэж, салбарыг тэргүүлэхээр дуудагдсан Агустин Харогийн барьсан Мехико хотын өмнөд хэсэгт байрлах нэгэн байранд анхны гишүүд цугладаг байв. Мексикийн хувьсгалын хүнд жилүүдэд дор хаяж нэг сая мексик хүн амь үрэгдэж, муж нь тулааны талбар болсон үед олон гэгээнтнүүд толгой хоргодох газар хайн, Сан Пэдро руу дүрвэжээ. Сан Пэдро дахь Халамжийн Нийгэмлэгийн эгч нар дүрвэгчдэд өрөвч сэтгэлийн ихээхэн үйлчлэлийг үзүүлсэн юм.<sup>5</sup>

Гишүүд нь түүнчлэн бүхнээ зориулсан Рэй Л.Пратт зэрэг удирдагчдаар адислагдсан юм. Тэрээр 1907 онд



Мексикийн номлолын ерөнхийлөгчөөр дуудагдсан бөгөөд 1931 онд нас бартлаа уг дуудлагадаа үйлчилжээ. Тэр Мексикийн түүх, соёлд болон хүмүүст нь хайртай байсан бөгөөд сүмийн суурийг тэнд бэхжүүлэх үйлсэд тэдэнтэй хамтран ажиллахдаа хайр болон итгэл, хүндэтгэлийг нь хүлээсэн ажээ. 1926 онд Мексикийн засгийн газар гадаадын хүмүүс Мексик дэх сүмүүдийг тэргүүлэхийг хориглосон хууль гаргахад сүмийн мексик үндэстэн удирдагчдыг бий болгон, сургахад ерөнхийлөгч Праттын хичээл зүтгэл онцгой ач холбогдолтой байлаа.<sup>6</sup> Энэ үед хэсэг гишүүд Гуравдугаар конвенци хэмээн

байсан ахлагч Жозеф Фийлдинг Смит (1876–1972) Нэгдсэн Улсын Аризона дахь сүмийн орон нутгийн удирдагчидтай уулзсаныхаа дараа “ариун сүмийн хуралдаанд англи хэл ноёрхох шалтгааныг би олж харахгүй байна” гэж хэлжээ.<sup>8</sup> Далын ахлагч Антоин Р. Айвинс, Эдуардо Балдэрас нар сүмийн орчуулгын албанаас ариун сүмийн ёслолуудыг испани хэлээр орчуулж өгөхийг хүсчээ. Энэхүү орчуулга нь бусад газруудад баригдах ариун сүмүүдэд чухал шатыг тавьсан юм.<sup>9</sup>

Аризонагийн Мэса ариун сүм дэх ариун сүмийн ёслол испани хэл дээр явагдах боломжтой болсны сацуу сүмийн ерөнхийлөгч



## ИХ ЭЗЭНИЙ ТААЛЛЫГ ХҮЛЭЭСЭН ХҮМҮҮС

“Одоогийн энэ тэмцлээс илүү агуу, илүү сайхан Мексик орон цэцэглэн хөгжинө гэдэгт хэн ч эргэлзэхгүй байна. . . . Гэтэлгэлийг мөн Их Эзэний таалалд нийцсэн хүмүүс болгох сайн мэдээг энэ орны хүмүүст авчирч, үнэн сайн мэдээг заах арга зам бэлтгэгдэх болно.”<sup>17</sup>

Мексикийн хувьсгалын үед Мексикийн номлолын ерөнхийлөгч байсан Рэй Л. Пратт

1875 он:  
Мормоны  
Номын зарим  
хэсгүүд испани  
хэл рүү  
орчуулагдаж,  
хэвлэгдэв.

1876 он:  
Анхны  
номлогчид  
Мексик рүү  
явав.



1881 он: Онцгой чуулган болов. Төлөөлөгч Мозес Тэтчэр тус орныг номлолын ажилд зориулан онцгойлон адислав.



1885 он: Мормоны эзэмшил газрууд Мексикт үүсэн бий болов.

1886 он: Мормоны Ном бүтнээрээ испани хэлээр хэвлэгдэн гарав.

нэрлэгдсэн байгууллагыг үүсгэн байгуулж, өөрсдийн удирдагчдыг дуудан, цуглааны байрууд барьж эхэлжээ.

## Суурин дээр барьсан нь

Арвэлл А. Пийрс 1942 онд Мексикийн номлолын ерөнхийлөгчөөр дуудагдав. Чихуахуад өсч, Мексикт номлолд үйлчилсэн туршлага дээрээ тулгуурлан ерөнхийлөгч Пийрс гишүүдэд зааж, тэднийг хүчирхэгжүүлэн, эв нэгдлийг бэхжүүлэхэд нь туслахдаа хайр болон ойлголтоор тэдэнд хүрч байлаа. Тэр бас Гуравдугаар конвенцийн гишүүдтэй тэдний асуудлуудыг шийдвэрлэх талаар хамтран ажилладаг байв.

Ерөнхийлөгч Пийрсийн нэг зорилго нь ариун сүмд явахад нь гишүүдэд туслах явдал байв.<sup>7</sup> 1943 онд ариун сүмийн адислаалуудыг улам олон гишүүдэд хүртээмжтэй болгох талаар их хүч чармайлт гаргажээ. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын гишүүн

Анхны гишүүд сайн мэдээний төлөө агуу золиослолууд хийдэг байлаа.





## ГАЙХАМШИГ-ТАЙ ИРЭЭДҮЙ

“Мексик дэх сүмийн ирээдүй хүн бүхний хувьд, түүнчлэн үүнд гар бие оролцож байгаа хүмүүсийн хувьд ч гайхамшигтай байх болно. Мексикчүүд амьдарч байгаа нийгмээ маш сайн мэддэг бөгөөд тэдний хүсдэггүй зарим зүйлс нийгэмд нь байдаг ажээ. Тэд сайн мэдээний санал болгодог зүйлсийг нүдээр харж, түүнийг хүсч байгаа бөгөөд үүний төлөө ямар ч төлөөсийг төлөхөд бэлэн байгаа” гэж би боддог.<sup>18</sup>

Мексикийн бүсийн ерөнхийлөгч, ахлагч Даниэл Л.Жонсон

Жорж Альбэрт Смит (1870–1951) Мексикийн гэгээнтнүүдийн эв нэгдлийг бэхжүүлэхэд туслахын тулд 1946 онд Мексикт айлчилснаар өмнөх үеийнхний зөвхөн 4 төсөөлж байсан тийм арга замаар<sup>10</sup> сүм өсөж эхэлсэн юм. Улс орон даяар шинэ номлолууд болон гадаснууд байгуулагдаж, сүмийн ивээн тэтгэдэг сургуулиуд боловсролд дэмжлэг үзүүлсэн ажээ.

Сүм 1964 онд Эл Сэнтро Эсколар Бэнэ-мэрито дэ Лас Америкас (El Centro Escolar Benemerito de las Americas) сургуулийг онцгойлон адисалсан ба уг сургууль 2013 онд номлогчийг бэлтгэх төв болох хүртлээ гишүүдийн боловсрол, нийгмийн үйлчлэл,

бидний төсөөлж байснаас бүр илүү сайхан боллоо!” хэмээн дуу алдсан ажээ.<sup>13</sup>

1970-аад он бол Мексик дэх сүмийн өсөлтийн сэтгэл догдлом үе байлаа. 1970 онд Мексик бараг 70 000 гишүүнтэй болсон бол уг оны эцсээр гишүүдийн тоо бараг 250 000-д хүрчээ. Тус бүсийн чуулганаас хойш гурван жилийн дараа ахлагч Ховард В. Хантэр (1907–1995) тэр үеийн гурван гадсыг долоо хоногийн дотор 15 гадас болгон хувааж, Мексикийн олон залуу гишүүдийг удирдагчдаар нь дуудсан юм.<sup>14</sup>

Энэ үеэр номлолын ажил ч бас өргөжин тэлсэн билээ. Мексик номлол 1879 онд албан

1889 он:  
Номлогчид  
төв Мексикээс  
гарав.

1901 он:  
Мехико хот  
орчимд сайн  
мэдээг дахин  
номлож эхлэв.

1910 он:  
Мексикийн  
хувьсгал  
эхлэв.



1912 он: Мексикийн хойд нутаг дахь Мормоны эзэмшил газруудаас хүмүүс олноороо дүрээв.

1913 он: Хувьсгалын үйл ажиллагааны улмаас номлогчдыг буцаан татав. Номлолын ерөнхийлөгч Рэй А.Пратт Нэгдсэн Улс дахь испаниар ярьдаг хүмүүстэй хамтран ажиллаж, тохиролцооноор Мексик дэх сүмийг удирдаж байлаа.

сүнслэг байдал болон удирдлагын хэрэгцээнд үйлчлэл үзүүлдэг байлаа.<sup>11</sup> Энэ сургуулийг төгссөн Лорена Гомэз-Альвэраз эгч “Бэнэмэ-рито сургууль надад авьяасаа нээн хөгжүүлж, амьдралыг минь адисалсан сайн мэдээний суурь мэдлэг эзэмшихэд тусалсан юм. Одоо энэ сургууль сайн мэдээг дэлгэрүүлэхэд номлогчдод тусалж, хүмүүсийн амьдралыг өөр замаар адисалсаар байх болно” гэжээ.<sup>12</sup>

### Өсөлтийн эрин үе

1972 онд Мехико хотод болсон бүсийн чуулган сүмийн өсөлтөд бас нэгэн чухал үе байв. Гишүүд ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973), түүний зөвлөхүүд мөн хэд хэдэн төлөөлөгч болон бусад удирдагчдын хэлэх үгийг сонсох гэж алс холоос ирж байлаа. Табэрнэкийн найрал дуу тоглосон нь сүнслэг баярт улам хөг нэмэв. Чуулганд оролцогчид “манай эх оронд болсон энэ чуулган

ёсоор нээгдсэн бөгөөд анх 1956 онд хуваагдсан бол одоо Мексик улс 34 номлолтой болоод байна.<sup>15</sup> Мехико хотын хойд номлолд 1980-аад оны үед үйлчилж байсан Жоргэ Замора ах сүмийн өсөлтийн гэрч болсон хүн юм. Гишүүд нь сүм рүүгээ бүтэн цаг явж, хүрдэг байсан нэг газар түүний номлолд байсныг тэрээр дурддаг бөгөөд одоо тэнд гадас байгуулагдажээ. “Ямар улс орон, ямар соёл заншилтай гэдгээс үл хамааран сүм байгуулахаар Их Эзэний ажилладаг арга зам надад гайхалтай санагддаг” гэж тэр хэлсэн.

### Ариун сүмүүд тархсан орон

Мексикийн гишүүд ариун сүмийн авралын ёслолуудад дуртай бөгөөд ариун сүмд шүтэн бишрэхийн тулд цаг зав, мөнгөө золиослоход ямагт бэлэн байдаг. Ахлагч Тэтчэр сайн мэдээг номлохоор тус орныг онцгойлон адисалснаас хойш 100 гаруйхан жилийн дараа Мехико хотод ариун сүм





Мексикийн гишүүд нийгмийн үйлчлэлийн төслүүдэд оролцдог. Эдгээр гишүүд 2007 онд мод тарихад тусалжээ.

## МЕКСИКИЙН АНХНЫ ГАДАСНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ АГРИКОЛ ЛОЗАНО ХЭРРЭРА

Агрикол Лозано Хэррера тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын гишүүн байсан ерөнхийлөгч Спенсэр В.Кимбаллын (1895–1985) хэлсэн үгийг сонсохдоо сүмийн залуу гишүүн байжээ. Ерөнхийлөгч Кимбалл эх орноо хүчирхэг болгоход туслахын тулд Мексикийн гишүүдийг боловсролтой болохыг нь дэмждэг байв. Лозано ах хуульч болж, эх орныхоо уугуул иргэдийг өмгөөлөхөөр шийдсэн ажээ. Тэр бас Мексик дэх сүмийн ерөнхий зөвлөх байсан бөгөөд Мексикийн анхны гадасны ерөнхийлөгч, номлолын ерөнхийлөгч, Арванхоёр Төлөөлөгчийн бүс нутгийн төлөөлөгч мөн Мехико хотын ариун сүмийн ерөнхийлөгчөөр үйлчилжээ.<sup>19</sup>



1921 он: Мехико хотын бүсэд номлогчдыг дахин томиллов.

1926 он: Мексикийн үндэсний үзэл гадаадын шашныхныг эх орноосоо хөөн гаргахад хүргэв.

1930-аад он: Орон нутгийн удирдагчид Мексик дэх сүмийн тогтвортой байдлыг хадгалж байлаа.



1945 он: Ариун сүмийн ёслолыг испани хэл дээр орчуулж, Аризоны Мэса ариун сүм рүү аялалууд эхлэв.



баригдав. 1983 онд болсон нээлттэй хаалганы үйл ажиллагаагаар мянга мянган хүмүүс ирж, ариун сүмийг үзэн, илүү их мэдээлэл хүсч байсан нь Мексик дэх сүмийг олон түмэнд таниулахад тусалсан юм. 30 жилийн дотор улс орон даяар дахиад 11 ариун сүм онцгойлон адислагдсан бөгөөд одоо дахин нэг ариун сүм баригдаж байна.

Изабэл Лэдэзма эгч Тампикод өссөн бөгөөд эцэг эх нь Аризоны Мэса ариун сүмд лацдан холбогдсоныг санадаг ажээ. Тэрээр: “Аризона руу явахад хоёр өдөр шаардлагатайгаас гадна өртөг зардал маш өндөр байв. Харин Мексикийн Мехико хотын ариун сүм онцгойлон адислагдсанаар бид машинаар ердөө 12 цаг явдаг болсон. Одоо Тампикод ариун сүмтэй болсон учир бид тэнд байнга орж болно” гэжээ.

2007—2010 онуудад Мексикийн Оаксака ариун сүмийн ерөнхийлөгчөөр үйлчилж байсан Лимхай Онтивэрос “Сайн мэдээний

тухай гүнзгий, бат бөх гэрчлэлтэй хүмүүс ариун сүмийг хоргодох гэрэлт цамхаг гэж үздэг бөгөөд тэд хол зай, санхүүгийн бэрхшээлийг үл харгалзан тийшээ очих арга замыг олдог” гэж яриу.

Лэдэзма эгч “Манай хотуудад Сүнс хэрэгтэй байгаа ба ариун сүмтэй болсон нь үүнд тусалж байна. Бидэнд асуудал тулгарсан болон уйтгар гунигтай байгаа үед ариун сүм дэргэд байгаа болохоор бид тэндээс амар амгаланг олдог” хэмээн нэмж хэлсэн юм.

### Бэрхшээлийг даван туулж байгаа нь

Мексикийн гишүүдэд нийтлэг сорилт, уруу таталтууд тулгардаг ч тэд өөрсдийгөө болон гэгээнтэн нөхдөө хайрт Эцэгийн хүүхдүүд гэдгийг мэддэг учраас эдийн засаг, нийгмийн байдал нь тэдний хувьд бие биедээ хэрхэн хандахад нөлөөлөх гол хүчин зүйл биш ажээ.

Мэндэвийн гэр бүл өмнөд Мексикийн



Оаксака хотын ойролцоох уулын нэгэн жижигхэн хотод амьдардаг. Тэд “Цаг хугацаа, санхүү болон алс холын зай зэрэг сорилт бэрхшээлүүд байдаг ч Аврагч биднээс хийхийг хүсдэг зүйлсийг хийх хүсэлтэй байх нь аливаа саад бэрхшээлийг даван туулах чин хүсэл эрмэлзлийг бидэнд төрүүлдэг” гэцгээлээ.

15 настай Гонзало Мэндээ “Та аюултай газарт амьдардаг бол уруу таталтууд үнэхээр хэцүү байж болно, гэвч бид залбирлын тусламжтайгаар дэлхийн уруу таталтуудад автагдахгүй байж, илүү сайхан амьдралын замыг гэрчлэгчид болж чадна” гэж хэлэв.

үүрэг хариуцлага гэдгийг Жэйм, Алэкс хоёр мэддэг ажээ. “Бусдад үйлчилж, сайн мэдээг номлох замаар Бурханы нэрийг алдаршуулахын тулд санваарыг залуу эрэгтэйчүүдэд олгодгийг би мэднэ” гэж Жэйм хэлэв.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Нийл Л.Андэрсэн саяхан Мексикт айлчлах үеэрээ Канкун хотын гурван гадасны өсвөр үеийнхэнтэй уулзжээ. Өсвөр үеийнхэнтэй хамт байсан үеийнхээ тухай тэрээр: “Тэдний нүдэнд гэрэл, нүүрэнд нь найдвар болон хүсэл мөрөөдөл байгааг бид олж харсан. Мексикийн ирээдүй ямар сайхан байх болоо? Хэмээн би удтал бодож билээ” гэж ярьжээ.<sup>16</sup> ■

1946 он:  
Ерөнхийлөгч  
Жоржс Аль-  
бэрт Смит  
Мексикт  
айлчлав.



1950-иад он:  
Мексикийн  
бараг бүх  
мужсуудад  
дүүрэг, салба-  
рууд зохион  
байгуулагдав.

1961 он: Мехико  
хотын гадсыг  
зохион бай-  
гуулж, Харольд  
Браун ерөнхий-  
лөгч нь болов.



1964 он: Мехико  
хотод Бэнэмэ-  
рито сургууль  
нээгдэв.

1967 он: Мехико хотод  
хоёр дахь гадас зохион  
байгуулагдаж, Агрикол  
Лозано Хэррера мексик  
үндэстний анхны га-  
дасны ерөнхийлөгчөөр  
дуудагдав.

1972 он:  
Мехико  
хотод  
бүсийн  
чуулган  
болов.

### Ирээдүйг харахуй

Сайн мэдээ Мексикт хүрээд удаж байгаа ч сүм дөнгөж хөгжиж байгаа бүс нутгууд байсаар байна. Оаксака хотын дэргэдэх нэгэн жижигхэн хотод 15 настай Жэйм Круз болон түүний гэрийнхнээс өөр сүмийн нэг ч гишүүн байдаггүй ажээ. Тэр найз Гонзалогийнхаа хамт долоо хоногийн турш гэрээр судлах семинарт суралцдаг байна. Тэд бямба гараг бүр тойргийнхоо бусад өсвөр насныхантай хамт семинарын хичээлд суухын тулд хамгийн ойрхон цуглааны байр хүртэл автобусаар хоёр цаг явдаг ажээ. Жэйм семинараас сурсан зүйлээ сургууль дээрээ ангийнхантайгаа хуваалцаж, тэдний асуулуудад хариулдаг гэнэ. Жэймийн дүү Алэкс сүмдээ дикон бөгөөд найз нарынхаа дунд удирдагч ажээ. Алэкс тэднээс хараал хэлэхгүй байх, зохисгүй хувцас өмсөхгүй байхыг хүсэхэд найз нар нь түүний үгийг сонсдог гэж хэллээ. Санваар атгах нь нэр төр болон




### ЭШЛЭЛҮҮД

1. Хэнри А.Смит, “200 Lamanites Gather in History-Making Conference, Temple Sessions,” *Church News*, 1945 оны 11-р сарын 10, 8-р хуудас.
2. Мозэс Тэтчэр, *Moses Thatcher Journal, 1866–1868*, 54-р хуудас.
3. Британи А.Чэпмэн ба Бага Ричард Э.Төрли, *Women of Faith in the Latter Days*, боть1, 1775–1820, 461–470-р хуудасууд.
4. Оорсон Скотт Кард, “It’s a Young Church in . . . Mexico,” *Ensign*, 1977 оны 2-р сар, 17–24-р хуудасуудыг үзнэ үү.
5. Көрк Хэнриксэн, “Mexican Mormon Pioneers (Мексикийн Мормон анхдагчид),” Мексикийн Мехико хотын ариун сүмийн зочдын төвд 2010 онд гаргасан үзэсгэлэн.
6. Гэрри Р.Фэйк, “Mormons in Mexico: The First 96 Years,” *Ensign*, 1972 оны 9-р сар, 20–21-р хуудасуудыг үзнэ үү.
7. ЛаМонд Тюалис, “A Shepherd to Mexico’s Saints: Arwell L.Pierce and the Third Convention,” *BYU Studies* боть37, 1 (1997): 127–151-р хуудасууд.
8. Эдуардо Балдэрас, “Northward to Mesa,” *Ensign*, 1972 оны 9-р сар, 30-р хуудсыг үзнэ үү.
9. Эдуардо Балдэрас, “Northward to Mesa,” 30–31-р хуудасуудыг үзнэ үү.
10. “The Church Moves On,” *Improvement Era*, July 1946 оны 7-р сар, 44б; Жон Д.Гилэс, “Father Lehi’s





## МЕКСИК ДЭХ СҮМИЙН ӨСӨЛТ



**Ариун сүм:** 12  
 ариун сүмтэйгээс  
 гадна 1 ариун  
 сүм Тихуанад  
 баригдахаар  
 зарлагдсан  
**Гадас:** 222  
**Дүүрэг:** 36  
**Тойрог, салбар**  
 2 000  
**Номлол:** 35

\*2013 оны 6-р сарын  
 байдлаар

1975 он:  
 Мексикийн  
 хэд хэдэн  
 бүсэд 12 шинэ  
 гадас зохион  
 байгуулагдав.



1983 он: Мехико хотын ариун сүмийг онцгойлон адислав.

1993 он:  
 Мексикт сүмийг албан ёсоор хүлээн зөвшөөрөв.

2000 он: Есөн жилиг ариун сүм онцгойлон адислагдав.



2009 он: Бүх Мексикийн бүсийн анхны ерөнхийлөгчийн зөвлөл дуудагдав.



2013 он: Мехико хотод номлогчийг бэлтгэх төв нээгдэв.

- Children," *Improvement Era*, 1946 оны 9-р сар, 556-р хуудсыг үзнэ үү.
- Иосеф Вокер, "Missionary surge prompts LDS Church to open new MTC in Mexico," *Deseret News*, 30, 2013 оны 1-р сарын 30, [www.deseretnews.com](http://www.deseretnews.com)-ыг үзнэ үү.
  - Энэхүү эшлэл болон Мексик дэх сүмийн одоогийн гишүүдийн дараах эшлэлүүдийг 2013 оны 2-р сарын 7-нд зохиогчтой хийсэн ярилцлагаас авчээ.
  - Жэй М.Тодд, "The Remarkable Mexico City Area Conference," *Ensign*, 1972 оны 11-р сар, 88-р хуудас.
  - Элиноор Нөвэлс, *Ховард В.Хантэр* (1994), 202-р хуудсыг үзнэ үү.
  - Дон А.Сөөрл, "One Million in Mexico," *Ensign*, 2004 оны 7-р сар, 34-р хуудас; Кристин Майнэр, "The Church in Oaxaca, Mexico," *Ensign*, 2001 оны 4-р сар, 78-р хуудсыг үзнэ үү.
  - 2012 оны 4-р сард дуу бичлэгийн албанд хийсэн ярилцлагаас.
  - Рэй А.Пратт, *The Young Woman's Journal*, боть25, дугаар 9 (1914), 539-р хуудас.
  - 2013 оны 4-р сарын 5-нд зохиогчтой хийсэн ярилцлагаас.
  - "Agricol Lozano Herrera: Mexican Mormon Church Leader," <http://mittromneymormon.net/meet-some-mormons-2/meet-some-mormons-2/agricol-lozano-herrera-mexican-mormon-church-leader>-ийг үзнэ үү.



Оаксака дахь семинарын суралцагчид хамт байхдаа их дуртай.



Joseph Fielding Smith

# ҮНЭНЧ БӨГӨӨД ИТГЭЛТЭЙ

ЖОЗЕФ ФИЙЛДИНГ СМИТИЙН

амьдрал ба сургаалуудын сүнслэг нөлөө

**Бага Хоёт В.Брюстэр**


33 настай Жозеф Фийлдинг Смитийг 1910 оны 4-р сарын 6-нд Ерөнхий чуулганд оролцохоор Солт Лэйкийн табэрнэклд орж ирэхэд хаалганы сахиул түүнд “За, Жозеф, шинээр хэн төлөөлөгч болох ёстой вэ?” гэхэд,

“Би мэдэхгүй юм байна” гээд “Та ч, би ч төлөөлөгч болохгүй!” гэж Жозеф хариулжээ.<sup>1</sup>

Дэмжүүлэн батлуулах арванхоёр төлөөлөгчийн нэрсийг уншиж байтал дараагийн нэр нь Жозефынх байх юм шиг гэнэт түүнд санагджээ. Үнэхээр түүний нэрийг дуудаж, тэрээр энэхүү хүндэт чуулгын 12 дахь гишүүнээр дэмжин батлагдав.

Түүнийг шинэ дуудлагынхаа талаар гэр бүлдээ мэдэгдэхээр чуулганаас гэртээ ирэх үед түүний даруу зан болоод хошин шогийн мэдрэмж харагдсан ажээ. Тэрээр эхнэртэйгээ мэндлээд “Бид үнээгээ зарах хэрэгтэй болох нь дээ” хэмээн учир битүүлгээр хэлэхэд эхнэр нь гайхаж, цааш нь юу гэж хэлэхийг нь хүлээсэн гэдэг. Гэтэл тэр ердөө л “Одоо үнээгээ маллах цаг надад байхгүй боллоо!” гэжээ.<sup>2</sup> Тийнхүү жар гаруй жил үргэлжилсэн түүний төлөөлөгчийн үйлчлэл эхэлсэн юм.

Хайрум Смитийн ач хүү Жозеф Фийлдинг Смит Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн 10 дахь ерөнхийлөгч болсон юм. Тэрбээр сүмийн ерөнхийлөгч болохоосоо өмнө Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын гишүүнээр сүмийн бусад аль ч ерөнхийлөгчөөс илүү удаан хугацаагаар үйлчилжээ. Тэрбээр онцгой гэрчүүдийн чуулгын гишүүнээр үйлчилсэн 60 жилийн турш гэгээнтнүүдэд заахын тулд морь, морин тэрэг сүүлдээ машин болон тийрэлтэт онгоцоор хүртэл аялан явдаг байв. Түүний үйлчилсэн номлолууд болон бичсэн үй олон зохиол нь сүмийг болон түүний сүнслэг нөлөө бүхий захиасуудыг сонсох хүн бүрийг адисалсан юм.



*“Их Эзэний зарлигуудыг сахиж, Түүнийг хүндэтгэн, Түүнтэй хийсэн гэрээнүүдээ санах хүсэлтэйгээр үргэлж үнэнч бөгөөд итгэлтэй байцгаая.”*



Би ерөнхийлөгч Жозеф Фийлдинг Смитийг өвөөгөө хэмээн хайрладаг бөгөөд түүнтэй ураг төрлийн холбоотой учраас энэ өгүүллийг бичиж өгөөч гэж намайг урьсан юм. Би төрсөн цагаасаа эхлэн түүний амьдралаар нөлөөлөгдсөн хүн. Тэрээр надад нэр өгсөн ба нас барах хүртлээ адислалын ёслолуудыг гүйцэтгэдэг байлаа. Би түүний оршуулгын ёслол дээр бусад ач нарынх нь хамт авсыг нь өргөн, авч явсан билээ.

### Урьдчилан томилогдсон бошиглогч

Жозеф Фийлдинг Смит Бурханы бүх бошиглогчдын нэгэн адил Их Эзэний тэнгэрлэг цаг хугацааны дагуу дэлхийд ирэхээр урьдчилан томилогдсон юм (Үйлс 17:26-г үзнэ үү). Жозеф нь Жюлина Ламсон Смитийн дөрөв дэх хүүхэд гэхдээ ууган хүү нь байв. Хэрвээ Их Эзэн түүнд хүү заяавал “тэр хөвгүүнийг амьдралынх нь бүх үеийн туршид Их Эзэн болон эцэгт нь туслуулахын тулд

*Дээд талд: Энэ хүүхдийн гэрэл зургийг эцэг эхийнх нь Библи дээр тавьжээ. Баруун талд: Жозеф, ах Дэвидтэйгээ гар бөмбөг тоглох дуртай байлаа. Доод талд: Ахлагч Смит (зүүн талаас хоёр дахь нь) Англи дахь номлогчидтой хамт байгаа нь, 1901 он. Эсрэг талын хуудсан дээрх гэрэл зургийг түүнийг номлогч байхад авчээ. Баруун доод талд: Ахлагч Смит (зүүн талд) төлөөлөгч Жорж Альбэрт Смит, Израйл Смит нартай хамт, 1936 он.*



чадах бүхнээ хийх болно” хэмээн Жюлина Хуучин Гэрээний итгэлт эх Ханнагийн даруухан сүнсээр тангараглажээ (1 Самуел 1:11-ийг үзнэ үү).<sup>3</sup> Их Эзэн түүний гуйлтад хариулсан төдийгүй хүүг нь төрөхөөс өмнө тэр хүүхэд хэзээ нэгэн цагт Арванхоёр Төлөөлөгчийн чуулгад Түүний онцгой гэрчээр дуудагдах болно гэдгийг түүнд бас харуулжээ.<sup>4</sup>

Жозеф 1876 оны 7-р сарын 19-нд Жозеф Ф.Смит, Жюлина Ламсон Смит нарын гэр бүлд мэндэлжээ. Жозефыг төрөх үед эцэг нь төлөөлөгч бөгөөд ерөнхийлөгч Бригам Янгийн зөвлөх байв. Жозефыг есөн настай байхад эцэг эх нь түүнийг Ютагийн Сэйнт Жоржийн ариун сүмийн онцгойлон адислалтад дагуулан очжээ. Тэрээр хожим нь “Сүм дэх миний анхны ажил үүрэг бол Сэйнт Жоржийн ариун сүмийг онцгойлон адислахад Бригам Янгийг дагалдан явах байв” хэмээн хошигнон дурссан байдаг.<sup>5</sup>

Жозефыг 19-тэйдөө патриархын адислал авах үед сүнсээр удирдагдсан патриарх Жозефын толгой дээр гараа тавин, “Их өндөр нас зооглох онцгой боломж танд тохиох болно. Та Израйл дахь хүчирхэг нэгэн болох нь Их Эзэний хүсэл мөн. . . . Та хүмүүсийн дунд бошиглогч, илчлэгч болон зогсоно, учир нь Их Эзэн таныг адисалж, энэ дуудлагад томилсон билээ” гэж хэлжээ.<sup>6</sup>

### Гэр бүлийн амьдрал: Хайр болон сорилтууд хамт байдаг

Жозеф Фийлдинг Смитийн хувьд “гэр бүл бол энэ амьдрал мөн үүрд мөнхийн хамгийн чухал байгууллага” юм.<sup>7</sup> Тэр хайр энэрэл, итгэл бишрэл, ёс суртахууны өндөр жишгүүд болон ажлын өндөр ёс зүй ноёрхсон гэр бүлд өссөн бөгөөд эдгээр зарчмуудыг гэр бүлдээ төлөвшүүлэхийг байнга хичээдэг байв. (*Teachings*

*of Presidents of the Church:  
Joseph Fielding Smith, 4, 15,  
16-р бүлгүүдийг үзнэ үү.*

Тэрээр Лүи Эмили Шөрт-лифтэй 1898 онд Солт Лэйкийн ариун сүмд гэрлэжээ. Нэг жилийн дараа тэр Их Британид хоёр жилийн хугацаагаар номлолд үйлчилсэн бөгөөд эхнэр нь түүнийг үнэнч итгэлээрээ дэмждэг байлаа. Түүнийг номлолоос эргэж ирсний дараа тэд дахин хамтдаа амьдарч, тэдэнд адислал болж хоёр охин нь мэндэлсэн юм. Харамсалтай нь, Лүи гурав дахь жирэмслэлтийнхээ үед хүндрэлийн улмаас нас барсан ажээ.

Уй гашуу дунд Жозеф “би түүнтэйгээ үүрд мөнхийн алдар сууд учран золгож, түүнтэйгээ дахин хэзээ ч салахгүйгээр нэгдэн нийлэхээр зохистой амьдрахад минь надад тусална уу хэмээн Танд хандан залбирч байна. . . . Хонгорхон хоёр үр минь насан туршдаа цэвэр ариун, толбогүй байхын тулд тэднийг гарыг нь ганзганд, хөлийг нь дөрөөнд хүргэхэд минь надад тусална уу” хэмээн залбирчээ.<sup>8</sup>

Уй гашууд автсан, хоёр хүүхдийн аав тэрээр эцгийнхээ шаргуу гуйлтаар өөртөө хань, хоёр бяцхан үрдээ эх болох хүнийг залбиран хайжээ. Түүний зөв шударга хүсэл Этэл Жоржина Рэйнольдсыг амьдралд нь авчирсан юм. Тэд 1908 оны 11-р сард Солт Лэйкийн ариун сүмд гэрлэсэн ажээ. Жозефын хоёр хүүхдийн эх болсон энэ гайхамшигт эмэгтэй дараа нь дахиад есөн хүүхэд төрүүлсэн юм.

Нэг удаа түүнийг нэгэн гадасны чуулганд явж байтал эхнэрийнх нь нөр их ачаалал төлөөлөгчийн оюун ухаанд хүчтэй нөлөөлжээ. Тэрээр эхнэртээ бичсэн захидалдаа “Би чамайгаа бодон, дараагийн хэдэн долоо хоногт чамтайгаа байнга хамт байж, хүүхдүүддээ анхаарал тавихад чинь туслахсан гэж үнэхээр их хүсч байна. Би чамдаа чадах бүхнээрээ туслах болно, ингэснээр чи минь минийхээ нөлөөг мэдрэх болно гэдэгт найдаж байна. Ээждээ болон өөр хоорондоо эелдэг бай гэж хүүхдүүддээ хэлээрэй” хэмээн өгүүлжээ.<sup>9</sup> Тэгээд тэрээр зүрх сэтгэлийнхээ бодлыг шүлэг хэлбэрээр хайрт гэргийтэйгээ хуваалцсан нь хожим “Аялал хол санагдаж



байна уу?” гэсэн нэртэй манай дууллаудын нэг болсон билээ. (дугаар 127).

Харамсалтай нь, Этэл 1937 онд нас баржээ. Түүнийг өөд болоход гэрт нь гэрлээгүй таван хүүхэд байв. Ахлагч Смит өөр эхнэр буюу хамтрагч хайх хэрэгтэйгээ Ариун Сүнсээр мэдэрсэн ажээ. 1938 онд тэр Жэсси Эванс Смиттэй Солт Лэйкийн ариун сүмд гэрлэв.

Тэднийг сайн мэддэг хүмүүсийн нэг нь “Жозеф Фийлдинг Смит, Жэсси Эванс Смит нар хорин зургаан насаар зөрөөтэй; зан ааш, боловсрол мэдлэгээрээ ялгаатай ч гэсэн гайхамшигтай сайхан гэр бүл болж чадсан юм. . . . Хоорондоо тэс ялгаатай бөгөөд олон насны зөрөөтэй энэ хоёр хүнийг хооронд нь

гүүр болж холбосон зүйл нь тэдний бие биеэ жинхэнэ халуун хайраар хайрлаж, хүндэтгэдэг байсан явдал юм” гэж бичжээ.<sup>10</sup> (Гарын авлагын 6–23-р хуудсуудыг үзнэ үү.)

### **Судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцахыг эрэлхийлэгч**

Жозеф Фийлдинг Смит бол судар судлаач бөгөөд сайн мэдээний эрдэмтэн гэдгээрээ сүмд нэрд гарсан хүн. Тэрээр өсвөр наснаасаа эхлэн “судлахаар мөн тэрчлэн итгэлээр суралцах” (С ба Г 88:118) гандан бууршгүй хүсэлтэй байлаа. Тэр 10 нас хүрэхээсээ өмнө Мормоны Номыг хоёр удаа уншжээ. Найз нар нь түүнтэй уулзахыг хүссэн үедээ түүнийг ихэвчлэн өвсний саравчинд судар уншиж байхад нь олдог байжээ.<sup>11</sup>

Тэрээр хэдэн жилийн дараа цугларагсдад хандан “Би анх уншиж сурсан тэр цагаас хойш бүх дэлхийн өөр юунаас ч хүлээн авдаггүй . . . тийм их баяр баясал, сэтгэл ханамжийг судар судлахдаа олж авдаг болсон” гэж ярьжээ.<sup>12</sup> (10, 18-р бүлгүүдийг үзнэ үү.)

Ерөнхийлөгч Хибэр Ж.Грант (1856–1945) нэг удаа ерөнхийлөгч Смитийн эрдэм мэдлэгийг магтан, “Манай сүмийн ерөнхий эрх мэдэлтнүүд дотроос судрын хамгийн гарамгай мэдлэгтэй хүн нь та юм гэж би боддог” гэжээ.<sup>13</sup>



*Дээд талд: Ерөнхийлөгч Смит хөвгүүдтэйгээ. Баруун дээд талд: Ахлагч Смит ерөнхийлөгч Дэвид О.Маккэйтэй мэндэлж байгаа нь, 1961 он. Баруун талд: Ерөнхийлөгч Смит Солт Лэйкийн табэрнэклийн индэр дээр сууж байгаа нь. Доод талд: Ерөнхийлөгч Смитийн өсвөр наснаасаа тоглох дуртай байсан спорт болох бэйсбол тоглож байгаа гэрэл зураг.*



Түүний сурч мэдэх агуу их хүсэлтэй байсан нь хөвгүүн байхдаа ч, насанд хүрсэн хойноо ч спорт болон бусад тоглоомоор тоглодоггүй байсан гэсэн үг биш юм. Тэр бэйсбол болон хөдөө амьдардаг өсвөр үеийнхний тоглодог байсан олон тоглоомоор тоглох дуртай байжээ. Тэр насанд хүрсэн хойноо гар бөмбөг тоглох хорхойтой байсан ба хүүхдүүдийнхээ спортын үйл ажиллагаануудад байнга оролцдог байлаа. Тэр бас гэр бүлийн цугларалтаар зохиогддог байсан спорт тоглоомуудад оролцдог байв. Өвөө минь нэг удаа софтбол тоглож байгаад бөмбөгөө талбайн шугам давуулан шидэж, талбайн зүүн талаас зураг авч байсан авга ахынхаа зургийн аппаратыг онож, цохиж байсныг би санадаг.

#### **Итгэлээ хамгаалагч нинжин сэтгэлтэн**

Жозеф Фийлдинг Смит төлөөлөгчөөр дуудагдахаасаа өмнө итгэлээ хамгаалагч хэмээн нэрд гарсан нь зарим хүмүүс түүнийг хатуу чанга хүн хэмээн буруугаар бодоход хүргэдэг байжээ. Тэрбээр Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авахад нь бүх хүмүүсийг

урамшуулан дэмжих мөн гэрээнүүдэдээ чин үнэнч байх гандан бууршгүй хүсэлтэй байсан хэдий ч гэр бүл, найз нөхөд нь түүнийг сайхан зантай, зөөлөн хүн гэдгийг нэгэн дуугаар хүлээн зөвшөөрдөг байлаа. Ерөнхийлөгч Спенсэр В.Кимбалл (1895–1985) түүний тухай дурсахдаа “Арванхоёр нь Израйлын шүүгчид байх болно хэмээн бид олонтоо хэлж байсан бөгөөд бидний хэн нь ч Смитээр шүүгдэхдээ баяртай байх болно, учир нь түүний шүүлт элдэг, найрсаг, нигүүлсэнгүй бөгөөд ариун байх болно” гэж хэлжээ.<sup>14</sup>

Сүмийн эзэмшдэг нэг автомашин осолд орсон тухай асуудлыг хэлэлцсэн хурал дээр ерөнхийлөгч Смит үнэхээр сайхан сэтгэлийн үлгэр жишээг харуулжээ. Хүнсний ногоо ачдаг, даатгалгүй машин барьж явсан настай жолооч осол гаргачихжээ. Хэсэг ярилцсаны дараа сүм уг асуудлыг шүүхээр шийдүүлэх нь зүйтэй гэсэн зөвлөмж гаргажээ. Гэвч ерөнхийлөгч Смит ам нээж, “Тийм ээ, бид ингэж болно л доо. Хэрэв бид хүч түрэн, тэр ядуу эрээс ачааны машиныг нь салгаад авчихвал хөөрхий тэр яаж амь зуух юм бэ?” гэжээ. Тийнхүү хороо зөвлөмжөө өөрчилж, асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэхгүй болсон аж.<sup>15</sup>

Ерөнхийлөгч Смитийн булшийг онцгойлон адисалсны дараа би Солт Лэйкийн оршуулгын газарт ерөнхийлөгч Харолд Б.Лий (1899–1973) рүү дөхөж очихдоо бусад хүмүүс өвөөг минь хэрхэн хайрладаг байсныг мэдэрч, “Ерөнхийлөгч Лий, таныг манай өвөөд үнэхээр сайхан сэтгэлээр ханддаг байсанд тань намайг ямар их талархдагийг минь мэдээсэй гэж хүсч байна” хэмээн хэлж билээ. Тэр миний нүд рүү эгцлэн харснаа тун ялдамхнаар “Би түүнийг үнэхээр их хайрладаг байсан юм шүү!” гэж хариулав.



## Үнэнч бөгөөд итгэлтэй үйлчлэгч

Ерөнхийлөгч Смитийн үйлчлэл нь наманчлалыг номлох судруудын зарлигт дуулгавартай байснаараа онцгойрон ялгардаг билээ (жишээ нь, С ба Г 6:9; 11:9-ийг үзнэ үү). Тэрбээр “Би хүмүүст *өнөөдөр* бол наманчлалын өдөр гэдгийг хэлж, гэрээнүүдээ санахад нь хожмын үеийн гэгээнтнүүдийг . . . дуудан, бүх зүйлд *үнэнч бөгөөд итгэлтэй* байхад тэднийг уриалж, Сионы гадсуудаар аялах үедээ Их Эзэний Сүнсэнд догдолдог байлаа” хэмээн хэлжээ<sup>16</sup> (5-р бүлгийг үзнэ үү).

Ерөнхийлөгч Смит амьдралынхаа бараг 96 жилийн турш үнэнч бөгөөд итгэлтэй хэвээр байж, эцсээ хүртэл тэвчинэ хэмээн залбирсан юм. Чухам иймээс Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын одоогийн ерөнхийлөгч Бойд К.Пакэр “Тэр ер гарсан байсан ч ‘гэрээнүүд болон үүргүүдээ биелүүлж, эцсээ хүртэл тэвчинэ’ хэмээн залбирдаг байсан юм” хэмээн тэмдэглэжээ.<sup>17</sup>

Ерөнхийлөгч Смитийн хувьд “үнэнч бөгөөд итгэлтэй” гэдэг үг зүгээр нэг олон удаа давтагддаг холбоо үгээс илүү чухал зүйл байлаа. Энэ бол бүх хүмүүст—гэрээ хийсэн сүмийн гишүүд болон бидний Тэнгэр дэх Эцэгийн бүх хүүхдүүдэд найдах түүний чин сэтгэлийн найдварын илэрхийлэл байсан юм. “Бурханы хаант улс болон Түүний зөв шударга байдлын төлөө . . . бид хамгийн түрүүнд, бүхний эхэнд байх ёстой. Их Эзэний зарлигуудыг дагах хүсэлтэйгээр, үргэлж үнэнч бөгөөд итгэлтэй байж, Түүнийг дээдлэн хүндэлж, Түүнтэй хийсэн гэрээнүүдээ сахицгаая. Энэ бол бүх Израйлын төлөө миний залбирал юм” хэмээн ерөнхийлөгч Смит хүссэн билээ<sup>18</sup> (19–22-р бүлгүүдийг үзнэ үү).

Та бүхэн түүний сүнсээр нөлөөлөгдсөн сургаалуудыг залбирч тунгаан бодсоноор гэрчлэл тань хүчирхэгжиж, Есүс Христийн сайн мэдээний энгийн болон цэвэр үнэнүүдийг ойлгох гүнзгий ойлголтоор адислагдах болно. Энэхүү цуврал хичээл “үнэнч бөгөөд итгэлтэй” амьдрах хүслийг тань нэмэгдүүлэх болно. ■  
Тэмдэглэл: Зохиогчийн эх Наоми Смит Брюстэр Жозеф Фийлдинг Смитийг Арванхоёр Төлөөлөгчийн чуулгад дуудагдсан жил Эгэл Жоржина Смитийн хоёр дахь хүүхэд болон төрсөн ажээ. Ерөнхийлөгч Смит анхныхаа эхнэрийг нас барсны дараа түүнтэй гэрлэжээ.

## ЭШЛЭЛҮҮД

1. *Teachings of Presidents of the Church: Joseph Fielding Smith* (2013), 16-р хуудас.
2. Бага Жозеф Фийлдинг Смит, Жон Ж.Споарт нар, *The Life of Joseph Fielding Smith* (1972), 176-р хуудас.
3. *Teachings: Joseph Fielding Smith*, 1; мөн Брүс Р.Макконки, “Joseph Fielding Smith: Apostle, Prophet, Father in Israel,” *Ensign*, 1972 оны 8-р сар, 29-р хуудас.
4. Брүс Р.Макконки, “Joseph Fielding Smith,” 29-р хуудсыг үзнэ үү.
5. Жозеф Фийлдинг Смит, Смит болон Споарт, *The Life of Joseph Fielding Smith*, 49-р хуудсаас эш татжээ.
6. Смит болон Споарт, *The Life of Joseph Fielding Smith*, vii хуудсаас эш татжээ.
7. *Teachings: Joseph Fielding Smith*, 76-р хуудас.
8. *Teachings: Joseph Fielding Smith*, 275-р хуудас.
9. Жозеф Фийлдинг Смит, Смит болон Споарт, *The Life of Joseph Fielding Smith*, 188–189-р хуудсуудаас эш татжээ.
10. *Teachings: Joseph Fielding Smith*, 22, 23-р хуудсууд.
11. *Teachings: Joseph Fielding Smith*, 4-р хуудсыг үзнэ үү.
12. *Teachings: Joseph Fielding Smith*, 4-р хуудсыг үзнэ үү.
13. Хибэр Ж.Грант, Францис М.Гиббонс, *Joseph Fielding Smith: Gospel Scholar, Prophet of God* (1992), 290-р хуудас.
14. Спэнсэр В.Кимбалл, Брүс Р.Макконки, “Joseph Fielding Smith,” *Ensign*, 1972 оны 8-р сар, 28-р хуудас.
15. Люсил К.Тэйт, *Бойд К.Пакэр: A Watchman on the Tower* (1995), 176-р хуудыг үзнэ үү.
16. Жозеф Фийлдинг Смит, Conference Report, 1919 оны 10-р сар, 88; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн.
17. Бойд К.Пакэр, “Covenants,” *Ensign*, 1990 оны 11-р сар, 84-р хуудас.
18. Жозеф Фийлдинг Смит, Conference Report, 1912 оны 10-р сар, 124–125-р хуудсууд.

## 2014 ОНД СУДЛАХ ХИЧЭЭЛ

Энэ жил Мелкизедек сан-ваартнууд болон Халамжийн Нийгэмлэгийн эгч нар *Teachings of Presidents of the Church: Joseph Fielding Smith* (Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Жозеф Фийлдинг Смит)-ийг судлах болно. Энэ гарын авлага нь сүмийн гишүүнчлэл дөнгөж 3 сая гаруйд хүрээд байсан 1972 онд ерөнхийлөгч Смитийн нас барснаас хойш түүний сүнслэг нөлөө бүхий сургаалууд өнөөгийн болон ирээдүйн үеийнхэнд хүртээмжтэй байх болно гэдгийг ойлгоход туслах болно. Эдүгээ амьд байгаа цөөхөн хүн ерөнхийлөгч Смитийн үлгэр жишээ болохуйц амьдралын талаар хувийн дурсамжтай байгаа ч бүх хүмүүс түүний сургаалуудын хүчээр урам зориг авч, сүнслэгээр нөлөөлөгдөж чадна.

Та ерөнхийлөгч Смитийн сургаалуудыг залбирч судлан, тунгаан бодох үедээ зарчмуудыг хэрэгжүүлснээр хэмжээлшгүй их адислал авчирдаг талаар түүнийг тун тодорхой заахад нь Их Эзэн хэрхэн түүнийг төлөөний хүнээ болгодог байсан тухай ойлгох болно. Та нар доорх сэдвүүдийг судлах болно:

- Тэнгэрлэг Эцэг болон Аврагчтай харилцах бидний харилцаа
- Бидний амьдрал дахь Ариун Сүнсний нөлөө
- Бошиглогч Иосеф Смитийн зорилго
- Ариун сүмийн гэрээнүүдийн ач холбогдол
- Дэлхийд байгаа хэрнээ хэрхэн дэлхийнх биш байх вэ?
- Үнэнч бөгөөд итгэлтэй байснаар Есүс Христийн Хоёр дахь ирэлтэд хэрхэн бэлтгэх вэ?

Энэ гарын авлагыг мобайл хэрэгслүүдэд [mobile.lds.org](http://mobile.lds.org) болон [LDS.org](http://LDS.org) онлайн хаягаар унших боломжтой байгаа.

## БИ ТЭР НОМЫГ ЧИНЬ УНШИЖ БОЛОХ УУ?

Бараг 50 жилийн өмнө номлолын маань хамтрагч бид хоёр Аргентины Кордоба их сургуулийн ойролцоо хаалга тогшин явж байтал нэгэн залуу эрэгтэй биднийг гэртээ урьж билээ. Тэр өрөөний найзуудтайгаа хамт бидэнтэй зөвхөн Бурхан байдаг эсэх талаар маргах гэж биднийг урьсан нь тэр даруй тодорхой болов.

Бид маргахыг хүссэнгүй, тиймээс суралцах тохиромжтой орчинд бидний захиасыг ярилцахын тулд дахин уулзахаар тохиролцов. Биднийг эргэж ирэхэд нөгөөх залуу яагаад Бурхан байдаггүй гэдэгт итгэдгээ тайлбарласан юм. Хүн өөрөөсөө илүү агуу, ер бусын ямар нэг зүйлд итгэх хэрэгтэй байсан учир Бурханыг зохион бодсон юм гэж тэр хэллээ.

Бидний ярих ээлж болоход “Та яаж Нэгдсэн Улс байдгийг мэддэг вэ?” гэж би асуув. Би Нэгдсэн Улс оршдогийн бодит баталгааг гэрчлээд энэ улс оршдог тухай үүнээс өөр нотолгоо байна уу? гэж асуув. Нөгөөх залуу Нэгдсэн Улсын тухай

ном, сонинуудаас уншсан тухайгаа ярилаа. Тэгэхэд нь би түүнээс миний гэрчлэлд болон уншсан зүйлдээ итгэдэг үү? гэж асуув. Тэр тийм ээ хэмээн маргалгүй хариулав.

“Иймээс л бид Нэгдсэн Улсаас ирсэн над шиг хүмүүсийн гэрчлэлийг үгүйсгэж чадахгүй бас энэ улсын тухай бичсэн хүмүүсийн гэрчлэлийг ч үгүйсгэж чадахгүй шүү дээ” гэж би хэлэв. Нөгөөх залуу зөвшөөрлөө.

Тэгэхэд нь би “бид энэ санаан дээр үндэслээд Бурханыг харсан болон өөрсдийн туршлагын тухай бичсэн тэдгээр хүмүүсийн гэрчлэлийг үгүйсгэж болно гэж үү?” хэмээн асуув. Би түүнд Библи үзүүлж, энэ ном нь Бурхан, Есүс Христ хоёрыг харж, Тэдэнтэй ярилцсан эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэрчлэлийг агуулдаг гэж хэллээ. Бид Библид агуулагдсан гэрчлэлүүдийг үгүйсгэж болох уу? гэж намайг асуухад тэр болохгүй хэмээн сулхан хариулав.

Дараа нь би “Библи дэх хүмүүсээс өөр хүмүүс Библийг бичсэн хүмүүсийн харсан тэрхүү Бурханыг бас

харсан тухайгаа бичсэн өөр нэг ном бий. Энэ номын талаар та юу гэж бодож байна вэ?” гэж асуув. Тийм ном байхгүй шүү дээ гэж тэр хариуллаа.

Бид түүнд Мормоны Номыг үзүүлж, зорилгыг нь түүнд сануулан, энэ ном үнэн бөгөөд Бурхан өнөө үед амьд бошиглогчдоор дамжуулан хүмүүнтэй харилцсан хэвээр байгааг гэрчиллээ.

Залуу эр гайхаж, “Надад бусад сүмийн бүх номлогчдыг мухардалд оруулах боломж байлаа. Харин урьд нь миний сонсож байгаагүй ямар нэг зүйл танд байна. Би тэр номыг чинь уншиж болох уу?” гэж асуув. Бид түүнд Мормоны Ном өгөөд хүүхдүүдээ хайрладаг Бурханы хайрын тухай гэрчлэв.

Хичээлийн жил дууссан учраас бид тэр залуутай Боливи дахь гэр рүүгээ явахаас нь өмнө уулзаж чадсангүй. Гэсэн ч би түүнийг Мормоны Номыг уншиж, гэрчлэлтэй болоосой хэмээн залбирч байлаа.

Би 2002 онд Прово дахь Номлогчийг бэлтгэх төвд испани хэлээр ярьдаг салбарын ерөнхийлөгчөөр үйлчлэхээр дуудагдав. Нэг ням гарагт би дээрх түүхийг номлогчдод яриулав. Дараа нь Боливоос ирсэн нэгэн номлогч миний ярьсан тэр түүхийг гадасных нь нэг настай хүн хөрвөлтийнхөө талаар ярихад нь сонссоноо надад хэллээ.

Нүдийг минь нулимс бүрхэв. Тийнхүү би Боливоос ирсэн сайх залуугийн талаарх залбирлынхаа хариуг 40 жилийн дараа хүлээн авсан юм. Тэр Бурхан оршдог талаар болон Түүний аз жаргалын агуу төлөвлөгөөний тухай гэрчлэлтэй болсон ажээ. Нэгэн өдөр бид дахин уулзаж, тэрээр сайн мэдээг хүлээн авсанд нь түүнд баярлан, талархах болно гэдгээ би мэдэж байна. ■

АНУ, Юта, Нийл Р.Кардон

Бид тэр залууд Мормоны Номыг өгөөд хүүхдүүдээ хайрладаг Бурханы хайрын тухай гэрчлэв.





# МАМА СИФАЙ АРИУН СҮМ РҮҮ АЯЛСАН НЬ

1940-өөд оны үед намайг Мексикийн номлолын оффист байхад Мехико хотоос зүүн өмнө зүгт 70 км-т оршдог, Попокэтэпэтал идэвхтэй галт уулын бэлд байдаг Озумба хэмээх жижигхэн хотоос нэг эгч хүрч ирэв. Бид бүгд түүнийг таньдаг байв. Нэрийг нь Мама Сифай гэнэ.

Тэр шавар болон сүрлээр хийсэн жижигхэн тоосгон байшиндаа бүрэн цагийн номлогчдод зориулан өрөө гаргасан бөгөөд тэд тэнд амьдардаг байжээ. 1 метр 50 см ч хүрэхгүй өндөртэй Мама Сифай Озумбагийн эргэн тойрон дахь жижигхэн хотуудын зах дээр жимс зарж, амь зуудаг байв. Хот бүрийн захын ажилладаг өдөр өөр байсан учраас тэр өдөр бүр өөр зах дээр жимс зарахаар явдаг байлаа.

Мама Сифай тэр өдөр гурилын том шуудай барьсаар номлолын оффис дээр хүрч ирэв. Шуудай нь олон жилийн туршид түүний хадгалсан хагас песогийн мөнгөн зоос *тостаноор* дүүрэн байлаа. Зарим зоос нь 1884-1911 онуудад Мексикийг удирдаж байсан Порфирио Диазын үеийнх байв. Мама Сифай шуудайтай мөнгөө Озумбагаас номлолын гэрт автобусаар авчирсан ажээ. Тэр хувийн хишгээ хүртэхээр Солт Лэйкийн ариун сүм рүү явахын тулд олон жилийн турш мөнгө хадгалсан юм гэж ерөнхийлөгч Арвэлл Л.Пийрсэд хэлжээ.

Түүнд ариун сүм явахыг нь зөвшөөрч, нэг номлогч чемоданаа түүнд зээлдүүлэхэд бид түүнийг галт тэргэнд суулгаж өгч билээ. Ерөнхийлөгч Пийрс Техасын Эл Пасод байдаг хэн нэгэн рүү утасдаж, Нэгдсэн Улсын хил дээр Мама Сифайг тосч, Солт Лэйк рүү явдаг автобусанд суулгаж өгөхийг хүсчээ. Солт Лэйк хот дахь испани хэлээр

ярьдаг салбарын гишүүд түүнийг автобусны буудал дээр тосч, байранд оруулан, ариун сүм дээр түүнд тусалжээ.

Мама Сифай хэдэн долоо хоногийн дараа Мехико хотод эргэн ирж, тэндээсээ Озумба дахь гэртээ иржээ. Тэр урт аян замаа эсэн мэнд туулан, гэртээ ирээд зах дээр жимс зарах ажилдаа дахин орсон гэнэ.

Мама Сифай англиар ярьдаггүй байсан учраас Эл Пасогоос Солт Лэйк хот хүртэл автобусаар хэд хоног явах үедээ яаж хоолоо авч идэж байсныг нь бид асуулаа. Тэр нэг

хүнээр “алимтай бялуу” гэж англиар яаж хэлдгийг заалгаж аваад зорчигчдоо хооллохоор автобусыг зогсох бүрд алимтай бялуу захиалдаг байсан гэнэ.

Тэр англиар ердөө энэ хоёр үгийг л мэддэг учраас улсын ихэнх нутгийг дайрсан энэ аялалынхаа ирж, очих *хоёр* талд зөвхөн алимтай бялуу л идэж явжээ. Гэвч Мама Сифай үүндээ огт сэтгэл дундуур байсангүй. Харин ч тэр ариун сүмийн туршлагаасаа царай нь гэрэлтэн, баяртайгаар эргэж иржээ. ■ АНУ, Юта, Бэтти Вэнтура



Мама Сифай шуудай дүүрэн мөнгөтэйгөөр номлолын гэр хүртэл 70 км газрыг автобусаар явж, ирсэн билээ.

# ОЧИЖ, ТҮҮНИЙ ХӨГЖМИЙГ ЗАС

Манай хажуугийн хаалганд суудаг хөрш орон нутгийн сүмд өсвөр үеийнхэнд үйлчилдэг байсан бөгөөд сүмийнх нь өсвөр насныхан тэднийд байнга ирдэг байлаа. Өдөр ч шөнө ч түүний байшингийн өмнө нэлээд хэдэн машин зогсож байх нь ердийн зүйл байв.

Эдгээр өсвөр насныхны зарим нь машиныхаа хөгжмийг чангаар тоглуулдаг байв. Тэдний чанга хөгжим орон сууцны хэдэн байшингийн цаанаас ч сонсогддог байсан бөгөөд тэднийг ойртоход цонхнууд маань чичирхийлдэг байлаа. Чанга хөгжим намайг шөнө олон удаа сэрээдэг байв. Миний дургүйцэл улам ихсэж, эдгээр өсвөр насныхныг дайснаа гэж үзэх болов.

Нэг өдөр би гадаа унасан навчсыг тармуураар хамж байтал хэдэн

байрны цаанаас машины хөгжим маш чанга дуугарах нь сонсогдлоо. Удалгүй хөгжим бүр ойртон, улам чанга болж эхлэв. Нөгөөх машины жолооч булангаар тойрч, манай хөршийн гэрийг чиглэхэд миний уур хүрч, Тэнгэрлэг Эцэгт хандан, хөгжмийг нь эвдэж өгөхийг гуйн залбирлаа.

Тэрээр хөгжмөө суга татан авсан юм шиг гэнэт чимээгүй болоход цөхрөнгөө барж хэлсэн миний залбирал талархал, магтаалын залбирал болов. Би өмнө нь машины хөгжим дээр ажиллаж байсан болохоор дууг нь нам болгоогүй харин бүр эвдэрснийг нь мэдсэн юм.

Хөгжим нь ажиллахаа больсонд нөгөөх залуу уруу царайлан, найз нар нь түүнийг тайтгаруулахаар цуглав. Харин би эсрэгээр нь, Бурханы

Харин би Бурханы мутар чанга дуутай хөгжмийн амыг барилаа даа хэмээн бодсондоо баярлан, их л маадгар байлаа.

мутар чанга дуутай хөгжмийн амыг нь барилаа даа гэж бодсондоо баярлан, их л маадгар байлаа.

Гэвч болсон явдлыг цааш үргэлжлүүлэн бодоод би өөрөө олон жилийн өмнөх шигээ ааш гаргаснаа ухаарлаа. Зүрх сэтгэл минь зөөлөрч, тэр хөвгүүн миний дайсан огт биш байсан шүү дээ хэмээн бодож эхэллээ. Тэгтэл Сүнс “Очиж, түүний хөгжмийг зас” хэмээн шивнэх нь тэр.

Би энэхүү өдөөлтөд цочирдон, үүнээс ангижрах гэж оролдов. Миний тайван амьдралд саад учруулж байсан тэр хөгжмийг би яагаад засч өгөх ёстой юм бэ? Гэвч нөгөөх сануулга дахин ирсэн учраас би үүнийг дагалаа.

Би хөгжмийг чинь засч өгөх үү гээд юу эвдэрснийг нь доржноо оллоо. Тиймээс маш хурдан засав. Удалгүй хөгжим урьдынх шигээ маш чанга дуугарч эхэллээ.

Залуу эрэгтэй талархлаа илэрхийлээд миний төлөө ямар нэгэн хийж чадах зүйл байна уу? гэж асуув. Би түүнд ажилдаа явахын тулд өглөө эрт босдог хүн, тэгэхээр оройдоо хөгжмөө унтрааж байвал тун их баярлахсан гэж хэллээ. Тэр инээмсэглээд тэгнэ ээ гэж надад хэлж билээ.

Тэр хөгжмөө зөвхөн үдэш оройн цагаар нам дуугаар тоглуулдаг болсон төдийгүй миний төлөө бүр найз нараасаа хөгжмөө унтраахыг хүсдэг болсон юм. Тэр цагаас хойш харанхуй болсон хойно чанга хөгжим сонсогдох нь огт үгүй болсон билээ.

Тэнгэрлэг Эцэг үнэхээр миний залбирлыг сонсож, хариулсан юм. Түүний шийдэл надад амар амгалан, нам гүм байдлыг авчирч, Сүнсийг дагах үнэ цэнэтэй сургамж, “дайснаудаа хайрлах” (Лук 6:27) гэгч нь чухам юу болохыг илүү сайн ойлгоход тусалсан юм. ■

АНУ, Флорида, Кэнт А.Рассэлл



# САЙН УУ, БЯЦХАН ХУРГА МИНЬ

Нөхөр бид хоёр нисэх онгоцны буудал дээр охин болон хоёр зээдээ гэр рүүгээ буцахаар бэлтгэхэд нь тусалж байлаа. Бид охиныхоо тээшийг зөөн, тийз авч, паспортуудыг нь бүртгүүлэх, хөдөлгөөн ихтэй гурван настай хүүхдийг нь харж өгөн, тусалж байлаа. Манай нэг настай зээ хүү Томми тэргэн дотроо бөх гэгч унтаж байснаа гэнэт сэрэв. Тэр цочин сэрж, их дуу шуугиан, хурц гэрэл, эмх замбараагүй орчинд дасах гэж ядан байв.

Би түүний нүүр хувирлыг хараад юу болох гэж байгааг нь ойлгон, охиноо дуудлаа. Охин маань хурдан бөхийж, Томмигийн нүүрийг хоёр гараараа тойруулан барьж, анхаарлыг нь татаад “Сайн уу, бяцхан хурга минь” гэж энхрийлэн хэлэв.

Бяцхан хүүгийн хөмсөг гэнэт тэнийж, ам нь хөдлөөд, санаа нь амарч, бүх бие нь тайвшран, гүнзгий амьсгаа авлаа. Тэр нүдээ дахин анин, унтахаасаа өмнө инээмсэглэв. Түүний айдас нь, түүнийг бүчин авах мэт амар амгалан ба тайвшралаар солигдов. Энэ бол бяцхан Томми ээждээ итгэн найдсаны багхан атлаа хүчтэй илэрхийлэл байсан юм. Ээж нь түүнд зөөлхөн хүрч, эелдэгхэнээр дуугаран, дэргэд нь байсан болохоор хүү тайвширчээ.

Бид бүгд Томмитой адилхан айдас, тодорхойгүй байдал болон санаа сэтгэлийн түгшүүрийг мэддэрэг билээ. Сайн Хоньчин Есүс Христ биднийг дууддаг гэдгийг мэдэх нь бидэнд тайтгарлыг өгдөг. Тэрбээр хонин сүргээ таньдаг бөгөөд бид Түүнд бүрэн итгэж болно. Тэрээр “Би Өөрийн амар амгалангаа та нарт өгнө. . . . Та нар зүрхээ бүү зовоо. Бүү ай” (Иохан 14:27) хэмээн хайраар өгүүлжээ.

Бид тодорхой бус цаг үе тохиолдоход Сайн Хоньчинд итгэл найдвараар хандсан үед тайтгарал ба өөртөө итгэх итгэлийг хүлээж авна гэдгийг би мэднэ. Би сэтгэл санаа тавгүй үедээ тайтгарлаар адислагдахдаа охин, хоёр зээтэйгээ нисэх онгоцны буудал дээр байсан тэр

хормыг эргэн санах дуртай. Ачаа дарамт мөрөн дээрээс минь авагдсан үед би бяцхан Томми шиг санаа алдан, тайвширдаг билээ. Тэр үед миний Хоньчин “Сайн уу, бяцхан хурга минь” хэмээн мэндчилдгийг би мэдэрдэг. ■

Канад, Онтарио, Коллин Соломон

Манай нэг настай зээ хүү цочин сэрж, их дуу шуугиан, хурц гэрэл болон эмх замбараагүй орчинд дасах гэж ядан байлаа.



# ТЭВЧЭЭРТЭЙ ДАВАН ТУУЛАХ НЬ

Ахлагч Ж.Кристофэр Лансинг

Хойд Америкийн зүүн хойд  
бүс, Бүсийн Дал

Авралын төлөвлөгөө бол гайхамшигтай төлөвлөгөө бөгөөд итгэл найдвар, хүсэл мөрөөдлөө биелүүлэхэд маань саад болдог сорилт бэрхшээлүүдийг даван туулах нь энэ төлөвлөгөөний нэг хэсэг юм. Дэлхий дээр амьдрах үед бид бүгдэд хүнд сорилтууд тохиолдог. Зарим нь жижиг, зарим нь том сорилт байдаг.

Хөл хөдөлгөөн ихтэй зам дээр шатахуун дуусвал энэ нь жижиг сорилт байж болох юм. Хайртай нэгнээ алдах, ослоор бэртэж гэмтэх эсвэл гэр бүлд ямар нэг эмгэнэлт явдал тохиолдох зэрэг нь том буюу хүнд сорилт болно. Бид зарим сорилтыг Бурханы эсвэл төрийн хуулиудад дуулгаваргүй байснаар өөр дээрээ авчирдаг. Зарим сорилт нь бидэнд ямар ч шалтгаангүйгээр ирдэг. Бидний ихэнхэд амьдралын “азгүй явдал” хэмээн нэрлэгддэг зүйлс тохиолдож байсан гэж би боддог. Ямар нэгэн тоглоом тоглож үзсэн хэнд ч гэсэн азгүйтэл тохиолддогийг бараг бүх хүмүүс мэднэ. Тийм азгүйтэл тоглоомын нэг л хэсэг байдаг. Азгүйтлийн хэмжээг эсвэл хэр олон удаа давтагдахыг урьдчилан таах аргагүй юм.

Азгүйтэл бол амьдралын нэг хэсэг гэдгийг сайн тоглогч мэддэг бөгөөд итгэл ба зоригтойгоор үргэлжлүүлэн амьдрахыг хичээдэг. Бид Тэнгэрлэг

**Бид үргэлж итгэлтэй байх болно гэж Их Эзэнд амласнаар л Тэрээр бидний сорилт бэрхшээлүүдийг зайлуулчих байх хэмээн хүсэн хүлээх ёсгүй. Харин бид үүний оронд тэвчээртэй даван туулах ёстой, тэгвэл бид адислагдах болно.**

Эцэгтэйгээ дахин хамт амьдрах хүсэлдээ үнэнч хэвээр байхын тулд саад бэрхшээлүүд дээр ажиллах аргыг олж, амьдралд чухам юу хамгийн чухал вэ гэдгийг нээж олох ёстой.

## Зогсолтгүй сэлээд бай

Цорын ганц охин Линзигээ бага байхад бид хоёр хамтдаа кино үзэх дуртай байж билээ. Бидний үзэх дуртай бөгөөд олон дахин хамт үзсэн хүүхэдэйн кино бол *Нэмогийн эрэлд байсан юм*. Уг кинонд Нэмо усан доогуур шумбагчид баригдаж, шүдний эмчийн ажлын өрөөний загасны аквариумд орчихдог. Түүний аав Марлин Нэмог олохоор шийджээ. Марлин аялалынхаа үеэр Дори гэгч загастай танилцав. Тэд Нэмог хайх үедээ саад бэрхшээлтэй удаа дараа тулгарч байв. Саад бэрхшээл нь том ч бай, жижиг ч бай ялгаагүй, Дори Марлинд “Зогсолтгүй сэлээд бай” гэж захидаг байлаа.

Хэдэн жилийн дараа Линзи маань Чилийн Сантьяго дахь номлолд үйлчилсэн юм. Номлол мэдээж, хүнд байлаа. Урам хугарах явдал ч олон байв. Би долоо хоног бүрийн сүүлчээр түүнд илгээдэг имэйлдээ “Зогсолтгүй сэлээд бай. Хайртай шүү, аав нь” гэж бичдэг байв.

Мөн Линзи хоёр дахь жирэмсэлтийнхээ үеэр хэвлийдээ тээсэн



хүүхэд нь зүрхэндээ цоорхойтой бөгөөд төрөлхийн оюуны хомсдлын шинж тэмдэгтэй болохыг мэдсэн юм. Ийм хүнд үед нь би түүнд илгээсэн имэйлүүдээ “Зогсолтгүй сэлээд бай” гэсэн үгээр төгсгөдөг байлаа.

Бидний хүн нэг бүрийн амьдралд саад бэрхшээлүүд тохиолддог ч тэдгээрийг даван туулж, зорилгодоо хүрэхээр зогсолтгүй сэлэх ёстой.

Миний дуртай судруудын нэг бол Сургаал ба Гэрээний 121-р хэсэг юм. Энэ бол бошиглогч Иосеф Смит гүн гуниг цөхрөлд эхэлсэн ч селестиед алдар суугийн оргилд хүрсэн судрын гайхамшигтай хэсэг билээ. Сургаал ба Гэрээний 122, 123-р хэсгүүд бол сүмд хандан бичсэн Иосефын захидал байдаг. Бид эдгээр агуу илчлэлтүүдийг илүү сайн ойлгохын тулд эдгээрийг тухайн үеийн нөхцөлд нь авч үзэх ёстой.

Иосеф цөөн хэдэн дагалдагчийнхаа хамт 1838 оны 12-р сараас 1839 оны 4-р сар хүртэл Миссурийн Либэрти шоронд хоригдож байсан билээ. Шорон халаалтгүй байсан ба дөнгөж амь зогоох төдий хоол өгдөг байлаа. Тэд заваан шалтай, хүн босоогоороо зогсох боломжгүй намхан таазтай, газар доорх гянданд хоригдож байв. Энэ үед гэгээнтнүүд мөн гэр орноосоо хөөгдөж байлаа. Энэхүү үймээн самууны үед мужийн захирагч Лилбурн В.Богтс гэгээнтнүүдийг хүйс тэмтрэн, устгах шившигт тушаал гаргасан юм.

Иосеф “Ай Бурхан минь, та хаана байна вэ, мөн таны байгаа газрыг бүрхэгч тэрхүү асар хаана байна вэ?” хэмээн асуусан билээ (С ба Г 121:1). Энэ бол Бурхан Эцэг, Есүс Христ, Моронай, Иохан Баптист, Петр, Иаков, Иохан болон бусад тэнгэрлэг элчүүд зочлон ирсэн тэр Иосеф Смит юм. Иосеф эхний шүлгүүдэд тавьсан асуултуудынхаа дараа гуниг цөхрөлөө илэрхийлж, “Уур тань бидний дайснуудын

эсрэг дүрэлзэг; мөн зүрх сэтгэлийнхээ догшин хилэнд бидний эсрэг үйлдсэн буруугийн төлөө өс хонзонг маань илдээрээ аваач.

“Ай, бидний Бурхан Та зовсон гэгээнтнүүдээ санаач; мөн таны үйлчлэгчид нэрэнд тань үүрд баясах болно” (5–6-р шүлгүүд) гэжээ.

Их Эзэн Иосефын зүрх сэтгэлийн үгсийн хариуд “Хүү минь, сүнсэнд чинь амар амгалан байг; саад тогтор хийгээд зовлон зүдгүүрүүд чинь хэсэг хугацаанд байх болно” (7-р шүлэг) гэсэн билээ.

Тэгээд Тэрбээр Иосефт “Мөн тэгээд, хэрэв чи үүнийг дажгүй давбал Бурхан чамайг тэнгэрт өргөмжлөх болно; чи бүх дайснаа ялах болно” (8-р шүлэг) хэмээн гайхалтай нэгэн зарчмыг заасан юм.

Энэ захиасын утга шууд шулуун бөгөөд тод томруун юм. Бид үргэлж итгэлтэй байх болно гэж Их Эзэнд амласнаар л Тэрээр бидний сорилт бэрхшээлүүдийг зайлуулчих байх хэмээн хүсэн хүлээх ёсгүй. Үүний оронд бид тэвчээртэйгээр даван туулах ёстой, тэгвэл бид адислагдах болно. Энэ бол бид бүтгийн хувьд амьдралын гайхамшигтай сургамж юм.

Их Эзэн 10-р шүлэгт Иосефт хандан, “Чи Иов шиг хараахан биш байгаа шүү дээ, тэд Иовт үйлдсэн шиг найз нар чинь чиний эсрэг тэмцээгүй, мөн чамд зөрчлийг тохсонгүй” гэжээ. Иов хэчнээн их зовсон ч “Хүний Хүү тэд бүгдэд доош бууж ирсэн юм. Чи түүнээс илүү агуу гэж үү?” хэмээн хэлснийг бид мэднэ (С ба Г 122:8).

122-р хэсэг бол 121-р хэсгийн нэмэлт юм. Би энэ хэсгийг *хэрэв* гэсэн нөхцөлтэй хэсэг гэж нэрлэдэг. *Хэрэв* гэдэг үг энд 15 удаа давтагдаг. Жишээ нь, 5-р шүлэгт “*Хэрэв* чи гай зовлон дундуур туулахаар дуудагдсан аваас; *хэрэв* чи хуурамч ах дүүсийн дунд зовлон зүдгүүрүүдэд

байгаа аваас; *хэрэв* чи дээрэмчдийн дунд зовлон зүдгүүрүүдэд байгаа аваас; *хэрэв* чи газраар эсвээс далайгаар зовлон зүдгүүрүүдэд байгаа аваас” (С ба Г 122:5; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) гэжээ.

Хэрэв бид дээрх сорилтуудыг өнөөгийн дэлхийд бидэнд тулгардаг сорилтуудаар орлуулбал *хэрэв* манай гэр бүлд үхэл хагацал тохиолдсон бол, *хэрэв* миний найз залуу эсвэл найз охин маань намайг хаясан бол, *хэрэв* надад санхүүгийн хүндрэл тохиолдсон бол, *хэрэв* би илүү ухаалаг байсан бол гэх зэрэг сорилтуудад суралцаж чадна.

Их Эзэн эдгээр олон *хэрэв*-ийн дараа “Эдгээр бүх зүйл чамд туршлага суулгах болно, мөн чиний сайн сайхны төлөө байх болно гэдгийг чи мэдэгтүн, хүү минь” (7-р шүлэг) гэж хэлсэн юм. Өөрөөр хэлбэл, амьдралд тохиолддог сорилтууд эцсийн дүндээ бидэнд тустай хийгээд тун чухал зүйл байдаг.

“Тиймийн тул, эрхэм хайрт ах дүүс минь, өөрсдийн хүчинд байгаа бүх зүйлийг хөгжил хөөртэйгөөр хийцгээе; мөн тэгээд бид бат итгэлтэйгээр бат зогсож, Бурханы авралыг харна, мөн учир нь түүний гар илчлэгдэх болно” (С ба Г 123:17) хэмээн бошиглогч бичжээ.

Амьдрал саад бэрхшээлээр дүүрэн бөгөөд зарим нь дааж давшгүй мэт санагдаж болно. Бид тэдгээр саад бэрхшээлүүдийг итгэлтэй мөн зоригтой даван туулах ёстой. Ингэснээр бид эцэст нь Бурханд эргэн очиж, Түүнтэй үүрд хамт амьдрах болно.

### **Аврагчийн үлгэр жишээ**

Бидэнд байдаг тэсвэр тэвчээрийн хамгийн агуу үлгэр жишээ бол Аврагчийн амьдрал юм. Цагаатгал нь бүх зүйлээс доогуурт бууж ирэн, бидний төлөө төгс амьдралаа золиослохыг Түүнээс шаардсан билээ.

Тэрбээр бүх зүйлээс доогуурт бууж ирэн, хүмүүний амьдралын бүхий л зовлон зүдгүүр болон нүглүүдийн төлөө зовж, шаналснаа “бүр бүхнээс хамгийн агуу Бурхан намайг өвдөхийн улмаас дагжин чичрэх, мөн сүв бүрээс цус шүүрэх, мөн бие хийгээд сүнс аль алиныг нь зовоход хүргэсэн” (С ба Г 19:18) юм хэмээн дүрсэлжээ.

Есүс өөрөөс нь юу шаардагдаж байсныг мэдэж байсан бөгөөд энэ тухайгаа нэн хүмүүний байдлаар “Эцэг минь, хэрэв боломжтой бол Надаас энэ аягыг өнгөрүүлээч. Гэвч Миний хүслээр биш, харин Таны хүслээр болог” (Матай 26:39) хэмээн хүссэн юм. Гэсэн ч Тэр Эцэгийнхээ хүслийг биелүүлж, бүх зүйлийг хүлцэн тэвчихэд бэлэн байлаа.

### Бидний ямар хүмүүс болох нь бүгдийг өөрчилдөг

Өнөөдөр миний эзэмшиж байгаа компанийг аав минь 60-аад жилийн өмнө үндэслэн байгуулсан юм. Аав

минь 1980 онд өөд болохдоо 30 настай залуу намайг компанийн удирдагч болгон үлдээсэн билээ.

Эхний жилүүдэд хөл дээрээ бат бөх зогсож чадаагүй бизнесийнхээ ирээдүйд нөлөөлөх шийдвэрүүд гаргахыг нөхцөл байдал надаас шаарддаг байлаа. Би аавынхаа нэгэн адил шаргуу ажиллаж, хийх зүйлээ мэдэхийг хичээн, их цаг хугацааг залбиралд зориулдаг байв. Тэр бүх шийдвэрүүдэд би тайвшруулагч нөлөөг эсвээс аль нэг арга замын тухай удирдамжийг огт мэдэрдэггүй байлаа. Би хамгийн сайн гэж бодсон зүйлээ л хийж, үүнийгээ тууштай үргэлжлүүлдэг байсан юм. Гэвч би өөрийн үйлдлүүдэд ямар ч баталгаа хүлээн авдаггүй байсандаа урам хутардаг байв.

Нэг шөнө би аавыгаа зүүдлэв. Би аавыгаа хийх ёстой зүйлээ мэдэхэд минь надад тусалдаггүй байсных нь төлөө эмэлж байх юм. Аав миний нөхцөл байдлыг сайн мэдэж байсан

ч тэрээр байгаа газраа завгүй байсан бөгөөд хуучин бизнес нь түүнд тийм ч чухал биш гэж хэллээ. “Крис, бид бизнесийн талаар үнэхээр санаа зовох хэрэггүй.” “Бидний хамгийн их санаа тавих ёстой зүйл бол чи бизнесийнхээ үр дүнд ямар хүн болох нь л юм шүү дээ” гэж аав хэлэв.

Энэ бол миний хувьд хэзээ ч мартахааргүй чухал сургамж байлаа. Амьдралдаа бидний хүлээн авдаг зүйлс ялихгүй байлаа ч гэсэн, бид амьдралд ямар хүмүүс болох нь л бүхнийг өөрчилдөг юм.

Бид заримдаа мөнх бус байдлын өмнөх амьдралд Аврагчтай хамт Эцэгээс бидэнд соёрхсон ёс суртахууны сонгох эрхийн төлөвлөгөөг хамгаалан, тулалдсанаа мартдаг. Бид тэр тулалдаанд ялсан шүү дээ! Люцифер болон түүний дагалдагчид тэнгэрээс хөөгдсөн. Харин бид энэ дэлхийд амьдрах боломжийг хүлээн авсан ба үүний төлөө бид тулалдсан билээ. Эцэгийн төлөвлөгөөнд Цагаатгал багтдаг. Бидний хийх зүйл бол тулгарсан сорилт, бэрхшээлүүдийг тэвчээртэйгээр даван туулах явдал юм. Ингэсэн тохиолдолд Цагаатгал бидний амьдралд утга учраа олж, “үхэшгүй байдал ба мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Моисе 1:39) Их Эзэний ажил болон алдар сууг бид биелүүлж чадна.

Есүс бол Христ гэдгийг би гэрчилж байна. Тэр бол дэлхийн Аврагч. Тэр бол энх амгалангийн Ханхүү бөгөөд Эцэгийн өмнө бидний өмгөөлөгч билээ. Тэнгэрлэг Эцэг биднийг нэрээр нь мэддэг бөгөөд бидний төгс бишийг үл харгалзан биднийг хайрладаг гэдгийг би гэрчилж байна. Хэрэв бид итгэлтэй байж, эцсээ хүртэл тэвчвэл Тэрбээр бидэнд зориулж, байр бэлтгэх болно гэдгийг би гэрчилж байна. ■

*2012 оны 10-р сарын 30-нд Хавай дахь БЯИС дээр болсон онцгой цугларалт дээрх “That's Life (Энэ бол амьдрал)” хэлсэн үгээс авав. Англи хэл дээрх бүрэн эхийг [devotional.byuh.edu/archive-aac](http://devotional.byuh.edu/archive-aac) үзнэ үү.*



**Бид Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт амьдрах хүсэлдээ үнэнч хэвээр байхын тулд саад бэрхшээлүүд дээр ажиллах аргыг олж, амьдралд чухам юу хамгийн чухал вэ? гэдгийг нээж олох ёстой.**



Ерөнхийлөгч  
Хэнри Б.Айринг  
Тэргүүн Зөвлөлийн  
нэгдүгээр зөвлөх

ИРЭЭДҮЙН  
ГЭР  
БҮЛДЭЭ  
*БЭЛЭГ*  
БЭЛТГЭХ НЬ

Энэ жил ирээдүйн  
гэр бүлдээ зориулан  
бэлэг–хамгийн агуу  
бэлгүүдийг бэлдэцгээе.





**Б**и хамгийн сайхан бэлэг өгдөг хүн байхыг үргэлж мөрөөддөг. Би бэлгийг минь задалж үзээд зөвхөн бэлгэнд нь бус харин бэлэг өгч байгаад нь зүрх сэтгэл нь догдолж, баяр хөөрийн нулимс унаган, баясан инээж буй хүмүүсийг төсөөлөн боддог. Та нарт ч бас ийм мөрөөдөл байдаг биз ээ. Магадгүй та нарын ихэнх нь бэлэг өгөх талаар мэргэшсэн байж мэднэ.

Энэ жил илүү сайн бэлэг бэлэглэгч болох талаар хийж болох зарим зүйл энд байна. Үнэндээ, сурагчид та нарт зарим онцгой боломж байдаг. Та нар ирээдүйн гэр бүлдээ зориулан хадгалсан мөнгөн дээрээ бэлэг—бүр агуу бэлгүүдийг нэмж эхэлж болно. Би энэ тухай та бүхэнд яримаар байна.

### Бичгийн ажлууд

Та нар өнөөдөр өрөөнөөсөө эхэлж болно. Дуусаагүй бичгийн ажлууд тавиурын чинь хаа нэгтэй байна уу? (Тийм бичгийн ажлууд өрөөнд чинь байгаа гэж би бодож байна.) Магадгүй бичиж дуусчихаад хаяхад бэлэн болсон ч байж болно. Үүгээр цааш яах билээ дээ? Яагаад гэдгийг би нэг удаа Рикс коллеж (одоогийн Айдахо дахь Бригам Янгийн Их Сургууль) дээр шашны хичээл зааж байхдаа мэдсэн юм. Би Сургаал ба Гэрээний 25-р хэсгээс зааж байлаа. Энэ хэсэгт Эмма Смитэд цаг хугацаагаа “бичих хийгээд ихийг сурахад” (8-р шүлэг) зориулах ёстой гэж хэлсэн байдаг. Намайг ангийнхнаас бичгийн чадвараа хөгжүүлэхийг чухалчлан хүсэх үед ар талаас гурав дахь эгнээний орчим цайвар шаргал үстэй нэг охин хөмсөг зангидан сууж байв. Тэр гараа өргөж, “Энэ чинь миний хувьд чухал биш юм байна. Би зөвхөн хүүхдүүддээ л

захиа бичих болохоор тэр юм” гэхэд ангийнхан нь нир хийтэл инээлдэв. Би хараад л тэрээр эх хүн болж, олон хүүхдээр тойруулчихсан сууж байх нь, бүр бичсэн захиа нь хүртэл нүдэнд харагдах шиг болов. Найруулан бичих чадвар түүнд чухал биш байж болох юм.

Тэгтэл ар талд сууж байсан залуу эрэгтэй бослоо. Тэр хичээлийн жилийн туршид бага ярьдаг байсан бөгөөд өмнө нь ч гэсэн ярьдаггүй байсан гэдэгт би итгэж байна. Тэр бусад оюутнуудаас арай ахмад атлаа бүрэг ичимхий ажээ. Үг хэлж болох эсэхийг тэр асуув. Тэр Вьетнамд цэрэг байснаа намуухан дуугаар хэллээ. Ямар ч үйл явдалгүй, жирийн нэг өдөр гэж түүнд бодогдсон тэр өдөр тэрээр буугаа орхиод шуудангаар цэргүүдэд ирсэн захиалуудыг авчирч өгдөг бэхлэлт бүхий байр руу алхжээ. Тэрээр захиагаа авч байтал цэргийн бүрээ дуугарч, хүмүүс хашгиралдан, давшин ирж буй дайсны өөдөөс винтов, мина харвагчаар галах нь сонсогджээ. Тэр буугаа авах гэж буцахдаа гараа зэвсэг болгон ашиглаж байсан байна. Тэр амьд үлдсэн эрчүүдийн хамт дайсныг хөөжээ. Тэгээд тэр амьд үлдсэн болон алагдсан хүмүүсийн дунд суугаад захидлаа задлав. Захидал ээжээс нь ирсэн байв. Хэрэв хүү нь үнэнч шударга байх юм бол гэртээ эсэн мэнд эргэж ирэх болно гэдгийг өөрт нь итгүүлсэн

сүнслэг үйл явдал тохиолдсон тухай ээж нь бичжээ. Ангид уг залуу намуухнаар “Тэр захидал надад судар минь болсон юм. Би түүнийг хадгалсаар байдаг” гэж хэлээд суулаа.

Чи хэзээ нэгэн цагт хүүхэдтэй, магадгүй хүүтэй болно. Чи түүний нүүрийг харж чадах болов уу? Чи түүнийг хаа нэгтэй, хэзээ нэгэн цагт, үхлийн аюул тулгарсан үед нь харж чадах уу? Чи түүний зүрх сэтгэл дэх айдсыг мэдэрч чадна гэж үү? Энэ нь чамд нөлөөлөх үү? Чи өгөөмрөөр ямар нэг зүйл өгөхийг хүсч байна уу? Зүрх сэтгэл тань хэн нэгэнд илгээхийг хүссэн тийм захидал бичихэд ямар золиослол шаардагдах билээ дээ? Өнөөдрөөс дадлага хийж эхэл. Өрөөндөө буцаж ороод захидлаа бичин, уншиж үзээд дахин дахин бич. Хэрэв та тэр хүүг төсөөлөн бодож, зүрх сэтгэлийг нь мэдрэн, нэгэн өдөр түүнд хэрэг болох захидлын тухай бодох юм бол энэ нь золиослол биш юм шиг санагдах болно.

### Математикийн бодлого бодсон нь

Та нарын заримд нь хичээлийн дэвтэр байхгүй байж магад. Энэ нь математикийн бодлоготой дасгалын ном байж болно. Та нарын ирээдүйн амьдралын нэгэн өдрийн тухай би яримаар байна. Та “би сургуульд





үнэнээсээ дургүй” гэж хэлэх өсвөр насны хүү эсвэл охинтой болно. Та түүнийг анхааралтай сонссоны дараа дургүй зүйл нь сургууль биш, тэр тусмаа математик ч биш, харин түүний бүтэлгүйтсэн талаарх мэдрэмж болохыг нь мэдэх болно.

Та тэр мэдрэмжийг нь ойлгодог болж, сэтгэл чинь догдлон, түүнд өгөөмрөөр өгөхийг хүсэх болно. Тиймээс та бодлогын өгүүлбэрийг гаргаад “Бодлогуудаас нэгийг нь хоёулаа хамт харъя” гэж хэлнэ. Бодлого бодохдоо завиар урсгал уруудан хоёр цаг сэлж, эргээд урсгал сөрөн таван цаг сэлсний дараа урсгал хэр зэрэг хурдан бас завь хэр зэрэг хол явсан бэ? гэсэн адармаатай асуултыг хараад та гайхширах болно. “Тэгээд ээж нь ч бас математикийн бодлого бодож чаддаггүй байсныг хүүхдүүд маань хараад уруу царайлахаа болих байх” хэмээн та бодож болох юм. Би та нарт зөвлөмөөр байна: Энэ нь тэдний хувьд тааруухан бэлэг байх болно.

Үүнээс илүү дээр бэлэг байгаа, гэхдээ энэ нь хүч чармайлт шаардах болно. Аав минь хүүхэд байхдаа завьтай болон өөр олон толгой гашилгасан бодлого бодож байсан. Тэр нь химийн шинжлэх ухаанд өөрчлөлт шинэчлэлт хийх эрдэмтэн болоход нь түүнд хэрэгтэй байсан

зүйл нь байв. Гэхдээ аав минь намайг ч бас өөрчилсөн юм. Манай гэр бүлийн өрөө зарим айлынх шиг тансаг байгаагүй. Энэ нь нэг загварын тавилга—сандлууд болон ханын чимэглэл, ногоон самбар бүхий өрөө байлаа. Би та нарын хүү эсвэл охины хүрэх насанд хүрээд байсан юм. Би математикийн тэр бодлогуудыг бодож чадах эсэх нь тийм ч гайхах юм биш байлаа. Би бодлогуудыг бодож чаддаггүй ч үүндээ сэтгэл гонсойдоггүй байв. Энэ нь үнэн учраас манай зарим багш нар ч сэтгэл хангалуун байсан билээ.

Харин аав үүнд сэтгэл хангалуун байсангүй. Аав намайг бодлогуудыг бодож чадна гэж боджээ. Тиймээс бид хоёр самбарын өмнө ээлжлэн гардаг байв. Аав надад зориулж, ямар бэлэг боож, өгч байсныг би санахгүй байна. Харин би самбар болон аавынхаа намуухан дууг л санаж байна. Аавын заасан зүйл нь хэрэгтэй байсан зүйлийг минь мэдэх болон надад анхаарал тавихаас илүү тийм чухал зүйл байсан юм. Энэ нь аавд тэр үед маш үнэтэй байсан цаг заваа надад зориулахад бэлэн байхаас ч илүү зүйл байв. Одоо өөрт чинь байгаа боломж түүнд өмнө нь байсан учраас тэр цаг заваа надад зориулж байгаа юм. Тэр үед аав маань цаг заваа зориулсан учраас аав бид хоёр самбарын

урд зогсож, аав надад тусалж чадаж байсан юм шүү дээ.

Тэр надад үүнийг өгсөн учраас л би хүүтэй болж, түүнтэйгээ нэг жил хамт суух боломж надад олдсон юм. Бид хоёр миний бодож байсан бодлогуудыг бодож, нөгөө завиа дээш доош нь хөвүүлж байлаа. Багш нь түүний дүнгийн хуудсан дээр “их сайжирсан” гэж бичжээ. Харин хамгийн их сайжирсан зүйл нь юу вэ гэвэл тэр сайн хөвгүүний өөрийнхөө тухай бодох бодол нь гэж л би хэлмээр байна. Стюарт амжилтаараа бардамнаж, гэр бүлийнхээ удам дамжсан үнэт өвийн залгамжлагч байх боломжоо хагас дутуу биелүүлсэн бол би Христийн мэндэлсний баярын сүлд модны доор юу ч тавихгүй.

### Урлаг ба хөгжимд суралцахуй

Урлагийн (эсвэл хөгжмийн?) оюутнууд инээмсэглэж магадгүй. “Миний дуусаагүй даалгавруудад нуугдсан бэлэг байгаа гэдэгт тэр намайг итгүүлж чадах нь юу л бол хэмээн тэд бодож байгаа байх.” Би итгүүлэх гээд оролдоод үзье. Өнгөрсөн долоо хоногт би нэг залуу эрэгтэйн хүндэтгэлийн үйл ажиллагаанд очлоо. Бидэнд дэлгэцэн дээр зургууд үзүүлэв. Гэрэл унтрахад би хоёр хүний дууг танилаа. Нэг нь тайзны ард дуулах нэрд гарсан дуучин, нөгөө нь залуу эрэгтэйн аав, үзүүлбэрийг хөтлөгч байв.

Аав нь зургуудыг бэлтгэн, хэлэх үгсээ бичиж, хөгжим ба үгсийн чанга сул болон үргэлжлэх хугацааг яв цав тохируулахад олон цагийг зориулсан нь гарцаагүй. Та хэзээ нэгэн цагт ийм үйл явдлаар хүндэтгэл үзүүлэх хүүтэй болно. Тэрхүү үйл явдлыг бүх садан төрлүүд, авга, нагац нар чинь үзэх болно.



Та хүүдээ тэр ямар хүн болсныг мөн ямар хүн болж чадахыг нь хэлэхийг бүх зүрх сэтгэлээсээ хүсэх болно. Та тэр үед энэхүү бэлгийг өгч чадах эсэх нь одоо та түүний зүрх сэтгэлийг мэдэрч, түүгээр нөлөөлөгдөх мөн өөртөө хэрэгтэй бүтээлч ур чадварыг эзэмшиж, хөгжүүлж чадах эсэхээс тань чухам шалтгаалах болно. Энэ нь одоо өөрийн тань мөрөөдөж чадахаас илүү чухал юм гэдгийг би та нарт амлаж байна.

### Одоо наманчил

Та нарын заримд өгөхийг хүсч болох өөр нэг бэлэг байгаа бөгөөд үүнийг эртнээс бэлтгэх хэрэгтэй. Тэрхүү бэлгийг би бишоп байхдаа бэлтгэж эхэлсэн юм. Ширээний нөгөө талд нэг залуу эрэгтэй миний өдөөс харан сууж байлаа. Тэр гаргасан алдаануудынхаа тухай ярьсан юм. Тэр хэзээ нэгэн цагт хүүхдүүдтэй болж, тэдэнтэйгээ үүрд лацдан холбогдон мөн санваараа ашигладаг эцэг болохыг маш их хүсдэг тухайгаа яриад наманчлалын төлөөс болон сэтгэл санааны шаналал үнэхээрийн их байдгийг би мэднэ гэлээ. Тэгээд тэр: “Бишоп оо, би алдаагаа засна аа. Үүнд шаардлагатай юуг ч

гэсэн би хийх болно. Би алдаагаа засна” гэж хэлснийг нь би мартахгүй. Тэр гуниг зовлонг мэдэрч байсан. Мөн түүнд Христэд итгэх итгэл байв. Гэхдээ энэ нь түүнээс олон сарын туршид сэтгэлийн зовлон бүхий хичээл зүтгэлийг шаардсан билээ.

Зөв шударга санваартнуудын тэргүүддэг гэр бүлүүд хаа нэгтээ бий. Тэд энэ дэлхийд мөнхийн найдвартай бөгөөд амар амгалан байдаг. Тэрээр гэр бүлдээ бүх төрлийн гэрэл гэгээтэй бэлгүүдийг өгөх байх. Харин олон жилийн тэртээ миний өрөөнд надтай ярилцаж байхдаа бэлтгэж эхэлсэн тэр наманчлалын бэлэг агуу бэлэг байсан бөгөөд тэрээр түүнийг өгөхөө хэзээ ч болиогүй юм. Тэгээд тэрээр хүүхдүүдтэй болох нь зөвхөн мөрөөдөл биш харин хэрэгцээ гэдгийг мэдэрч, эртнээс эхлэн өгөөмрөөр өгч эхэлсэн ажээ. Тэрээр өөрийн бардамнал, залхуурал болон таагүй мэдрэмжүүдийг золиосолсон юм. Одоо бодоход энэ нь золиослол биш мэт санагддаг.

Бүр өмнө нь, өөр нэг хүн түүнд

бас үүнийг өгч байсан учраас л тэр энэхүү бэлгийг өгч чадсан юм. Бурхан Эцэг бидэнд Хүүтээ өгсөн бол, Есүс Христ бидэнд бүх бэлгүүдээс хамгийн агуу нь болох Цагаатгалыг өгсөн билээ. Аврагч бид бүгдэд болон дэлхий дээр амьдарч байсан бөгөөд амьдрах хүн бүр дээр ирэх гай зовлон ба нүглийн бүх уй гацууг биеэрээ туулсан билээ (Еврей 4:14–16-г үзнэ үү).

Есүс бид бүгдэд энэхүү бэлгийг үнэгүй бөгөөд дуртайяа өгснийг би та бүхэнд гэрчилж байна. Хэмжээлшгүй золиослолоор өгөгдсөн энэхүү бэлгийг та нар хүлээн авснаар энэ нь өгч буй түүнд мөн баяр баясал авчирдаг юм гэдгийг би та бүхэнд гэрчилж байна (Лук 15:7-г үзнэ үү).

“Үнэгүйгээр авснаа үнэгүйгээр өг” (Матай 10:8). Бид үнэгүйгээр өгдөг байхын төлөө би залбирч байна. Бидэнд бусдын санаа бодлоос сүнснийг мэдэрч, шахалт шаардлагагүйгээр эсвэл ашиг олох бодолгүйгээр өгдөг байхын төлөө болон бидний хийсэн золиослол өөр хэн нэгний зүрх сэтгэлд баяр баяслыг авчирч, бидэнд үнэ цэнэтэй байхын төлөө би залбирч байна. ■

*1980 оны 12-р сарын 16-нд Бригам Янгийн Их Сургууль дээр болсон онцгой цугларалт дээрх “Gifts of Love (Хайрын бэлэг)” хэлсэн үгээс авав. Англи хэл дээрх бүрэн эхийг [speeches.byu.edu](http://speeches.byu.edu)-аас үзнэ үү.*





## МЮЧЕЛИЙН 2014 ОНЫ УРИА



*“Христэд ирэгтүн, мөн түүгээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтүн”  
(Моронай 10:32).*



*Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл*

### ХРИСТЭД ИРЭГТҮН

*Залуу эрэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл*

**А**роны санваартан залуу эрэгтэйчүүд ээ, манай мючелийн энэ жилийн уриа нь бидний Аврагч бөгөөд Гэтэлгэгч Есүс Христтэй харилцах бидний харилцааны талаар, түүнчлэн та бүхэн хэрхэн Түүнтэй адилхан болох талаар бодоход тань сүнслэгээр нөлөөлөх болно. Бидний уриа бол “Христэд ирэгтүн мөн түүгээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтүн” (Моронай 10:32) юм.

Энэ бол Бурханы Хүүд ойртох ариун урилга юм. Бид Түүний Цагаатгалын ачаар бусдад үйлчлэх, өөрсдийн амьдрал дахь бурханлаг бус зүйлүүдээс татгалзах болон Түүний хязгааргүй хайрыг мэдрэх хүчийг олж чадна. Ингэснээр бид жинхэнэ амар амгалан ба аз жаргалыг олох болно.

Та нар Христэд ирэх урилга дээр үйлдсэний дагуу “бүхнийг Христэд ирэхэд урих” (С ба Г 20:59) ариун үүргээ ойлгох болно. Та бүхэн өөрсдийнхөө хүлээн авсан болон хүлээн авсаар байгаа адислалуудыг бусад хүмүүст хүртээмжтэй болгохын тулд тэднийг Түүн рүү удирдах хүслээр зүрх сэтгэл тань дүүргэгдэх болно.

Майкл хэмээх нэг залуу сургуулийнхаа нэг найз Хосед тусалснаар энэхүү үүргээ биелүүлжээ.

Нэгэн өдөр Хосе “Майкл аа, чи яагаад үргэлж баяртай байдаг юм бэ?” гэж түүнээс асуухад

Майкл “Би бусдад үйлчилдгээс л тэр” гэж хариулжээ.

“Чи яагаад бусдад үйлчилдэг юм бэ?”

“Учир нь би санваар атгадаг бөгөөд

үйлчлэх нь миний үүрэг” гэж Майкл хариулав.

Тэгэхэд нь Хосе “Би санваарын тухай илүү ихийг мэдмээр байна” гэжээ.

Майкл Хосег сүмийн үйл ажиллагаануудад дараа нь сүмийн цуглаануудад урьжээ. Эцэстээ Хосе болон түүний гэр бүлд номлогчид зааж, тэд баптисм хүртсэн ажээ. Хосе “Номлолын ажил бол манай сүмийн үндэс суурь мөн. Хэрэв бид өдөр тутмын ажил үйлсдээ үнэнч шударга байвал бидний эргэн тойрон дахь хүмүүс биднийг ажиглаж, миний асуусан шиг асуултыг биднээс асуух болно. Майкл бол Бурханы агуу төлөвлөгөөнд багтсан нэгэн хөлөг юм” гэж хэлсэн билээ.

“ ‘Христэд ирэгтүн’ гэсэн үгс нь урилга юм. Энэ бол таны өөр хүнд санал болгож чадах хамгийн чухал урилга билээ. Энэ нь мөн хүмүүний хүлээн авч чадах хамгийн чухал урилга юм.”<sup>1</sup>

Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б.Айринг

Та нар Их Эзэнд ойртсоноор Майклтай адил бусдад үйлчлэх хүсэлтэй байх болно. Та нар ийм хүсэлтэй болсноор Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх, ерөнхийлөгч Хэнри Б. Айрингийн дараах амлалт үнэн гэдгийг мэдэж авна: “Та нар хүмүүсийг Христэд ирэхэд урих ажилд зүрх сэтгэлээ зориулбал зүрх сэтгэл тань өөрчлөгдөнө. Та нар Түүний ажлыг Түүний өмнөөс хийх болно. Тэрбээр үйлчлэлд тань та нартай нэг байх болно гэсэн амлалтаа биелүүлдгийг та нар мэдэж авна. Та нар Түүнийг мэдэх болно. Тэгээд та нар хэсэг хугацааны дараа Түүнтэй адилхан болж, ‘түүтээр төгөлдөржих болно.’”<sup>2</sup>

Энэ бол энэ жилийн урианы үндсэн гол санаа юм. ■

#### ЭШЛЭЛҮҮД

1. Хэнри Б.Айринг, “Христэд ирэгтүн,” *Лиакхона*, 2008 оны 3-р сар, 49-р хуудас.
2. Хэнри Б.Айринг, “Христэд ирэгтүн,” *Лиакхона*, 2008 оны 3-р сар, 52-р хуудас.

## ТА УРИГДСАН

### Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

Урилга хүлээн авах дургүй хэн байх билээ? Бид хэн нэгний төрсөн өдрийн үдэшлэг эсвэл хуримын урилга хүлээн аваад тэдний амьдрал дахь чухал үйл явдлыг тэдэнтэй хамтран тэмдэглэх боломжтой байгаадаа баяртай байдаг. Мючелийн 2014 оны уриа нь: “Христэд ирэгтүн мөн түүтээр төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун” (Моронай 10:32) гэсэн мөнхийн ач холбогдол, баяр баясгалантай урилга юм.

Олон урилга нь урилгыг хүлээн авсан эсвэл хүлээн аваагүйг харуулахын тулд хариу ирүүлэхийг хүссэн байдаг. Та нар амьдралдаа энэхүү урилгад хариулж байсан уу? Христэд ирэх гэдэг нь бид баптисмынхаа үеэр хийсэн ариун гэрээгээ сахих гэсэн үг юм. Энэ нь бид Есүс Христийг өөрийнхөө Аврагч ба Гэтэлгэгч гэдгийг хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Энэ нь Алма хүү Шиблондоо “Христэд мөн түүтээр бус аваас хүмүүн аврагдаж чадах өөр зам эсвээс арга үгүй” (Алма 38:9) хэмээн заасан зүйлийг бид хүлээн зөвшөөрч, үүнд итгэдэг гэсэн үг юм. Энэхүү урилгыг хүлээн авах нь бид ариун амьдралаар амьдарч, бусдыг хайрлан, тэдэнд үйлчилснээр Христийн үлгэр жишээг дагахдаа шийдвэр төгс байх ёстой гэсэн үг юм.

Энэхүү урилга нь нэг удаагийн үйл явдал биш, харин байнгын үйл явц юм. Бид Тэнгэр дэх Эцэгтэйгээ нэмэлт гэрээнүүдийг хийж, өөрсдийн авралд зайлшгүй шаардлагатай ёслолуудад оролцохын тулд ариун сүм рүү хөтлөх замыг дагахад уригдсан билээ. Номлолд үйлчлэх нь уг замд багтаж болно. Үүнд ариун сүмийн гэрлэлт болон Бурханы хаант улс дахь зөв шударга эрэгтэй, эмэгтэйчүүд болох зэрэг нь багтана. Энэ нь бас эцсээ хүртэл тэвчих гэсэн үг



Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгчийн зөвлөл

юм. Энэхүү урилгад хэлснээр, бид Христэд ирвэл түүгээр төгөлдөржиж чаддаг. Түүнд итгэх итгэлээр болон наманчлалаар дамжуулан энэхүү гэрээний зам дээр үлдэхийг Христ бидэнд боломжтой болгосон билээ. Төгс төгөлдөр болох энэхүү үйл явцыг өнөөдөр эхэлж болно. Христийн Цагаатгал үүнийг боломжтой болгосон юм.

Энэхүү урилга нь дэлхийн хувцасны загвар мөн дэлхийн жишиг болон дадал зуршлуудаас өөр байж, бүх бурханлаг бусаас өөрсдөө татгалзахыг биднээс хүсдэг. Бид “энэ дэлхийн зүйлүүдийг хойш тавьж, мөн илүү сайн зүйлүүдийг эрэлхийлэхэд” (С ба Г 25:10) уригдсан билээ. “Христэд ирж, түүгээр төгөлдөржих” урилгыг хүлээн авах нь энэ амьдрал дахь аз жаргал, ирэх дэлхий дэх мөнх амьдрал руу хөтлөх болно гэдгийг бид гэрчилж байна. Та нар өнөөдөр хариу үйлдэхэд уригдсан! ■

# Моронай 10:32

Энэ жилийн мючелийн уриа нь Аврагчийг дагах Моронайн урилга юм.



## Түүгээр төгөлдөржигтүн

“Хэрэв төгөлдөржилтийн төлөөх бидний хичээл зүтгэл дэндүү хэцүү, эцэс төгсгөлгүй юм

шиг санагдвал бид шантрах ёсгүй. Төгөлдөржилт нь байнгын үйл явц бөгөөд зөвхөн амилуулалтын дараа Их Эзэнээр дамжин бүрэн биелэгдэх болно. Энэ нь түүнийг хайрладаг бөгөөд зарлигуудыг нь сахидаг бүх хүмүүст боломжтой юм.”

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Рассэлл М.Нэлсон, “Perfection Pending,” *Ensign*, 1995 оны 11-р сар, 88-р хуудас.

## Бурханыг хайрла

Та Тэнгэрлэг Эцэгийг хайрладгаа Түүнд хэрхэн харуулж чадах вэ? Эдгээр санаануудыг анхаарахын хамт өөрөө илүү шинэ санаанууд гаргана уу. Юу хийхээр төлөвлөж байгаагаа тэмдэглэлдээ бичнэ үү.

- Зарлигуудыг сахь.
- Бусдыг хайрлаж, тэдэнд үйлчил.
- Сүм дэх үүргүүдээ биелүүл.
- Чин сэтгэлээсээ залбир.

## Яав ч

Яав ч гэдэг нь арга байхгүй, огт болохгүй гэсэн утгатай.

## Христэд ирэгтүн

Христэд ирэх олон урилга судруудад агуулагддаг. Доор жагсаасан цөөн жишээг харна уу. Бид Аврагчид ирснээр ямар адислалууд хүлээн авдаг тухай доорх судрууд юу зааж байна вэ? Та ийм урилга агуулсан өөр судруудыг олж чадах уу?

- Омнай 1:26
- Алма 5:34–35
- 3 Нифай 12:19–20
- Матай 11:28–30
- Иохан 6:35

32 Тийм ээ, Христэд “ирэгтүн, мөн түүгээр “төгөлдөржигтүн, мөн бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзагтун; мөн хэрэв та нар бүх бурханлиг бусаас өөрсдөө татгалзаж, мөн Бурханыг өөрсдийн бүх хүч, оюун, мөн чадлаар “хайрлах аваас, тэгвэл түүний ач ивээл та нарт хангалттайгаас түүний ач ивээлээр та нар Христээр төгс байж болно; мөн хэрэв Бурханы ач ивээлээр та нар Христээр төгс аваас, та нар Бурханы хүчийг яав ч үгүйсгэж чадахгүй.”

## Ач ивээл

Судруудад хэрэглэгдсэнээр “ач ивээл гэдэг үг нь Их Эзэн Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан бидний хүлээн авдаг бурханлаг тусламж хийгээд хүч чадлыг заадаг.”

Итгэлдээ үнэнч байх нь: Сайн мэдээний эшлэлүүд (2004), 77.



## Түүний ач ивээл та нарт хангалттай

“Христийн зарим шашинтнууд . . . хожмын үеийн гэгээнтнүүдийг авралдаа өөрсдөө хүрч

чадна хэмээн Бурханы ач ивээлийг үгүйсгэдэг гэж зэмлэн, буруутгадаг. Учир нь бид Христэд итгэж, мөн Бурханд нийцсэн байхыг хүүхдүүддээ . . . ятгахын тулд бичихээр хичээнгүйлэн хөдөлмөрлөв; учир нь бид ач ивээлээр л бид аврагдана гэдгийг мэднэ, бидний хийж чадах бүхний дараа буюу гэсэн үгсээр бид энэхүү буруутгалд хариулдаг (2 Ниф. 25:23). Тэгвэл ‘Бидний хийж чадах бүхэн’ гэж юу вэ? Энд наманчлал, баптисм, зарлигуудыг сахиж болон эцсээ хүртэл тэвчих нь багтана” (Алма 24:11-ийг үзнэ үү).

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Даллин Х.Өүкс, “Have You Been Saved?” *Лиахона*, 1998 оны 7-р сар, 68-р хуудас; *Ensign*, 1998 оны 5-р сар, 56-р хуудас.

## Христээр төгөлдөржигтүн

Судруудад хэрэглэгдсэнээр төгс гэдэг үг нь “төгс төгөлдөр, бүрэн дүүрэн хөгжсөн, туйлын зөв, шуударга гэсэн утгатай. Төгс гэсэн үг нь мөн нүгэл хилэнцгүй гэсэн утгатай. Зөвхөн Христ бүрэн төгс байсан юм. Христийн жинхэнэ дагалдагчид түүний ач ивээл болон Цагаатгалаар дамжин төгс төгөлдөр болно” (Судруудын удирдамж, “Төгс” scriptures.lds.org).

# ХРИСТЭД ИРЭГТҮН

“Христэд ирэгтүн, мөн түүгээр  
тегэлдөржигтүн, мөн бурханлиг  
бусаас өөрсдөө татгалзагтүн”

(Моронай 10:32).



# БУРХАН ТЭРГҮҮТЭНИЙГ МЭДЭХ нь НАМАЙГ ӨӨРЧИЛНӨ ГЭДГИЙГ БИ ХЭРХЭН МЭДЭХ ВЭ?

*Бурхан Тэргүүтэний тухай таван зарчим таны амьдралын хэв маягийг өөрчилж чадна.*

**Лори Фүллэр**

Сүмийн сэтгүүлүүд

**И**осеф Смит “Бурханы шинж чанарыг эргэлзээгүйгээр мэдэх нь сайн мэдээний анхдагч зарчим юм” гэж хэлжээ.<sup>1</sup> Бурхан Тэргүүтэний тухай бидний мэдлэг бидний амьдралын хэв маягийг, зөвхөн том зүйлсийг төдийгүй бас өдөр тутмын жижиг сажиг зүйлсийг ч өөрчилж чадна. Та эдгээр таван зарчмын тухай уншсанаар Бурхан Тэргүүтэний тухай мэдлэг амьдралд тань хэрхэн нөлөөлснийг авч үзээрэй.

**Бурхан Тэргүүтэн биднийг хайрлаж, бидэнд хамгийн сайн сайхныг хүсдэг.**

Бурхан Тэргүүтэний гишүүд үүрд мөнх оршиж, бүхнийг чаддаг ч биднийг аз жаргалтай, амжилт бүтээлтэй байхын төлөө санаа тавьж байдаг юм. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли (1910–2008) “Бурхан Тэргүүтэн биднийг анхаардаг бөгөөд бид Тэдний үйл хэргийн төвд байдаг билээ. Бидний хүн нэг бүрд Тэд нээлттэй байдаг. Бид Хүүгээр дамжуулан Эцэгт хүрдэг билээ. Хүү бол Бурханы хаан сэнтийний өмнө бидний зуучлагч юм. Бид Эцэгт хандан Хүүгийн нэрээр ярьж болдог нь хэчнээн гайхамшигтай билээ” гэсэн юм.<sup>2</sup>

Бурхан Тэргүүтэний гишүүд биднийг хайрлаж, бидэнд хамгийн сайн сайхан бүхнийг хүсдэг учраас сонголтууд маань ялангуяа биднийг Тэдэнд улам ойртуулдаг бидний өдөр тутам хийдэг жижиг зүйлс хүртэл чухал байдаг юм. Бидний боломжууд хязгааргүй бөгөөд Бурхан бидний амжилтад, бүр жижиг зүйлсэд ч гэсэн санаа тавьж байдаг.

**Тэнгэрлэг Эцэг бидэнд бүх зүйлийг өгсөн.**

Тэнгэрлэг Эцэг бидэнд бүхнийг өгсөн гэдгийг бид мэдэх учраас бид Түүний мутрыг таньж, талархалтай байхыг хичээх ёстой. Хэрэв бид талархалтай байвал бидний үйлдэл өөр байх болно. Ерөнхийлөгч Томас С.Монсон “Бид атгаг санаа өвөрлөхгүй байж, зүрх сэтгэлдээ талархлыг



хөгжүүлэн, төлөвшүүлсэн үед өөрсдийгөө болон өрөөл бусдыг өргөн, дэмжиж чадна” хэмээн амласан билээ.<sup>3</sup>

Бидэнд байгаа юм бүхэн Бурханаас ирсэн учир бидний талархал биднийг бусадтай хуваалцах илүү их хүсэлтэй болгодог (Мозая 2:20–21; С ба Г 59:21-ийг үзнэ үү). Ийнхүү хуваалцах зүйлд бидний цаг зав, авьяас чадварууд болон материаллаг адислалууд орно.

### Тэнгэрлэг Эцэг маань нигүүлсэнгүй билээ.

Түүний ажил ба аддар суу нь “үхэшгүй байдал хийгээд мөнх амьдралыг хүмүүнд тохиолгон авчрах” (Мосе 1:39) явдал юм. Тэрбээр биднийг амжилттай байхыг хүсдэг, тиймээс бидний алдаануудад Тэрээр өршөөлийг үзүүлдэг. Бид өмнө гаргасан алдаагаа давтахад ч гэсэн Тэрбээр биднийг нигүүлсэнгүйгээр өршөөдөг. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ, Ариун Сүнс гурав өөрчлөгдөхөд маань бидэнд туслах болно.

Бурханы нигүүлсэл бидэнд өршөөнгүй байхыг заадаг. Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф “Бурхан бидэнд маш их хайртай учраас бид бие биеэ хайрлаж, уучлах ёстой” гэж хэлжээ.<sup>4</sup> Бид бас өөрсдийгөө уучлах ёстой.

### Есүс Христ бидний төлөө зовсон.

Аврагч Цагаатгалаар дамжуулан бидний бүх өвдөлт, уй гашууг амссан юм (Алма 7:11–13-ыг үзнэ үү). Хэрэв бидэнд хүнд үе тулгарч, хэн ч биднийг ойлгохгүй байгаа юм шиг санагдвал Аврагч биднийг *ойлгодог* гэдгийг бид мэдэж болно. Тиймээс бидэнд сайхан цаг ирж, үүнийг хэн нэгэнтэй хуваалцахыг хүсэхэд мөн Аврагч бидний төлөө хамт байх болно. Тэрбээр бидний өвчин

зовлонг хуваалцдаг шигээ бидний баяр баяслыг бас хуваалцахыг хүсдэг.

### Ариун Сүнс биднийг удирддаг.

Аврагч Өөрийн төлөөлөгчдөд Тайтгаруулагч буюу Ариун Сүнс тэдэнд зааж, тэднийг тайтгаруулан, үргэлж тэдэнтэй хамт байх болно хэмээн амласан (Иохан 14:16–17, 26–27-г үзнэ үү). Бид ч бас өөрсдийгөө удирдуулах Ариун Сүнсний бэлэгтэй байж болно. Ариун Сүнсний өгдөг хариулт бидэнд туслах болно гэдэгт бид мөн итгэж болно. Бид Түүний удирдлагаар Бурхан Тэргүүтэнтэй байнга холбоотой байж чадна. Бид хүлээн авсан сүнсний өдөөлтүүдээ дагавал Тэднийг бүр илүү сайн мэддэг болно. ■

#### ЭШЛЭЛҮҮД

1. Иосеф Смит, *History of the Church*, 6: 305.
2. Гордон Б.Хинкли, “Би эдгээр гурван зүйлд итгэдэг,” *Лиахона*, 2006 оны 7-р сар, 8-р хуудас.
3. Томас С. Монсон, “Талархлын бурханаг бэлэг” хэлсэн үгээс эш татав, *Лиахона*, 2010 оны 11-р сар, 95–99-р хуудсууд.
4. Дийтр Ф.Угдорф, “Өршөөнгүй хүмүүс өршөөл энэрлийг хүлээн авна,” хэлсэн үгээс эш татав, *Лиахона*, 2012 оны 5-р сар, 76-р хуудас



## ХАМТДАА ЯРИЛЦ



### Ням гарагт тунгаан бодох зүйлс

- Таныг Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ эсвэл Ариун Сүнс хэзээ адисалж байсан бэ?
- Та Тэдэнтэй хэдийд хамгийн ойр байгаагаа мэдэрсэн бэ?
- Та Тэдний тухай суралцсанаар өөрийнхөө талаар юу мэдэж авч болох вэ?

### Таны хийж болох зүйлс

- Та Бурхан Тэргүүтэнийг мэдсэнээр хэрхэн өөрчлөгдсөн тухайгаа тэмдэглэлдээ бичнэ үү.
- Бодол санаагаа сүм дээр эсвэл хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуваалцана уу.

ГЭРЭЛ ЗУРАГ: ЧИМЭГЛЭЛИЙГ ВЭЛДЭН К.АНДЭРСЭН, МАТТЬО РЭЙЭРНАР, АНХНЫ ҮЗЭЛДЭЛ, ДЭЛ ПАРСОН, ХРИСТ ГЕГСЕМАНИД, ХАРРИ АНДЭРСОН



**Лари М.Гибсон**

Залуу эрэгтэйчүүдийн  
ерөнхий ерөнхий-  
лөгчийн зөвлөлийн  
нэгдүгээр зөвлөх

# Би үргэлж ТҮҮНИЙГ ДУРСАН САНАДАГ

*Хүндэтгэлийн өдрийг бид хэрхэн сахдаг нь Есүс Христийг  
үргэлж санах бидний гэрээний гадагд илрэл юм.*

Намайг 11-тэй байхад манай бишоп тойргийн цуглааны шинэ байранд намайг хүндэтгэлтэйгээр дагуулан орж, ариун ёслолын ширээний өмнө надтай хамт суусныг би санадаг. Тэр надад “Ларри, чи удахгүй Аароны санваарын диконы албанд томилогдох болно. Энэ нь ямар онцгой адислал болон үүрэг гэдгийг чи мэдэж байгаа биз дээ?” гэсэн юм. Тэр надад сүмийн гишүүд ариун ёслолын эрхэм нандин бэлгэдлүүдийг гүйцэтгэн, үйлчлэхэд Аврагчийн адилаар үйлдэх ариун үүрэг надад ноогдож байгаа талаар ярих. Би хүлээн авах санваарын дуудлагынхаа ач холбогдлыг сүрдэн биширч билээ.

Ариун ёслолын залбирлуудыг чээжилж, эдгээр нь хэрхэн миний амьдралын нэг хэсэг болох талаар бодохыг бишоп надаас хүссэн юм. Хэрэв Аврагчийг төлөөлөн, ариун ёслолыг бусдад түгээхийг надаас хүсвэл ариун ёслолын залбирлуудын бидний хүн нэг бүрээс хийхийг хүсдэг зүйлсийг би хийхийг хичээх ёстой гэж тэр хэлэв. Гэртээ эргэж ирсний дараа аав надад Сургаал ба Гэрээ (20:76–79) болон Мормоны Номоос ариун ёслолын залбирлуудыг олоход тусалсан юм (Моронай

4; 5). Би амьдралдаа анх удаа эдгээр залбирлуудыг анхааралтай уншлаа. Сүм дээр эдгээр залбирлуудыг хэлэхэд би анхааралтай сонсдог байв. Талх түгээж байхдаа би залбирлын үгсийг тунгаан боддог ч усны адислал дахь “гэд түүнийг үргэлж санан” гэсэн үгсийг сонсоод ариун ёслолын гэрээний утга учрыг бүрэн ойлгосон юм. “Би үргэлж Түүнийг санадаг бил үү? *Үргэлж* гэдэг чинь юу гэсэн үг вэ? Би Түүнийг хэрхэн үргэлж санаж чадах билээ?” гэж өөрөөсөө асуулаа. Би ариун ёслолын залбирлуудыг сонсох бүрдээ сүнслэгээр нөлөөлөгдөн, эдгээр асуултуудыг эргэцүүлэн боддог байв.


Хүндэтгэлийн өдрийг бид хэрхэн ариунаар сахих нь Есүс Христийг үргэлж санах Тэнгэрлэг Эцэгтэй хийсэн бидний гэрээний гадаад илрэл мөн. *Хүндэтгэлийн өдөр нь долоо хоногийн бусад зургаан өдөр Түүнийг дурсан санахад суурь болдог.*

Ням гараг бол амрах болон дурсан санах өдөр юм. Бид сүмийн цуглаануудад оролцож, хүч чадал, адислалууд болон алдаа дутагдлаа бодож, өршөөлийг эрэлхийлэн, ариун ёслолоос хүртэж, бидний төлөө Аврагч хэрхэн зовсныг тунгаан

боддог. Бид Түүнийг шүтэн бишрэхэд саад болох аливаа зүйлсээс зайлсхийхийг хичээдэг, учир нь “энэ өдөр . . . чи өөр юу ч хийх ёсгүй” (С ба Г 59:13) хэмээн Их Эзэн хэлсэн билээ. Хүндэтгэлийн өдөр бидний оролцдог аливаа үйл ажиллагаа Христийг санах уур амьсгалд зохицсон байх ёстой. Хэрэв хүндэтгэлийн өдөр хийдэг аливаа зүйл маань Аврагчийг санах болон энэ өдөр Тэр хэрхэн үйлчилдэг байсантай адил үйлчлэхээс биднийг холдуулж байвал бид хийж байгаа зүйлээ эргэн харах хэрэгтэй. Хүндэтгэлийн өдөр бол зөвхөн “хөдөлмөрүүдээсээ амрах” төдийгүй бас “Бүхний Дээдэд чи бүхнээ зориулахаар чамд өгөгдсөн өдөр” (С ба Г 59:10) гэдгийг санагтун.

Их Эзэний өдрийн аль ч хэсгийн ариун байдлаас биднийг холдуулах аливаа шалтаг байхгүй тийм замаар бид амьдралаа төлөвлөх ёстой. Энэ бол Түүний ажил хэргийн өдөр бөгөөд бидний хувь хүн бүрийн болон гэр бүлийн амьдрал бүхэлдээ адислагдан, ариун туршлагуудаар шинэчлэгддэг өдөр юм. Энэ бол бидний хувьд сүнслэг байдлаа баяжуулах өдөр юм.

Амьдралдаа хүндэтгэлийн өдрийг үнэхээр ариун өдөр



болгох зүйлсийг хийж занших төлөвлөгөө боловсруулж, мөрдөхийн төлөө яг одоо цаг гарга. Тэгээд төлөвлөгөөнийхөө дагуу ажилла.

Их Эзэн хүндэтгэлийн өдрийг зохих ёсоор эрхэмлэн сахидаг хүмүүст “эдгээр зүйлүүдийг та нар талархалтайгаар, баяр хөөртэй зүрх сэтгэл хийгээд хөгжил хөөртэй дүр төрхтэйгөөр хийхийн хэрээр . . . , дэлхийн бүрэн байдал та нарынх бөлгөө” (С ба Г 59:15–16) хэмээн гайхамшигтай амлалт өгснийг санагтун. Бид өөрсдийн болон гэр бүлийнхээ гишүүдийн амьдралд эдгээр адислалуудаас татгалзаж чадна гэж үү?

Хүндэтгэлийн өдрийг дээдлэн хүндэтгэхэд би итгэдэг. Хүндэтгэлийн өдрийг сахих нь амьд бөгөөд бид бүгдийг хайрладаг бидний Бурханы зарлиг юм гэдгийг би зоригтой боловч даруухнаар гэрчилж байна. Хэрэв бид хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих бурханлаг зарлигийг биелүүлж, үүгээр амьдрах юм бол Их Эзэн хариуд нь биднийг адислан, удирдаж, бидэнд тулгардаг асуудлуудыг шийдвэрлэхэд сүнс­лэгээр нөлөөлөх болно гэдгийг би гэрчилж байна. ■



# АМЖИЛТАА

## ахиулсан нь

Даниэл Кавай

Намайг 14-тэй байхад физикийн багш маань намайг математикт авьяастайг мэдээд Бразилын математикийн олимпиадад оруулсан юм. Олимпиад гурван ангилалтай байлаа. Нэг, хоёр дахь ангилал нь бямба гарагт болох байв. Би гурав дахь ангилалд орсон бөгөөд олимпиад хоёр өдөр дараалан бямба, ням гарагуудад болох байлаа.

Тиймээс би олимпиадын багш, захирал хоёрт ням гараг бол Их Эзний өдөр учраас би энэ өдөр оролцож чадахгүй гэдгээ хэллээ. Захирал надад сүмийн удирдагчдаа хэлж, ням гарагт чөлөө аваад тэмцээнд оролцож болно шүү дээ, хэрэв тэмцээнд оролцохгүй бол чи хасагдана гэлээ. Би бүх зүйлээс татгалзаж чадна, харин Бурханаас л чадахгүй гэж хэллээ.

Бурхан Өөрийг нь хүндэлдэг хүмүүст хүндэтгэлтэй ханддаг гэдэгт би найддаг байсан учир гунигласангүй. Матай 6:33-т: “Харин эхлээд Түүний хаанчлал болон Түүний зөвт байдлыг хайгтун. Тэгвэл энэ бүхнийг та нарт нэмж өгөх болно” гэсэн байдгийг би саналаа.

Хэдэн долоо хоногийн дараа бид олимпиадын нарийн бичигтэй холбоо барихад тэрээр намайг өөр ямар ч өдөр тэмцээнд оролцох боломж байхгүй, хэрэв заасан өдрүүдэд оролцохгүй бол хасагдах болно гэв. Нэлээд удаан ярилцсаны дараа тэр намайг нөхцөл байдлаа тайлбарласан имэйл ирүүлэхийг зөвлөв. Би имэйл явуулсныхаа дараа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, Түүний хүслийг биелүүлэх болно гэж хэллээ.

Маргааш орой нь би олимпиадын зохицуулагчаас имэйл хүлээн авлаа. Тэр намайг ням гарагийн шалгалтыг даваа гарагт хамгийн тохиромжтой цагтаа өгч болно гээд миний өглөөний хичээлийг таслуулахгүйн тулд шалгалтыг манай хотод явуулахыг зохион байгуулагчид санал болгосон тухайгаа бичсэн байв.

Би энэхүү баярт мэдээг хүлээн авсныхаа дараа надад тусалсанд нь Их Эзэнд талархал илэрхийлж, залбирсан юм. Аав, ээж маань талархлаа илэрхийлэхээр ариун сүм рүү явж билээ.

### ХҮНДЭТГЭЛИЙН ӨДРИЙГ САХИХ ТУХАЙ ҮНДСЭН САНААНУУД

Их Эзэн хүндэтгэлийн өдрийг та нарын тусын тулд өгсөн бөгөөд ариунаар сахи- хыг тушаасан билээ.

Сүмийн бүх цуглаандаа суух нь хүндэтгэлийн өдрийг ариунаар сахи- хад ордог. . . .


“Хүндэтгэлийн өдөр хийхэд зохимж- той, сэтгэл санаа өргөх үйл ажиллагаа- нуудыг ням гарагт хийхээр бэлтгэ. . . .

Хүндэтгэлийн өдрийг сахи- х нь таныг Их Эзэнд болон гэр бүлд тань ойртуул- даг. Энэ нь бас танд аливаа зүйлсийг үүрд мөнхийн талаас нь харахад тусалж, сүнслэг хүч чадлыг өгөх болно.”

*Залуучуудын бат бөх байдлын төлөө*  
(товхимол, 2011), 30, 31.

Олимпиадын дүн гара- хад би алтан медаль ав- сан байв. Их Эзэн Өөрийг нь хүндэлдэг хүмүүст хүндэтгэлтэй ханддаг. ■

*Энэ өгүүллийн зохиогч*  
*Бразилын Сан Паулод*  
*амьдардаг.*



# НҮДЭЭ ОЛСОН ХАРИУЛТ

Залуу эрэгтэйчүүд  
18 нас хүрмэгцээ  
**НОМЛОЛД ҮЙЛЧЛЭХ**  
ёстой юу? Мөн залуу  
эмэгтэйчүүдийг 19  
настайгаасаа эхлэн  
номлолд үйлчлэхийг  
нь хүчтэй дэмждэг  
болсон уу?

Хэрэв сүмийн идэвхтэй өсвөр үеийнхэн надад  
**сүмийн жишгүүдийг зөрчих**  
**шахалт** үзүүлбэл би яах вэ? Би өөрийгөө  
бусад хүмүүсээс илүү шударга эсвэл бусдыг  
шүүдэг гэж харагдахыг хүсдэггүй.

**Е**рөнхийлөгч Томас С.Монсон номлолд үйлчлэх насанд өөрчлөлт оруулсан тухай зарлахдаа “Бүх залуу эрэгтэйчүүд заавал энэ наашлуулсан насанд номлолд үйлчлэх болно эсвэл номлолд үйлчлэх ёстой гэж би хэлээгүй шүү. Харин хувийн нөхцөл байдлууд дээр болон санваартны удирдагчдын шийдвэрт үндэслэн, энэхүү боломжийг бүтгэд олгож байгаа юм” гэжээ.<sup>1</sup> Биеийн болон сэтгэл санааны эрүүл мэнд, санхүүгийн мөн сүнслэг байдлын бэлтгэлээ харгалзан үзээрэй. Номлолд үйлчлэх цагаа зөв шийдэхдээ чи дээрх зүйлүүдийн тухай эцэг эх болон санваарын удирдагчидтайгаа зөвлөж болно.

Ерөнхийлөгч Монсон залуу эмэгтэйчүүдийн талаар “Залуу эмэгтэйчүүдэд . . . залуу эрэгтэйчүүдтэй адил заавал үйлчлэх зарлигийг өгөөгүй юм. Гэхдээ сүмийн залуу эгч нар номлогчийн ажлаараа маш үнэтэй хувь нэмэр оруулдаг учраас бид тэдний үйлчлэлийг дуртайяа хүлээн авах болно гэдгийг баттайгаар хэлж байна” гэжээ.<sup>2</sup> ■

## ЭШЛЭЛҮҮД

1. Томас С.Монсон, “Чуулганд тавтай морилно уу,” *Лиахона*, 2012 оны 11-р сар, 4–5-р хуудсууд.
2. Томас С.Монсон, “Чуулганд тавтай морилно уу,” 5.


**С**үмийн жишгүүдийг хамгаалах зоригтой бай, бүр эдгээр жишгүүдийг мэддэг бөгөөд өөрийг чинь бусдаас илүү шударга хүн болж харагдах гэж байна гэж бодож мэдэх хожмын үеийн гэгээнтэн өсвөр үеийнхнээс ирж болох дарамт шахалтаас өөрийгөө хамгаалах зоригтой бай. Их Эзэний зарлигуудад дуулгаваргүй байх эсвэл зөвхөн

бусдад шударга хүн болж харагдахын аль нь илүү эрсдэлтэй вэ? (Хэрэв үе тэнгийнхэн чинь *өөрийн чинь* хувьд таагүй санагдах эсвэл сүмийн аль нэг жишгийг бус харин танай *гэр бүл* дэх жишгийг зөрчих шахалт үзүүлж байгаа бол чи зүгээр л үүнийг хиймээргүй байгаагаа хэлээд бодол санаандаа хүндэтгэлтэй хандахыг тэднээс хүсч, өөрийгөө хамгаалах хэрэгтэй.)

Мэдээж хэрэг, чи ийм нөхцөл байдлыг бошиглогч Алма, номлогч хүү Шиблондоо “зоригийг хэрэглэ, гэвч бүү дээрэлх” (Алма 38:12) гэж хэлсэн шиг хэнийг ч гомдоолгүйгээр эвтэйхэн шийдэх хэрэгтэй. Бусдыг хатуугаар зэмлэх юм уу өөрийгөө ёс суртахууны хувьд бусдаас гаргуун нэгэн мэтээр харуулах гэж хичээсний хэрэггүй. Чи ямар жишгүүдээр амьдрахаар сонгосноо хүмүүст зүгээр л илэн далангүй хэлэх хэрэгтэй. Хэрэв сүмийн идэвхтэй гишүүд сүмийн тодорхой жишгүүдийг зөрчихийг өөрөөс чинь хүсвэл “Бүх хүмүүст найз нь бай, гэвч жишгүүдээсээ хэзээ ч бүү ухар” хэмээн хэлсэн Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорфын үгийг санагтун.<sup>1</sup> ■

## ЭШЛЭЛ

1. Дийтр Ф.Угдорф, “Та нарын гэртээ харих гайхамшигт аялал,” *Лиахона*, 2013 оны 5-р сар, 128-р хуудас.



# ДАВХАР АДИСЛАЛ



Ариун сүмд орох болон гэр бүлийн түүхийн ажлын аль аль нь чухал бөгөөд эдгээрийг нэгтгэвэл улам олон адислалуудыг авчирдаг.

**Британи Бэтти**  
Сүмийн сэтгүүлүүд

**Т**а энэ сарын *Лиахона*-ийн хуудсуудыг нэг бүрчлэн эргүүлэн харахдаа зураг, дизайн болон уран зураг бүрийг сонирхолтой, дур татам болгох олон өнгийн хослолуудыг хараарай. Хоёр үндсэн өнгө—улаан, шар эсвэл цэнхэр өнгө нийлж, нэгэн шинэ өнгө бий болгожээ. Хэрэв үндсэн өнгүүдийг тус тусад нь хэрэглэсэн бол ийм өнгө бий болохгүй байсан юм.

Гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажил нь эдгээр өнгөнүүдтэй

адил юм. Та энэхүү хоёр чухал ажлыг нэгтгэн хийснээр улам олон адислалуудыг хүлээн авч чадна. Яагаад гэвэл гэр бүлийн түүх болон ариун сүмийн ажил нь үнэндээ нэг ажил—авралын ажлын хоёр тал юм. Мэдээж хэрэг, та гэр бүлийн түүхээ бичихэд нь бусдад тусалж, нэрсийг нь бэлтгэсэн хүмүүсийн төлөө ариун сүмийн ажил хийхэд оролцсоноороо агуу адислалуудыг хүлээн авах болно. Харин та *өөрийн* гэр бүлийн нэрсийг олж, дараа нь *өөг*

дээдсийнхээ төлөөх ажлыг ариун сүмд гүйцэтгэн, энэ хоёр ажлыг нэгтгэснээр эдгээр олон өнгийн хослол мэт агуу адислалуудыг бүрнээр нь хүлээн авах болно.

Арванхоёр Төлөөлөгчийн чуулгын ахлагч Ричард Г. Скотт:

“Ариун сүм болон гэр бүлийн түүхийн ажил бол нэг ажлын хоёр тал юм. . . .

Тэнгэр дэх Эцэг энэхүү орлон гүйцэтгэдэг амин чухал хоёр ажлын аль алианаас нь давхар адислал хүртэхийг биднээс хүсдэг. Тэрбээр бидэнд хэрхэн энэ бүхнийг хүлээн авч болохыг харуулахын тулд бусдыг удирдсан билээ. Эдгээр адислалуудыг хүртэх боломж та бидэнд бүгдэд нь байдаг.

“Ариун сүмд таны хийдэг ямар ч ажил цаг завьг тань дэмий гарзадна гэж байхгүй, харин өвөг дээдсийнхээ хэн нэгний төлөө орлон гүйцэтгэх ёслол хийлгэснээр ариун сүмд өнгөрүүлсэн цаг тань улам ариун болж, агуу адислалуудыг хүлээн авах боломжийг танд олгоно.”<sup>1</sup>

Ингэхлээр, биднийг “давхар адислалыг” хүлээж авахад ирдэг “агуу адислалуудын” зарим нь юу вэ? Баруун талд өнөө үеийн төлөөлөгчдийн хэд хэдэн амлаалт байна.

#### ЭШЛЭЛҮҮД

1. Ричард Г. Скотт, “Нарс барагсдын аврагч ирдэг баяр баясгалан,” *Лиакхона*, 2012 оны 11-р сар, 93–94-р хуудсууд.
2. Бонд К. Пакэр, “Your Family History: Getting Started,” *Лиакхона*, 2003 оны 8-р сар, 17-р хуудас.
3. Рассэлл М. Нэлсон, “Хайраар холбогдсон үеийнхэн,” *Лиакхона*, 2010 оны 5-р сар, 92-р хуудас.
4. Дэвид А. Бэднар, “The Time Is Now,” [lds.org/youth/family-history/leaders](http://lds.org/youth/family-history/leaders).
5. Жон А. Видцөү, Conference Report, 1943 оны 4-р сар, 39-р хуудас.



#### Сүнсний ариусгагч нөлөө

“Сүмийн гишүүдийн хийдэг гэр бүлийн түүхийн ажил нь энэ ажилд өөрсдийгөө зориулсан тэдгээр хүмүүсийг ариусгах, сүнсээр дүүргэх мөн тэднийг номхон дөлгөөн болгох нөлөөтэй. Энэхүү хэлхээ холбоо гэр бүлийг нь нэгтгэдгийг тэд ойлгодог. . . . Бид өөрсдийнхөө хийх ёстой судалгааг хийсэн үед зөвхөн нэрсийг биш харин чухал зүйлийг сонирхдог болно. . . . Бидний сонирхол зүрх сэтгэлээ эцгүүд рүүтээ эргүүлж— тэднийг олж мэдэн, тэдэнд үйлчлэх боломжийг бидэнд олгодог.”<sup>2</sup>



#### Агуу ажлын нэг хэсэг

“Сүнснүүдийн хооронд хэлхээ холбоо. . . бий болж байна. . . . Бидний зүрх сэтгэл өвөг дээдэс рүүтээ эргэсэн үед дотоод сэтгэлд минь өөрчлөлт гардаг. Бид өөрсдөөсөө илүү агуу ямар нэг зүйлийн нэг хэсэг болохоо мэдэрдэг билээ.”<sup>3</sup>



#### Уруу таталтын эсрэг хамгаалалт

“Бидний хүн нэг бүр өмнөх үеүдэд амьдарч байсан хүмүүсээс ашиг тустай зүйлүүд олсон байдаг. Эдгээр түүхүүдийг мэдэх нь бид хэн гэдгээ мөн хаанаас ирснээ ойлгоход бидэнд үнэхээр тусалдаг билээ. . . . Та өөрийнхөө гэр бүлд хайлт судалгаа хийж мөн гэр бүлийн түүхээ судлахад нь бусад хүмүүст тусалж байгаа юу? Энэ ажил нь өнөө үед бидний амьдарч байгаа ёс бус дэлхийд залуу хүн бүрийг Сатаны уруу таталтуудаас хамгаалах хамгийн агуу хамгаалалтуудын нэг юм.”<sup>4</sup>



#### Үл үзэгдэх ертөнцөөс ирэх тусламж

“Бид үл үзэгдэх ертөнц дэх хүмүүсийн төлөө хийх ёстой ажлаа хийвэл үл үзэгдэх ертөнц хариуд нь өнөөдөр бидний хойшлуулшгүй чухал хэрэгцээнд туслах болно. Тэд өөрсдийнх нь төлөө бидний хийж чадах ажлыг хүсэн, хүлээж, залбирч байдаг билээ. Нөгөө ертөнцөд энд дэлхийнхээс илүү олон хүмүүс байгаа бас тэнд энэ дэлхий дээр бидэнд байгаагаас илүү их хүч чадал байгаа шүү дээ.”<sup>5</sup>



## БИ НЭГ НЭР ОЛЛОО

**М**анай тойрог өсвөр үеийнхнийг ариун сүмийн аялалд бэлтгэхийн тулд ариун сүмд аваачиж болох гэр бүлийнхээ нэрсийг хайх үйл ажиллагааг мючелийн үйл ажиллагаатай нэгтгэсэн юм. Би найзуудынхаа хажууд сууж, ёслолууд хийгдэх шаардлагатай ямар ч нэрсийг олж чадаагүйдээ урамгүйхэн байлаа. Би маш их хайсны дараа familysearch.org-ээс нэг нэр олоод жигтэйхэн их баярлалаа!

“Би гэр бүлийн түүхийн зөвлөх рүүгээ шалавхан гүйж очоод дараагийн алхам юу болохыг асуув. Тэр уг нэрийг хэрхэн хадгалж, ариун сүмийн ажил хийхийн тулд хэрхэн хэвлэж авахыг надад үзүүлэв. Гэр бүлийн түүхийн зөвлөх мөн надад тэр нэр бол компьютерийн дэлгэцэн дээрх зүгээр нэг нэр биш, бодит хүн болохыг хэлсэн. Би Сүнс мэдэрч; тэр хүн өөрийг нь олж, түүний төлөө ариун сүмийн ажил хийгээсэй хэмээн надаас хүсэн хүлээж байсныг нь мэдсэн юм. Түүний нэрийг ариун сүмд авч очих боломж надад тохиосон билээ. Би өвөг дээдэстэй үйлчилж, сайн мэдээний баяр баяслыг тэдэнд авчрахад туслах боломжтой байсандаа туйлын баяртай байна.”

АНУ, Нью-Йорк, Лиан Г.,



## Хэрэв би интернетэд нэвтрэх боломжгүй бол яах вэ?

Хэдийгээр та гэр бүлийн түүхийн нэрсийг тэдний ариун сүмийн ажилд зориулан онлайн ариун явуулах хэрэгтэй ч заавал гэртээ интернеттэй байх шаардлагагүй. Амьд төрөл төрөгсдөөсөө нэрс, гэр бүлийн түүхүүд болон мэдээллийг нь цуглуулсны дараа өөрийн байдаг газартаа familysearch.org-д нэрсийг явуулж болох орон нутгийн гэр бүлийн түүхийн төв байдаг эсэхийг мэд. Интернетэд нэвтрэх нь хязгаарлагдмал газруудад таны олсон мэдээллийг интернетэд оруулах боломжийн талаар гадас болон тойргийн гэр бүлийн түүхийн зөвлөхүүдтэй ярилц.



## Хэрэв надад гэр бүлийн нэрс байхгүй бол би ариун сүм явж болохгүй гэсэн үг үү?

Үгүй, огт тийм биш! Ариун сүмд орох нь өмнөөс нь баптисм хүртэж, гишүүний баталгаа хийлгэсэн хүн өөрийн тань өвөг дээдэс мөн үү, биш үү гэдгээс үл хамааран танд болон түүнд аль алинд нь арвин их адислалуудыг авчирдаг. Танд гэр бүлийн нэр байхгүй байсан ч ариун сүмд орсоор байх ёстой. Тэргүүн Зөвлөл “Өөрийнхөө гэр бүлийн түүхийн судалгаа хийх хязгаарлагдмал боломжтой гишүүдийг бусад гишүүдийн бэлтгэсэн эсвэл ариун сүмд өөрт тань өгсөн нэрсээр орлон гүйцэтгэх ёслолууд хийхийг дэмжиж байна” гэж заажээ (Тэргүүн Зөвлөлийн захидал, 2012 оны 10-р сарын 8).



## ТЭРГҮҮН ЗӨВЛӨЛИЙН УРИЛГА

“Сүмийн гишүүд өвөг дээдсийнхээ нэрсийг олж, тэдгээр нэрсийг ёслолын ажлуудад зориулан ариун сүм рүү авч явах үед ариун сүмийн туршлага тань агуу ихээр баяжин, хөгжих болно. . . . Ялангуяа бид өсвөр үеийнхнийг . . . өөрсдийн гэр бүлийн эсвэл тойрог ба гадасныхаа гишүүдийн өвөг дээдсийн нэрсийг ариун сүмийн ажилд зориулан ашиглахыг урамшуулан дэмжиж байна.”

Тэргүүн Зөвлөлийн захидал, 2012 оны 10-р сарын 8



## ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ: ГЭР БҮЛИЙН ТҮҮХИЙН АДИСЛАЛУУД

Саяхан АНУ-ын Нью-Йорк хотын өсвөр үеийнхнийг гадасны ерөнхийлөгчийн зөвлөл нь өсвөр үеийнхний тусгай чуулганы хэсэг болгон ариун сүмд авч очих гэр бүлийн нэр олоход урьжээ. Тэдний зүрх сэтгэл эцгүүд рүүгээ эргэж байгааг мэдэрснээр тэд агуу адислалуудыг олж нээжээ (Малахи 4:5–6-г үзнэ үү).

### Гэр бүлийн нэрсээ ариун сүмд аваачих нь

- “Би өмнө нь гэр бүлийн түүх бол зүгээр л нэг хийх ёстой зүйл гэж боддог байсан бол одоо энэ нь олон жилийн туршид хүлээж байгаа бодит хүмүүс юм гэдгийг ойлгодог болсон. Би гэр бүлийнхнийхээ нэрсийг ариун сүмд аваачихад ариун сүмийн минь туршлага арай л өөр мэт санагддаг. *Ганцхан* нэр олоход л шаргуу ажил, цаг хугацаа мөн олон залбирал шаардагддаг учраас тэгж санагддаг байх. Гэвч *ганцхан* нэр гэдэг бол Тэнгэр дэх Эцэгтэйгээ хамт байх хэрэгтэй нэг хүн юм.” —Ханна А., нас 13
- “Чи нэг хүн олсон бол тэр хүнтэй сүнсний ертөнцөд холбоотой боллоо гэсэн үг. Өөрийнхөө олсон нэрсийг ариун сүмд аваачих нь энэхүү холбоог бэхжүүлэх нэг арга зам мөн. Энэ нь мөнхийн гэр бүлээ ойлгоход тань тусална.” —Спэнсэр С., нас 15
- “Гэр бүлийнхээ нэрсийг ариун сүмд аваачих нь эдгээр хүмүүс яг хэн байсныг

ойлгоход тань тусална. Тэд бол зүгээр нэг цаасан дээрх нэрс биш; тэд бол өөрийн тань түүхийн нэг хэсэг болох бодит хүмүүс—таны ах эгч нар юм.” —Лилли Н., нас 16

### Адислалууд хүлээн авах нь

- “Би амьдралдаа өөрчлөлт гарч байгааг ажигласан. Энэ бол ивээлтэй, дулаахан мэдрэмж юм.” —Ноа Р., нас 13
- “Чи өөрийгөө энэхүү агуу ажлын нэг хэсэг болсноо зүрх сэтгэлдээ мэдэрч чадна. Ариун сүмийн адислалуудыг хүлээн авах боломжийг гэр бүлдээ олгох нь юутай ч зүйрлэшгүй гайхалтай мэдрэмж юм.” —Кориннэ К., нас 17
- “Гэр бүлийн түүхээ хийж эхэлснээс хойш би илүү их тайтгарал болон амар амгаланг мэдэрдэг болсон. Гэр бүлийнхнийхээ нэрсийг ариун сүмд аваачих нь надад агуу баяр баяслыг авчирдаг.” —Тайлэр М., нас 16
- “Гэр бүлийн түүхийн ажил нь Аврагч, Тэнгэрлэг Эцэг болон өвөг дээдсээ

хайрлах миний хайрыг нэмэгдүүлсэн. Энэ нь үндсэн гэр бүлтэйгээ улам ойр дотно болж, сайн мэдээний тухай гэрчлэлээ нэмэгдүүлэхэд надад тусалсан.” —Александра Х., нас 14

- “Би илүү их аз жаргалтай байгаа.” —Росс С., нас 12
- “Би нэр олох бүрдээ тэр хүн зөвхөн намайг л хүлээж байсан юм шиг амар тайван болон сэтгэл догдлолыг мэдэрдэг.” —Рианнон Б., нас 15
- “Би хаанаас ирснээ болон итгэл минь хүчирхэгжиж байгаа гэдгээ мэднэ.” —Элиза Л., нас 13
- “Миний гэртээ үймүүлдэг минь багассан.” —Гэриг Л., нас 12
- “Би гэр бүлүүдийн ач холбогдлыг улам илүү ойлгодог болсон. Иймээс би энэ дэлхий дээр гэр бүлтэйгээ улам ойр байхыг хүсч байна.” —Эмма Л., нас 15
- “Бидэнд зориулсан Бурханы төлөвлөгөөг илүү сайн ойлгох нь надад тусалдаг. Би ёслолуудыг сайн ойлгодог учраас Тэнгэрлэг Эцэг болон сайн мэдээнд илүү ойр байгаагаа мэдэрдэг.” —Ноа К., нас 14 ■

### Та юу хийх вэ?

Гэр бүлийнхээ нэрсийг олж, ариун сүмд аваачихаас ирдэг “адислалуудыг олж авахын тулд” та юу хийх вэ? Эдгээр давхар адислалуудыг амьдралдаа хүлээн авах амлалтуудыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг өнөөдөр гарга.

# БИДНИЙ ОРОН ЗАЙ

## СҮНСЛЭГ НӨЛӨӨ БҮХИЙ СУДАР

“[Есүс Христ] бүх хүмүүний үрсийг өмгөөлөхийн учир, . . . мөн түүнд итгэх тэд аврагдах болно” (2 Нифай 2:9).

Энэ сударт *өмгөөлөх* гэдэг үг агуу чухал бөгөөд “аль нэг асуудлыг шийдэхэд нь хоёр талд туслахын тулд зуучлагч болж үйлчлэх” гэсэн утгатай юм. Энэ тохиолдолд Аврагч нь нүглийн улмаас Тэнгэрлэг Эцэгээс тусгаарлагдсан бүх хүмүүст тусалдаг зуучлагч юм.

Энэ судар бидний Аврагч, Есүс Христийн чухал болохыг мэдэхэд надад тусалсан юм. Би Түүний Цагаатгалд талархдаг. Бид зөвхөн Түүгээр дамжуулан Тэнгэр дэх Эцэгтэйгээ дахин хамт амьдарч чадна.

Энэтхэг, Ханиша А.,



## ХЭН ЗАЛБИРАХЫГ ХҮССЭН ГЭЭЧ?

**Х**амтрагч бид хоёр номлолд байхдаа нэлээн хэдэн хүүхэдтэй нэгэн гэр бүлд заадаг байлаа. Нэг удаа бид төлөвлөгөө хийх үеэрээ залбирч, хүүхдүүдэд нь дараагийн удаа юу заах вэ гэдгийг ярилцаад залбирлын тухай заая гэж хоёул санал нэгдлээ.

Бид тэднийд очиход эмээ нь ач, зээ нартайгаа хамт ихэд баярлаж, догдолсон байдалтай байв. Бид хичээлээ залбирлаар эхэллээ. Хүүхдүүд чимээгүй болж, сонсоход бэлэн болоход бид тэдэнд хэрхэн бас яагаад залбирах ёстойг тайлбарлалаа. Бид хичээлийнхээ төгсгөлд “Хэн хаалтын залбирал хийх вэ?” гэж тэднээс асуув. Тэд бүгдээрээ залбирахыг хүслээ! Тиймээс биднийг хичээл заахаар ирэх болгонд хэн хэн хэзээ залбирах тухай хуваарь хийсэн юм. Түүнчлэн биднийг байхгүй үед ч залбирч байхад тэднийг урилаа.

Тэр хичээлийн дараа “Насанд хүрсэн сонирхогчдод залбирах нь хэцүү байхад яагаад бага насны хүүхдэд залбирах нь хялбар байдаг юм бол?” хэмээн би бодож байж билээ. Би энэ асуултын хариуг Библийн толь бичгээс олсон юм: “Бид Бурханд (чухамдаа Бурхан бидний Эцэг, харин бид түүний хүүхдүүд) үнэн сэтгэлээсээ хандаж сурсан тэр даруйд залбирал нь жам ёсоороо буюу бидний талаас зөн совингийн шинжтэй болдог” (Матай 7:7–11). Залбирал хийх тал дээр гардаг олон хүндрэлтэй асуудал нь энэхүү харилцааг мартсанаас үүдэлтэй байдаг (мөн Судруудын удирдамж, “Залбирал” [scriptures.lds.org](http://scriptures.lds.org)-ыг үзнэ үү).

Би тэр үеэс хойш хүмүүст Тэнгэр дэх Эцэгтэйгээ харилцах жинхэнэ харилцаагаа ойлгоход нь туслахыг хичээдэг болсон. Дэлхийн эцэг эхчүүд маань бидэнтэй ярилцахыг хүсдэг шиг Тэнгэр дэх бидний Эцэг мөн хүүхдүүдтэйгээ ярилцахыг хүсдэг. Тэр бидэнд хайртай мөн бидэнтэй ярилцахыг хүсдэг бас биднийг Өөртэйгөө ярилцаасай хэмээн хүсдэг билээ.

Филиппин, Жаррэл М.,



## ГЭР БҮЛИЙН ТҮҮХ ГЭР БҮЛҮҮДИЙГ НЭГТГЭДЭГ

**Б**и Хувийн хөгжил дэвшлийн зорилго дээрээ ажилласан минь гэр бүлийн түүхээ хийж эхлэхэд намайг урамшуулсан юм. Би өвөө, эмээ хоёр дээрээ үдийн хоол идэхээр очих үед тэд надад өөрсдийн болон бусад төрөл садангуудынхаа амьдралын түүхээс ярьж өгдөг байлаа. Би гэр бүлийн түүхийн төвд очиж, гэр бүлийнхээ тухай мэдээ цуглуулж эхлэв.

Би элэнц эмэг эхийнхээ тухай мэдээллийг хэрхэн олсноо санадаг. Тэр жирэмсэн байхдаа усан онгоцоор Аргентинд иржээ. Завин дээр хүү нь төрсөн ч нас барсан учраас түүнийг далайд оршуулсан юм. Эмэг эхийнхээ нэрийг бүртгэлээс олох хүртэл эмээ минь зөвхөн түүх байлаа. Би өвөө, эмээ хоёртоо ойр байж, өвөг дээдсээ тэдэнтэй хамт амьдарч байсан юм шиг л мэддэг боллоо. Би өвөг дээдсийнхээ тухай мэдээлэл олж, мөнхийн лацдан холболтын баярт мэдээг хуваалцан, олон үеэ адислахад тусалсан билээ.

Би FamilySearch-ийн ачаар нуугдмал эрдэнэсийг нээн илрүүлсээр байна. “Бид өмнөө тулгарсан ажлыг дуусгахын төлөө чадах бүхнээ хийх тусам уйгагүй эрж хайсан эрдэнэсийг нээх шаардлагатай ариун түлхүүрийг Их Эзэн бидэнд өгөх болно гэдгийг би гэрчилж байна” хэмээн ерөнхийлөгч Томас С.Монсоны хэлсэн үгэнд би дуртай.<sup>1</sup> Бид хичээл зүтгэлээрээ дамжуулан өөрсдийн мөнхийн эрдэнэсийг нээх түлхүүрүүдийг олох болно, тэгээд нэгэн өдөр өвөг дээдэстэйгээ өөрийн биеэр уулзах болно.

Аргентин, Яаэл В.,

### ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “The Key of Faith,” *Ensign*, 1994 оны 2-р сар, 5-р хуудас; *Tambuli*, 1994 оны 5-р сар, 5-р хуудас.



## АРИУН СҮНСНЭЭС ГЭРЧЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ НЬ

**Б**и найман настайдаа сүмд элсэхдээ сүм үнэн гэдэгт аль хэдийнээ итгэдэг байсан, тиймээс сүм үнэн үү гэдгийг Бурханаас асуух шаардлагагүй байлаа. Харин гишүүн болоод хэдэн жил болсны дараа би эргэлзэж эхлэв. Ариун ёслолын цуглааны үеэр “Иосеф Смитийн анхны залбирал” (*Сүмийн дуулал*, болон хүүхдийн дуу, дугаар

14) дууллыг сонсоод би Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч, сүм үнэн үү, Иосеф Смит үнэхээр Түүнийг болон Есүс Христийг харсан уу гэдгийг асуусан юм. Миний оюун бодолд тийм ээ, Есүс Христийн сүм үнэн; тийм ээ, Иосеф Бурхан Эцэг, Есүс Христ хоёрыг харсан гэх хариу ирж, нүдэнд минь нулимс цийлгэнэн, Ариун Сүнс зүрх сэтгэлд минь шатаж буйг би мэдэрсэн.

Энэ сүм үнэн гэдгийг Ариун Сүнс надад гэрчилснийг би өнөөдөр баталж чадна. Иосеф Смит Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрыг харсан гэдгийг би мэднэ, би үүнийг үгүйсгэж чадахгүй. Гэрчлэлээ бусадтай хуваалцах зоригийг энэхүү гэрчлэл надад өгсөн юм. Бразил, Тамара О.,



# Hola! amigos!\*

## Бид бол Мексикийн Махонри, Хиламан хоёр

Цүнхэндээ юмаа хий!  
Дэлхий даяарх найз нар-  
тайгаа танилцана уу!

Махонри

Хиламан

Эми Жэйн Лийвигтэй хийсэн ярилцлагаас

**М**ахонри, Хиламан хоёр бол Мексикийн эрэгт амьдардаг ах дүү хоёр юм. Эцэг эх нь тэдэнд Мормоны Номын хоёр агуу эрийн нэрийг өгсөн ажээ. Махонри Морианкумер бол Жаредын ах юм. Тэр Их Эзэний хурууг харсан билээ. Ахмад Хиламан бол зөв шударга удирдагч байв. Тэрээр хоёр мянган залуу дайчныг тулалдаанд удирдсан билээ. ■

\* "Сайн уу, найзуудаа!" гэхийг испаниар.



Энэ ах дүү хоёр эцэг эхийнхээ өгсөн нэрэнд тохирохуйц амьдрахад найддаг ажээ. Тэд Мормоны Номын Махонри, Хиламан хоёртой яг адилхан байхыг хүсдэг гэнэ.





**БИ АРИУН СҮМ ХАРАХ ДУРТАЙ**



Мексикийн Гуадалахара ариун сүм бол Мексикийн 13 ариун сүмийн арваннэг дэх нь юм.



Манай аав, ээж хоёр 2003 онд Мексикийн Гуадалахара ариун сүмд лацдан холбогдсон. Энэ бол бидний амьдардаг газарт хамгийн ойрхон байдаг ариун сүм. Энэ ариун сүмд машинаар зургаан цаг явж хүрнэ. Бид ариун сүмд очих дуртай, тэгээд бид хэзээ нэгэн цагт аав, ээж шигээ ариун сүмд орох болно гэдгийг мэднэ.



**ЯВАХАД БЭЛЭН!**

Махонри, Хиламан хоёрын цүнх тэдний дуртай юмсаар дүүрэн байна. Чи эдгээр зүйлсийн алинаар нь цүнхээ дүүргэмээр байна?



Бид гэр бүлээрээ цагийг хамтдаа өнгөрүүлэх дуртай. Мөн хагас сайн өдөр бүр гэрийнхээ ойролцоох далайн эрэгт очих дуртай. Бид өөрсдийн дуртай хоол болох сам хорхой, тако болон тортас (хавчуургатай талхны нэг төрөл) иддэг. Бид Малекон руу эсвэл эрэг уруудан алхдаг. Бид элсээр цайз хийж, далайд тоглодог.





**Ахлагч  
Роберт Д.Хэйлс**

Арванхоёр  
Төлөөлөгчийн  
чуулга

*Арванхоёр Төлөө-  
лөгчийн чуулгын  
гишүүд бол Есүс  
Христийн онцгой  
гэрчүүд юм.*

# ХРИСТИЙН ШАШИНТАН байна ГЭДЭГ НЬ ЮУ ГЭСЭН ҮГ ВЭ?



Христийн шашинтан нь  
Их Эзэн Есүс Христэд  
итгэдэг.

Христийн шашинтан  
Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс  
Христ хоёрын ач ивээлээр  
дамжуулан бид наманчилж  
чадна гэдэгт итгэдэг.

Бид Есүс Христийг  
дагаснаарТэнгэрлэг  
Эцэгийн биднийг ямар хүмүүс  
байгаасай гэж хүсдэг шиг тийм  
хүмүүс болж чадна.

*Христийн  
шашинтан гэдэг нь*

Христийн нэрийг өөрсдөдөө  
авна гэсэн утгыг илэрхийлнэ. Бид  
баптисм хүртэж, Ариун Сүнсийг  
хүлээн авснаар Христийн нэрийг  
өөрсдөдөө авдаг билээ.



*“Христтэй илүү адил  
Христийн шашинтан байх  
нь,”* Лиахона, 2012 оны 11-р сар,  
90–92-р хуудсуудаас авав.



Өнөөдрийн огноо

Төрсөн огноо

Яс үндэс

Нэр

Паспортын  
Аугаар

ЗУРАГ



ДЭЛХИЙ ДАВАРХ  
НАЙЗУУД

Passport  
Паспорт  
Паспорте




Итали



Шинэ Зеланд



Филиппин




Зимбабве




Орос




Мексик



Бразил



Тонга



Өмнөд Солонгос



Чили



Англи



Швед

# Паспорт

ДЭЛХИЙ ДАВАРХ НАЙЗУУД



Энэ жил паспорт дээрээ шинээр нэмэх нэг орны маркийг *Лиахона*-гийн дараагийн дугааруудаас олоорой!



# ДЭЛХИЙ ДАЯАРХ НАЙЗУУД



Hello!

iHola!

안녕

ПРИВЕТ!

Mhoroi!

Olá!

Mālō e  
lelei!

Ciao!

Hej!



# БИДНИЙ ХУУДАС



Аав, ээж хоёр намайг бага байхаас минь эхлэн надад ариун сүмийн тухай заасаар ирсэн. Ариун сүм хол байсан ч би гэр

бүлтэйгээ хамт тийшээ явах дуртай. Би аав, ээж хоёртойгоо лацдан холбогдох үеэрээ ариун сүмд орж үзсэн. Үнэхээр гайхалтай байсан. Одоо бид ариун сүмд очих үед би гадаа нь үлдэж, хүлээдэг. Би том болохоороо ариун сүмд өөрийн гэрээнүүдийг хийнэ.

**Никарагуа, Дэвид В., нас 6**



Би сүмийн дууллаудыг дуулах үнэхээр дуртай бас гэрийнхэнтэйгээ хамт гэр бүлийн үдэшт оролцох дуртай. Би Жарэд, Сарай гэдэг хоёр дүүтэй, тэдэндээ маш их хайртай. Би ээжийгээ хоол хийхэд нь туслах дуртай. Яагаад гэвэл би том болохоороо ээж шигээ сайхан хоол хийдэг байхыг хүсч байна.

**Эквадор, Амбар А., нас 9**

Есүс Христ амьд бөгөөд бид бүгдийн төлөө анхаарал тавьдгийг мөн сүм үнэн гэдгийг би мэднэ.

**Бразил, Осирис М., нас 6**




**Бразил, Трис М., нас 8**



Би гэр бүлийн үдэш хийхэд ээждээ туслах дуртай. Манай гэр бүл ариун сүм явахыг хүсдэг, тэгснээрээ бид үүрд хамт байж чадна. Би том болохоороо үеэлүүдтэйгээ адилхан номлолд үйлчлэхийг хүсч байна. Би Тэнгэрлэг Эцэг болон бошиглогч, ерөнхийлөгч Томас С.Монсонд хайртай. Би "Есүс Христийн сүм" гэдэг Хүүхдийн хэсгийн дуунд дуртай.

**Гондурас, Кэйди П., нас 12**



**Камбож, Д.Ван Хийп, нас 11**



Би бүр багаасаа л сайн мэдээг заалгасан. Тэгээд наймтайдаа баптисм хүртэхээр шийдсэн юм. Би тэр онцгой өдөрт зориулан Итгэлийн 13 тунхгийг бүгдийг нь чээжилсэн. Би уснаас гарч ирэхдээ их хүчтэй ямар нэгэн зүйлийг мэдэрсэн. Ийм мэдрэмжүүд Ариун Сүнснээс ирдэг гэж ээж надад хэлсэн. Иосеф Смит Есүс Христийн сүмийг сэргээсэн, Мормоны Ном үнэн, Томас С.Монсон бол амьд бошиглогч гэдгийг би мэднэ.

**Испани, Абигэйл А., нас 8**

# Яг л судрууд шиг!

*Бид замын тэмдэг олж харах хүртэл явган аялал маань маш сайхан болж байна гэж бодож байлаа.*



**Рэнэ Вэйт Маккли**

Бодит түүхээс сэдэвлэв

*“Та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг . . . би түүнчлэн хөнгөлнө” (Мозай 24:14).*

**А**рван настай хүүхдүүд яггүй ухаалаг сэргэлэн байдаг. Бид юмсыг өөрийнхөөрөө бодох дуртай.

Аав минь надад судруудыг өөртэйгээ адилтга гэж байнга хэлдэг. *Адилтгах* гэдэг нь судраас сурч мэдсэн зүйлээ амьдралдаа хэрэгжүүлэхийг хичээх гэсэн утгатай юм. Иймээс бид гэр бүлээрээ хамт уншиж байгаа үед

аав бидэнд ямар нэг зүйлийг тайлбарлахаас нь өмнө би заримдаа тэсэлгүй хэлчихдэг байж билээ. Жишээ нь: Нэг удаа би “Аав аа, бид судруудад өгүүлдэг шиг мацаг барьж, залбирах хэрэгтэйг би мэднэ” гэлээ.

Би зөв захиасыг нь байнга



“Судруудыг илүү их зорилготой . . . илүү их анхаарлаа төвлөрүүлэн уншихад өөрсдийгөө дайчилцгаая.”

Тэргүүн Зөвлөлийн хоёрдугаар зөвлөх, ерөнхийлөгч Дийтр Ф.Угдорф, “Та нарын чадавх, та нарын онцгой боломж” *Лиэхона*, 2011 оны 5-р сар, 59-р хуудас.

ойлгочихдог байсан учраас аав инээмсэглэдэг байв.

Гэвч би нэгэн удаа судрууд олон талаараа миний амьдралтай үнэхээр адилхан болохыг мэдсэн. Бид гэр бүлийнхнийхээ уулзалтаар явган аялалд явж байхад энэ явдал болсон юм.

Би өөрийнхөө том үүргэвчийг аяны хөнжилтэй хамт үүрч явахдаа гомдоллосонгүй. Эцэстээ нуур хүртэл ердөө 6.5 км үдлээ хэмээн бид бодож байв. Би энэ замыг ямар ч асуудалгүйгээр туулж чадах байлаа.

Явган аялал надад хэцүү байгаагүй ч 3 км явсны дараа амрахаар түр буудалласанд би баяртай байв. Бид тэр үед л замын тэмдгийг анх харсан юм. Гэтэл тэр замын тэмдэгт нуур хүртэл 9.5 км гэж заасан байв. Явган аялалд бидний анх бодож байснаас хоёр дахин хол газрыг туулах ёстой болсныг аав надад хэлэх шаардлага байсангүй.

Би үүнийг аль хэдийн бодоод олчихсон байлаа. Харин аав бидэнд усаа хэмнэж уух *хэрэгтэй* гэж хэлэв.

Аавын зөвлөгөө чухал байсан ч дагахад хэцүү байлаа. Үдээс хойш нар халуу шатаж, аяны замд

бид сүүдэрт нь орчих юу ч байсангүй. Бид нууранд хэзээ ч хүрч чадахгүй юм шиг санагдах болов.

Том хүмүүс хүүхдүүдийн ард хоцорч, бусад үеэл ах, эгч нар цувааны өмнө түрүүлэн явж байлаа. Би өөрийн үе тэнгийн гурван үеэлийнхээ хамт цувааны дунд явж байгаад зогсож, хартал

бидний өмнө ч, ард ч хэн ч харагдсангүй тул бид сандарч эхэллээ. Үүргэвчүүд маань хүнд санагдаж, усны лонхнууд хоосорчээ. Бид цаашаа хэр хол явах хэрэгтэй бол?

Эцэстээ ихэд ядарч, сандарч байсан болохоор бид зогсож, залбирахаар шийдэв.

Бид залбирсныхаа дараа үүргэвчээ үүрч, цааш алхлаа.

Тэгтэл удсан ч үгүй зам дээр морин төвөргөөн ойртон ирэхийг бид сонслоо. Нэг морьтой хүн биднийг чиглэн давхиж байх нь харагдав.

Тэр хүн зогсож, бидэнд ус өглөө. Манай үеэл ах, эгч нар нууранд түрүүлэн очиж, ус шүүгчээр ус аваад бидэнд явуулсныг тэр тайлбарлав. Тэр хүн бидэнд ус хэчнээн их хэрэгтэйг сонсоод туслахаар зөвшөөрсөн гэнэ. “Үүргэвчээ надаар дайлгах хүн байна уу?” гэж тэр асуув.

Намайг үеэлүүд рүүгээ харахад тэд над руу харж, инээмсэглэв. Бидэнд үнэхээр сайхан байлаа!

Бид тэр хүнд “Та цааш явж,

бусад хүмүүст тусал даа,” “Бид дажгүй ээ” гэж хэллээ.

Үнэхээр тийм байсан шүү! Нуур хүртэлх үлдсэн замд чухамдаа бидний үүрсэн ачааг тэнгэр элчүүд өргөж, бидний араас түрэх шиг санагдаж билээ. Хожим нь намайг энэ тухай аав, ээж хоёрт ярихад аав баяртай нь аргагүй инээмсэглэсэн бол ээжийн нүдэнд нулимс цийлэгнэчихсэн байж билээ.

Долоо хоногийн дараа манай гэрийнхэн Мозая 24-р бүлгийг уншив. “Мөн та нарын мөрөн дээр тавигдах ачаануудыг, бүр тэдгээрийг нуруун дээрээ байгааг ч мэдрэхгүй болтол . . . би түүнчлэн хөнгөлнө” (14-р шүлэг) гэсэн үгсийг бид унших үед би нүдээ бүлтийтэл гайхаж билээ.

“Явган аялалын замд ийм явдал болсон юм даа” хэмээн би дуу алдсан юм. Энэ судрыг амьдралдаа хэрхэн ашиглах талаар бодох хэрэг надад байсангүй. Энэ судар миний амьдралыг аль хэдийн дүрсэлсэн байсан юм! Энэ нь үнэхээр гайхалтай байсан шүү! Миний амьдралыг ийнхүү дүрсэлсэн өөр судруудыг олохоор би тэсэж ядан байлаа.

Тийнхүү би судруудыг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг сурсан төдийгүй, өөрийн амьдралыг судраас уншсан зүйлтэйгээ харьцуулж чаддаг болсон юм! ■

*Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.*



# НОА

Хуучин Гэрээний бошиглогч байсан. Тэр зарлигуудыг сахидаг байсан бөгөөд Бурханы үгийг сонссоноор үерээс аврагдахад нь гэр бүлдээ тусалжээ. Энэ жил долоо хоног бүр Хуучин Гэрээнээс уншсанаар чи зарлигуудыг сахиж чадах бөгөөд гэр бүлдээ ч тусалж чадна.

Энэхүү будах хуудсыг хайчилж авах буюу [iaihona.lds.org](http://iaihona.lds.org)-аас хэвлэж авахад насанд хүрсэн хэн нэгнээр туслуул. Долоо хоног бүр уншсаныхаа дараа долоо хоногийн дугаар бүхий зайнуудыг хамгийн тохиромжтой гэж бодсон өнгөрөө буд. Долоо хоног бүрээр унших зөвлөмжийг 76-р хуудаснаас үзнэ үү. Чи ганцаараа эсвэл гэрийнхэнтэйгээ хамт уншиж болно. Ингэснээр, чи Хуучин Гэрээний хамгийн чухал зарим түүхүүдийг уншсан байх болно. ■

ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ АДАМ КОБОРД





28

5

29

41

25

24

26

18

52

9

15

10

14

12

23

51

13

48

32

22

30

31

50

43

42

49

18

36

47

7

20

6

33

17

20

46

13

45

22

2

51

16

23

14

24

15

34

2

“Хуучин Гэрээний судруудыг судлах уриалга”-ын долоо хоног бүр унших зөвлөмж (74–75-р хуудсуудыг үзнэ үү).

ДОЛОО ХОНОГ	УНШИХ СУДРУУД	ДОЛОО ХОНОГ	УНШИХ СУДРУУД
1	<b>Авралын төлөвлөгөө:</b> Моше 1:39; Абрахам 3:12, 22–28; 4:1	27	<b>Самсон, Делила хоёр:</b> Шүүгчид 13:1–5, 24; 16:2–23, 28–30
2	<b>Бүтээлт:</b> Эхлэл 1; 2:1–3	28	<b>Рут, Наоми хоёр:</b> Рут 1:1–9, 14–16; 2:1–8, 15–18; 3:1, 3–11; 4:13, 17; Иохан 7:42
3	<b>Адам, Ева хоёр:</b> Эхлэл 2:7–9, 15–25	29	<b>Бошиглогч хөвгүүн Самуел:</b> 1 Самуел 1:9–11, 17–20, 24–28; 2:26; 3:1–11, 16–20
4	<b>Уналт:</b> Эхлэл 3	30	<b>Давид ба Голиат:</b> 1 Самуел 16:7; 17:1, 4–24, 32–33, 37–51
5	<b>Каин, Абел хоёр:</b> Эхлэл 4:1–16	31	<b>Давид ба Ионатан:</b> 1 Самуел 18:1–9; 19:1–10; 23:14–18; 24:9–10, 16–19; 2 Самуел 1:4, 11–12
6	<b>Енохын хот:</b> Моше 6:21, 26–28; 7:13–21	32	<b>Давид ба Батшеба:</b> 2 Самуел 11:1–4, 14–17, 26–27; 12:1–7, 9, 13
7	<b>Ноагийн хөвөгч авдар:</b> Эхлэл 6:5, 7–9, 13–22; 7:1–19, 23–24	33	<b>Соломон хаан:</b> Хаадын дээд 2:1–4, 12; 3:3–28; 6:1
8	<b>Ноагийн гэр бүл аврагдав:</b> Эхлэл 8:6–13, 15–17	34	<b>Рехобоам:</b> Хаадын дээд 11:43; 12:1–21
9	<b>Бабелын цамхаг:</b> Эхлэл 11:1–9; Ифер 1:1–3, 33–43	35	<b>Бошиглогч Елиа:</b> Хаадын дээд 17; 19:11–12
10	<b>Абрахамын гэрээ:</b> Абрахам 1:1–4; 2:6–13; Эхлэл 17:1–7	36	<b>Елиа ба Баалын хуурамч эш үзүүлэгчид:</b> Хаадын дээд 18:16–18, 21–39
11	<b>Абрахам, Лот хоёр:</b> Эхлэл 13:1–13; 19:1, 15–17, 24–29	37	<b>Нааман эдгэрэв:</b> Хаадын дэд 5
12	<b>Абрахам, Исаак хоёр:</b> Эхлэл 22:1–18	38	<b>Елиша ба бэлэвсэн эмэгтэй:</b> Хаадын дэд 4:1–6
13	<b>Исаак, Ребека хоёр:</b> Эхлэл 24:1–4, 7–20, 61–67	39	<b>Исаиа ба Хезекиа:</b> Хаадын дэд 18:1–7; Исаиа 36:1–2, 4, 13–15; 37:1–7, 15–21, 33–38; 38:1–7
14	<b>Иаков, Есав хоёр:</b> Эхлэл 25:21–34; 27:1–23	40	<b>Исаиагийн бошиглолууд:</b> Исаиа 1:17–19; 2:2–4; 11:6–10; 53:3–5; 55:8–9; 58:6–14
15	<b>Иаков, Рахел хоёр:</b> Эхлэл 29:1–2, 10–30	41	<b>Иошуа, Езра хоёр судруудыг уншиж байна:</b> Хаадын дэд 22:1–4, 8–13; 23:1–4, 24–25; Нехемиа 8:1–8
16	<b>Иаков Израйл болсон нь; Иосеф Египетэд худалдагдсан нь:</b> Эхлэл 35:9–12; 37:3–14, 18–34	42	<b>Дуулал ба Сургаалт үгс:</b> Дуулал 1:1–3; 19:1–3; 24:1–4; Сургаалт үгс 3:5–6
17	<b>Иосеф Египетэд:</b> Эхлэл 39:1–4, 7–20; 40:1–3, 5–8; 41:1, 8–12, 14, 29–36, 39–40	43	<b>Естер:</b> Естер 2:5–9, 17; 3:2–13; 4; 5:1–8; 7; 8:3–11, 17
18	<b>Иосеф уучилсан нь:</b> Эхлэл 42:3–16; 43:15; 44:1–12, 18, 33–34; 45:3–8	44	<b>Иов:</b> Иов 1; 19:13–26; 27:2–6; 42:10
19	<b>Мосегийн төрөлт ба дуудлага:</b> Египетээс гарсан нь 1:8–14, 22; 2:1–6, 10–21; 3:1–14, 19–20; 4:10–12	45	<b>Иеремиа:</b> Иеремиа 1:1, 4–9; 18:1–6; Исаиа 64:8
20	<b>Өвчин тахал:</b> Египетээс гарсан нь 7:10–14, 20–21; 8:6, 17, 24; 9:6, 10, 23; 10:14–15, 22; 11:5; 12:30–32, 41–42	46	<b>Соломоны ариун сүм:</b> Шастирын дээд 28:20; 29:6–9; Шастирын дэд 5:1; 6:1–3
21	<b>Египетээс гарсан нь:</b> Египетээс гарсан нь 14:5–16, 19–31	47	<b>Даниел ба хааны зоог:</b> Даниел 1:1, 3–20
22	<b>Израйлчууд тэнгэрээс маннаг хүлээн авсан нь:</b> Египетээс гарсан нь 16:1–8, 21–31, 35	48	<b>Шадрах, Мешах, Абеднего гурав:</b> Даниел 3:1, 4–30
23	<b>Арван зарлиг; гуулин могой:</b> Египетээс гарсан нь 19:1–5, 20; 20:1–17; 31:18; Тооллого 21: 4–9	49	<b>Даниел ба арслангууд:</b> Даниел 6
24	<b>Зелофехадын охид:</b> Тооллого 27:1–7	50	<b>Иона ба халим загас:</b> Иона 1; 2; 3:1–5
25	<b>Иошуа ба Иерихогийн тулалдаан:</b> Иошуа 1:1–11, 16–17; 2:1–6, 14; 3:5–9, 13–17; 6:1–5, 13–16, 20, 23; 24:14–18	51	<b>Нэмэлт судрууд:</b> Амос 3:7; Нахум 1:7; Хабаккук 3:19; Зефаниа 3:16–20
26	<b>Гидеон:</b> Шүүгчид 6:6–16; 7:1–7, 16–22; 8: 22–23	52	<b>Малахи:</b> Малахи 3:8–12; Малахи 4:5–6



**Рөүзмэри М.Виксом**  
Хүүхдийн хэсгийн ерөнхий  
ерөнхийлөгч

# Ялалтын хаалга

*“Бурханы маань төлөвлөгөө  
хэчнээн агуу билээ”  
(2 Нифай 9:13).*

**Н**эгэн хавар нөхөр бид хоёр дөрвөн настай ач хүүгийнхээ хөл бөмбөгийн тэмцээнд очлоо. Хүүхдүүд бөмбөгний араас тал бүр тийшээ гүйдэх нь хэчнээн өхөөрдмөөр хөөрхөн гээч. Сүүлчийн шүтэл дуугарахад тоглогчдын хэн нь хожсоныг эсвэл хэн нь хожигдсоныг ч мэдсэнгүй. Тэд зүгээр л тоглодог байлаа.

Дасгалжуулагч нь тоглогчдоос нөгөө багийнхаа гишүүдтэй гар барихыг хүслээ. Дараа нь бид тэнд нэлээд сонин нэг зүйлийг харж билээ. Тэдний дасгалжуулагч ялалтын хаалга хэмээн ориллоо.

Аав, ээж, өвөө, эмээ нар түүнчлэн хүүхдүүдийн

тоглолтыг үзэхээр ирсэн хүн бүхэн өөд өөдөөсөө харан, хоёр эгнээ болж, зогслоо. Тэгээд тэд гараа өргөж, нийлүүлэхэд нэгэн нуман хаалга бий болов. Хүүхдүүдэд баяр хүргэхээр эгнэн зогссон хүмүүсийн гар доогуур хүүхдүүд шуугилдан, гүйж байлаа.

Удалгүй нөгөө багийн хүүхдүүд тэдэнтэй нийлж, бөөн баяр хөөр

болов. Ялалтын хаалгаар гүйдэхдээ бүх тоглогчид хүмүүсийн уухайн дунд баярлан, хөөрч байлаа.

Би дотроо өөр нэг дүр зургийг төсөөлөн бодсон юм. Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд бүрийн төлөө бүтээсэн төлөвлөгөөний дагуу эдгээр хүүхдүүд амьдарч байгааг харж буй мэт мэдрэмж надад төрж билээ. Тэд өөрсдийг нь хайрладаг хүмүүсийн гар доогуур нарийн бөгөөд шулуун замаар гүйж байлаа. Хүүхэд бүр тэр зам дээр баяртай байлаа.

Есүс Христ бидний хүн нэг бүрд зориулж, “замыг тэмдэглэсэн бөгөөд тэр замаар биднийг удирдаг” билээ.<sup>1</sup> Хэрэв бид Тэнгэрлэг Эцэгийнхээ удирдлагыг дагавал бид бүгд тэнгэр дэх гэртээ буцаж очин, Түүний тэвэрт аюулгүй байх болно. ■

**ЭШЛЭЛ**

1. “Мэргэн ухаан ба хайр хэчнээн агуу билээ,” *Нуннс*, дугаар 195.



Хүүхдийн хэсгийн энэ сарын урианаас илүү ихийг сурч мэдэгтүн!

# Тэнгэрлэг Эцэг Өөрт нь эргэж очих замыг надад бэлтгэсэн

Бид бүгд энэ дэлхийд ирэхээсээ өмнө Бурхан Эцэг болон Түүний Хүү Есүс Христтэй хамт тэнгэрт амьдарч байсан юм.

Тэнгэрлэг Эцэг бидэнд зориулан Өөрийн төлөвлөгөөг танилцуулсан билээ. Бид Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг дагахаар сонгож, дэлхий дээр ирсэн билээ.

Тэнгэрлэг Эцэг бидэнд хайртай бөгөөд биднийг Өөртөө эргэж ирээсэй гэж хүсдэг. Тэрбээр бидэнд замыг үзүүлж, Өөрт нь эргэж очиход бидэнд туслахын тулд Өөрийн Хүү Есүс Христыг илгээсэн юм.



Биднийг Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очиход Тэр биднийг гараа дэлгэн, тэвэрч угтана!



Мөн итгэлээр амьдарснаар.

Бид дараах зүйлсийг хийснээр Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очих замыг дагана:



баптисм хүртэж, гишүүнээр батлуулснаар,



ариун сүмийн гэрээнүүдийг хийснээр,



ариун ёслолоос хүртэж,







Энэ бол би!

## НАДАД ЗОРИУЛ- САН НЭГЭН ЗАМ

Тэнгэрлэг Эцэгтээ эргэж очих өөрийн замыг харуулсан зурагт хуудас хий. Цаас юм уу самбар дээр уг замыг зур. Жижигхэн зургуудыг хайчилж, замын дагууд цавуу эсвэл наадаг туузаар наа. Баптисм гэх мэт чухал үйл явдлуудын дэргэд өөрийнхөө гэрэл зургийг эсвэл өөрийгөө зурсан зургуудыг нэм. Шаардлагатай зүйлс:

Цаас эсвэл самбар

Хайч

Цавуу эсвэл наадаг тууз

Будгийн харандаанууд, самбарын

үзэг эсвэл харандаанууд

## ДУУ БА СУДАР


- “Тэр Хүүгээ илгээсэн”  
(*Children’s Songbook*, 34–35-р хуудас)
- Иохан 3:16

## ГЭР БҮЛЭЭ- РЭЭ ЯРИЛЦАХ САНААНУУД

Энэхүү захиас нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөг маш энгийнээр тайлбарлаж байгаа. Та үзүүлэнгүүд ашиглан гэр бүлийнхээ гишүүдээр авралын төлөвлөгөөний өөр өөр талуудыг ээлжлэн тайлбарлуулж болно. Үүний дараа та нар Тэнгэрлэг Эцэг рүү хөтөлдөг зам дээр байхын тулд бие биедээ хэрхэн тусалж болох талаар хамтдаа ярилцаж болно.




Мөнх бус байдлын  
өмнөх амьдрал



Бурханы бүрэн хуяг  
дуулгыг өмс




Ариун Сүнсний  
бэлэг хүлээн ав



Зарлигуудыг сахь



Миний баптисмын  
өдөр



Зөв зүйлийн төлөө  
тууштай зогс



Би Есүс Христийг  
дагах болно



Би хэзээ нэгэн цагт  
дотор нь орж үзнэ




Би Тэнгэрлэг Эцэгтээ  
эргэж очно!



Мормоны Ном



Миний ирээдүйн  
гэр бүл



Амилалт

# ТЭР НАМАЙГ ХАРАХ БОЛОВ УУ?

Тэрэза Старр

Энэ бол манай хүү Даниэл хүүхдийн цэцэрлэгтээ явахын өмнө, анхны өдрийнх нь өглөө бөгөөд цэцэрлэгтээ явахаар гэрээс гарахдаа асуух хэдэн зүйл түүнд байжээ. “Бодит дэлхий” дэх сорилтуудтай тулгарахаар тэр өөрийгөө бэлтгэгдсэн гэж бодож байгааг нь би мэдэхийг хүслээ. Даниэлийг эзгүйд түүнийг маш их санана даа гэж би түүнд хэллээ. Би хэдийгээр түүнтэй хамт сургуульд явж чадахгүй ч гэсэн тэнгэр дэх Эцэг түүнийг үргэлж харж хандах учраас хэзээ ч айж, ганцаардахгүй гэдгийг мөн хэлэв. Бурхан түүнийг үргэлж сонсож байдаг учир тэр хэзээ ч, хаана ч залбирч болно гэдгийг би түүнд сануулсан юм.

Дөнгөж тавхан настай Даниэл миний үгийг маш анхааралтай сонсож байлаа. Тэр хэсэг бодсоноо “Тэртээ байхад маань ч бас Тэр намайг харж чадах юм уу?” гэж асуув.


“Тийм ээ, чадна” гэж би хэллээ.

“Тэр намайг гадаа байхад харах болов уу? гэж тэр асуулаа.

“Тийм ээ, Тэр чамайг үргэлж харж байдаг” гэж би хариулсан.

Даниэл сэтгэл нь догдолж, намайг харснаа арын хашаа руу гүйгээд явчихав. Би түүний араас ойрхон дагаж явлаа. Даниэл дээшээ, үүлгүй цэнхэр тэнгэрийг хараад, “Хэрэв би тэнгэр өөд хараад инээмсэглэвэл Бурхан над руу мөн инээмсэглэх болов уу?” гэж асуув.

Түүний үг миний сэтгэлийг ихэд



*Даниэл хашаанд гүйн орж ирээд “Хэрэв би тэнгэр өөд хараад инээмсэглэвэл Бурхан надад хариу инээмсэглэх болов уу?” гэж надаас асуулаа.*

догдуулсан учир би үг ч дуугарч чадсангүй, “Тийм ээ” хэмээн толгой дохилоо.

Даниэл хүүхдийн гэнэн цагаан итгэл, сонинучхан харцаар тэнгэр өөд ширтсэн хэвээрээ гүн бодлогошрон, “Би Түүнийг харж чадах болов уу?” гэсэн юм.


“Чи Түүнийг харж чадахгүй байж болно, гэвч чи Түүний инээмсэглэхийг зүрх сэтгэлээрээ мэдрэх учраас Бурхан тэнд байдгийг мэдэх болно” гэж би хариулсан билээ.

Даниэл инээмсэглэн, тэнгэр ширтсээр зогслоо. Тэрхүү гэгээн инээмсэглэлийг зүрх сэтгэлийнхээ гүнд мэдэрч байгааг нь тэнгэр элч мэт түүний амар амгалан нүүрнээс би харж байлаа.

Бид бяцхан хүүхдийн үгээс цэвэр итгэл— тэдний үүрд үнэнч байна хэмээн бидний найдах тэрхүү итгэлийг сурдаг. Амьдрал сайхан ч заримдаа хэцүү байдгийг тэд гарцаагүй ойлгох болно. Итгэл нь хүнд хэцүү үеийг даван туулахад нь тэдэнд туслахын төлөө бид залбирдаг билээ.

Миний амьдралд хүнд үе тохиолдоход би Даниэлын жишээг санаж, насанд хүрсэн хүний зөвхөн дотоод сэтгэлд байж болох хүүхдийн гэнэн цагаан итгэлээр тэнгэр өөд ширтэн, “Тэр намайг харах болов уу?” гэж асуудаг. Тэгээд би Даниэл шиг “Би Түүнийг харж чадах болов уу?” хэмээн чимээгүйхэн тунгаан боддог. Би өөрийнхөө амьдрал дахь Тэнгэрлэг Эцэгийн үй олон нигүүлслийг санах үедээ Түүний хайрыг үнэхээрийн их мэдэрснийг Ариун Сүнс надад баталдаг билээ. Итгэл минь шинэчлэгдэж, найдвараар хөтлөгдөхөд миний бие Тэнгэрлэг Эцэгийн хайрыг байнга мэдэрч чадна хэмээн Ариун Сүнс надад баталж байдаг юм. ■

*Энэхүү өгүүллийн зохиогч АНУ-ын Ютад амьдардаг.*



## ХАРОЛД Б.ЛИЙ

Харолд Б.Лий бүр багаасаа Сүнсийг танин мэдэж сурчээ. Нэг өдөр түүнийг нурах шахсан хуучин саравч руу явж байтал нэгэн дуу хоолой нэрээр нь дуудан, тийшээ бүү оч гэжээ. Харолд дуулгавартай дагав. **Тэрээр сүмийн халамжийн хөтөлбөрийг тэргүүлж байхдаа дагадаг байсан шигээ Сүнсийг үргэлж дагадаг байжээ.** Тэр бас амьдралдаа Сүнсийг танин мэдэхэд нь гишүүдэд туслах **суралцах материалуудыг** хэвлэн гаргадаг байсан сүмийн албыг тэргүүлдэг байлаа.

# Энэ дугаарт

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

42



### Тэвчээртэй ДАВАН ТУУЛАХ НЬ

Бид үргэлж итгэлтэй байх болно гэж Их Эзэнд амласнаараа бид хүнд сорилтуудаас зайлсхийж чадна хэмээн бодох ёсгүй. Харин үүний оронд хүнд сорилтуудыг тэвчээртэй даван туулахаар төлөвлөх хэрэгтэй, тэгвэл бид адислагдах болно.

## ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

### ДАВХАР АДИСЛАЛ




Гэр бүлийн түүхийн ажлыг хийн, өвөг дээдсийнхээ нэрсийг ариун сүмд аваачсанаас ямар адислалууд ирдэг вэ? АНУ-ын Нью-Йорк хотын өсвөр үеийнхэн өөрсдийн туршлагыг хуваалцаж байна.

60

## ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

69



### Паспорт

Энэ жил паспортан дээрээ нэмэх улс орнуудын маркийг *Лиахона*-аас олоорой!

ЕСҮС ХРИСТИЙН  
ХОЖМЫН ҮЕЙН  
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ